

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Зүүн хойд Азийн хаанчлалд  
Монгол Улс

Занарын эрин эхэлчихэж

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 08 сар. №14, 25 (024, 025)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)



## ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТООС ХӨГЖИЛ ДЭВШИЛ ӨӨД ХАМТДАА



Оюу Толгой ХХК  
Улаанбаатар - 14240  
Сүхбаатар дүүрэг  
Чингисийн өргөн чөлөө - 15  
Моннис цамхаг  
Утас: +976-11-331880  
(дотуур утас 3800, 3801)  
Факс: +976-11-331890  
И-мэйл: OTLLCinfo@ot.mn

ДЭЛХИЙД ТЭРГҮҮЛЭГЧ  
МОНГОЛЫН УУЛ  
УУРХАЙН КОМПАНИ



# ОЮУ ТОЛГОЙ – ТА БИДНИЙ БАХАРХАЛ

Рио Тинто болон Монгол улсын Засгийн газрын хамтран бүтээн байгуулж буй Оюу Толгой төсөл нь дэлхийн хамгийн том зэс, алтны уурхайн нэг болон хөгжиж байна.

Оюу Толгой төсөл нь Монгол улсын гэрэлт ирээдүйг цогцлоон бүтээх алсын хараатай ажиллаж, Монгол улсын эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд бодит хувь нэмрээ оруулан

бүтээн байгуулалтын үйл ажиллагаагаа өрнүүлж байна.

Монголын ирээдүйн шинэ хөгжлийг манлайлагч Оюу Толгой төслийг бүтээн байгуулахад мянга мянган Монгол залуус гар бие оролцож, олон зуун Монгол компани, ханган нийлүүлэгчид хувь нэмрээ оруулж, эх орныхоо ирээдүй, хойч үедээ үлдээх бахархал, түүхийн эхний хуудсыг бичилцэж байна.

Монгол улсын түүхэн дэх хамгийн том бүтээн байгуулалт Оюу Толгой төслийг барьж байгуулах эхний үе шатанд буюу 2013 он хүртэл нийт 7,8 их наяд төгрөгийн (6 тэрбум ам.доллар) хөрөнгө оруулалт хийх юм. Энэ хугацаанд Монгол улсын Засгийн газарт 900 гаруй тэрбум төгрөгийн (700 сая ам.доллар) татвар, төлбөр, хураамжийг төвлөрүүлж байна.

[www.ot.mn](http://www.ot.mn)  
[www.facebook.com/oyutolgoi](https://www.facebook.com/oyutolgoi)



# “БОРОО ГОУЛД” ХХК



## МОНГОЛ УЛСАД АЮУЛГҮЙ, ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ХӨГЖҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ



● Монгол Улсад 2004 оноос алтны үндсэн ордын олборлолтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

● Бороогийн уурхайгаас алтыг ил уурхайн аргаар олборлодог бөгөөд хоногт дунджаар 30,000 тонн чулуулаг тээвэрлэж, 7000 тонн хүдэр боловсруулж байна.

● “Бороо Гоулд” ХХК нь 2004 -2012 оны хооронд нийтдээ 232.9 тэрбум төгрөгийг улсын нэгдсэн төсөвт төлж улсад 2007 онд хоёрдугаар байранд, 2008 онд гуравдугаар байранд, 2009 онд нэгдүгээр байранд, 2010 онд гуравдугаар байранд тус тус орж Монгол Улсын Манлай татвар төлөгч аж ахуйн нэгжээр шалгарсаар ирсэн.

● Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа нь тус компанийн нэгэн бахархал. Бороогийн ажилчид 887 хоног буюу 2.4 жил хөдөлмөрийн чадвар түр алдалтгүй дөрвөн сая хүн цаг ажилласан амжилт үзүүллээ.


● 2012 оны 6-р сарын байдлаар 300 ажилтан ажиллаж байгаагийн 97 хувь нь Монгол Улсын иргэд эзэлж байна.

● Өнөөдрийн байдлаар 49.9 тонн алт экспортлоод байна.



Бороо Гоулд ХХК  
Сентерра Гоулд Инк  
www.borooold.mn

Утас: 976-11-317798  
Факс: 976-11-316100




# ГАН ХИЙЦ ХУВЬЦААТ КОМПАНИ



БАРИЛГА УГСРАЛТЫН ГАН-ЭРДЭНЭ КОНСТРАКШН ХХК  
СЭНДВИЧ, ХӨӨСӨНЦӨР ХАВТАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ  
БАРИЛГЫН ТӨМӨР ХИЙЦИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ  
ХҮНСНИЙ ХУСАНДАЙ МӨӨГНИЙ ҮЙЛДВЭР  
ВАКУМ ЦОНХ, ХААЛГАНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ  
ТӨМӨР БЕТОН ЭДЛЭЛИЙН ЖАДАВ ХХК  
БАРИЛГЫН ХАДААСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ  
ХҮЧИТГЭСЭН БЕТОН ХИЙЦ ХХК  
ҮЙЛДВЭРЛЭЛ ДЭЭРХ СУРГАЛТ

**БОГИНО ХУГАЦАА ЧАНАРЫН БАТАЛГАА**

Монгол улс, Улаанбаатар хот  
Сонгино Хайрхан дүүрэг, 7-р хороо  
Утас: 976-11-632448, 632467, 632446  
88115500, 88068117, 99060779  
Факс: 976-11-632448  
Web: [www.gankhiits.mn](http://www.gankhiits.mn)  
E-mail: [gankhiits@mongol.net](mailto:gankhiits@mongol.net)



Carrera Series

### HISTORY BEGINS EVERY MORNING

Some people make history happen. Aged 9, Lewis Hamilton dreamed of being a top racing car driver. He made his dream reality. For Lewis, every day is the date to write history, and history is written by winners.



# TAGHeuer

SWISS AVANT-GARDE SINCE 1860

Tag Heuer boutique  
Наран Молл, 2-р давхар, Сөүлийн гудамж 42/1  
Утас: 328841

Swiss Watch Shop  
Наран Пойнт, Хувьсгалчдын гудамж #9  
Утас: 326435  
[www.sws.mn](http://www.sws.mn)

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ВЭБ РЕДАКТОР

Б.Энхмарт

ОРЧУУЛАГЧ:

Б.Үүрийнтуяа

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР:

Ш.Оюундарь

□□□□□□□□□□

□.□□□□□□□□□□

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖЕР:

Ж.Алтантуяа /9905-1914/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /8880-0825/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш

“ECONOMY” ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ:

Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН

Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

[info@mongolianeconomy.mn](mailto:info@mongolianeconomy.mn)

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

АЙДЕОӨӨЛӨ ОҮА—А:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall"

## MONGOLIAN ECONOMY



ЗАХИАЛГЫГ:

“Монгол шуудан”

“Түгээмэл шуудан”

“Sky” шуудан

“UB Post” шуудангийн салбарууд болон  
сэтгүүлийн редакцид авч байна.

УТАС: 7011-5476

8880-0825

9905-1914

**П.Очирбат: Хөрөнгө оруулагчдын өөдөөс шороо цацахгүй байх юмсан**



Уул уурхай Монголыг Азийн бар болгох шатандаа явна. Хөрөнгийн урсгал зах зээлээ даган урсдаг жамтай. XXI зууны эрэлтийг Ази тив тодорхойлж байна. Нийлүүлэлтийн боломж энэ тивд тухайлбал, Монголд тодорхой хэмжээгээр байна. ...18

**Монгол улс ба гадаадын хөрөнгө оруулалт**

Улсын төсвийн орлогыг уул уурхайн салбар бараг л 100 хувь хангахын зэрэгцээ хамгийн өндөр цалинг олгож, түүнийг бараадсан ханган нийлүүлэлтийн салбарт том хувьсал гарлаа...26



**Усгүй хууль улсын ирээдүй**

Боловсруулах үйлдвэр ашиглалтад орвол уул уурхайн баялгаас дутахааргүй хөгжил дэвшил ирж, олон зуун хүн ажлын байртай болж, гаднынхны хорхойг хөдөлгөж, чамгүй хөрөнгө оруулалт татах учиртай. ...48

**Дархлаа ба уурхайн хаалт**

Үүрийн гэгээ татаж, өтгөн манан газраас хагацаж ядан салах Монголын тэгш талд аль эрт чийг унажээ. Талын салхи зөөлөн үлээж, таанын үнэр хамар цоргих нь хэний ч сэтгэлийг сэргээж, мартагдсан гэгээн дурсамжийг сэдрээх хүчтэй ажгуу...36



**УУЛУУРХАЙ**

- 10 “Discover Mongolia-2012” арав дахь жилдээ
- 11 А.Билгүүн: Хайгуул, олборлолтоос хөгжил дэвшил өөд хамтдаа
- 13 Зүүн Хойд Азийн орнуудын ашигт малтмалын бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлт
- 15 Зүүн хойд Азийн хаанчлалд Монгол Улс
- 18 П.Очирбат: Хөрөнгө оруулагчдын өөдөөс шороо цацахгүй байх юмсан
- 22 Бодлогоо хэрэгжүүлэх л үлдлээ
- 26 Монгол улс ба гадаадын хөрөнгө оруулалт
- 30 Хазайсан уу, хальтисан уу
- 32 “Discover Mongolia” Монголд өнгөт эсгийг моодонд оруулсан
- 42 Эцэг хуулийн оргил цаг
- 44 Занарын эрин эхэлчихэж
- 46 Өсөлтөөс хөгжилд
- 48 Усгүй хууль улсын ирээдүй
- 50 Дархлаа ба уурхайн хаалт

**БИЗНЕС**

- 54 Германы компанийн нийгмийн хариуцлагатай танилцлаа
- 58 Номингийн төрсөн өдөрт зочилсон нь
- 61 Уурхайчдын уушгийг хэн аврах вэ

**ЗАСГИЙН ГАЗАР**

“100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд бага, дунд орлоготой иргэдэд зориулж Засгийн газраас жилийн зургаан хувийн хүүтэй зээл олгохоор шийдвэрлэснийг Төрийн банк гүйцэтгэж байсан. Харин шинэ Засгийн газар “Капитал” банкийг нэмж оролцуулахаар болжээ. “Капитал” банк 5-10 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөс гарган эхний санхүүжилтийг хийхэд бэлэн буйгаа илэрхийлснээр ийнхүү Хөгжлийн банкнаас гарсан эх үүсвэрээр дамжуулж санхүүжүүлэх зээлийн хөтөлбөрт нэгдсэн байна.

**ХӨРӨНГИЙН БИРЖ**

Монголын хөрөнгийн биржийн арилжаа сүүлийн саруудад эрс муудсан. Албаныхны тайлбарлаж буйгаар энэ нь Лондоны хөрөнгийн биржийн арилжааны систем болох “Миллениум Ай Ти”-г оруулж ирсэн үеэс эхэлсэн аж. Шинэ системийн тавигдах шаардлага буюу хөрөнгийн асуудлаас болж арилжаанд оролцогч компани


эрс цөөрсөн байна. Систем нэвтэрсэнтэй холбоотойгоор уг шилжилтийн биелэлтээс арилжаанд хоёрхон компани оролцож байсан үеийг бодвол өнөөдөр байдал бага багаар сэргэж байгаа ч энэ нь хангалттай бус юм.

**ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Ази, Номхон далайн бүс нутгийн худалдаа аж үйлдвэрийн танхимын нэгдсэн холбооны Ерөнхийлөгч Ноён Бенедикто В.Южико манай улсад айлчилж байна. Айлчлалын бүрэлдэхүүнд Хонконг, Тайвань, Энэтхэг, Филиппин, Пакистан зэрэг орны бизнес эрхлэгчид багтжээ. Тэд мэдээллийн технологи, үл хөдлөх хөрөнгө, бэлэн хувцас, амралтын газар, бөөний болон жижиглэнгийн худалдаа, газрын тос, хийн үйлдвэрлэлийн хяналт, шалгалт сорилын лабораторийн үйлчилгээ, гурилын худалдаа, уул уурхай, машины эд анги, сэлбэгийн худалдаа, тээвэр зуучлал болон урлагийн бүтээлийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж.

**БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**

Төвийн эрчим хүчний шинэ эх үүсвэр



болох Салхитын салхин цахилгаан станцыг “Ньюком групп” Төв аймгийн Сэргэлэн суманд байгуулж буй. Ирэх арваннэгдүгээр сард ашиглалтад орох тус цахилгаан станцын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа аж. Салхитын салхин цахилгаан станц нь 50 мегабаттын хүчин чадалтай бөгөөд ашиглалтад орсноор жилдээ 170 сая кВт. цаг цэвэр эрчим хүч үйлдвэрлэх чадалтай юм. Инженерүүдийн тооцоолж буйгаар салхин станц ашиглалтад орсноор жилд хоёр сая тонн ус хэмнэж, 200 мянган тонн түүхий нүүрсийг шатаахгүй байх боломжтой гэнэ.

**ГАЗАР ТАРИАЛАН**

Энэ жил улсын хэмжээнд 318 мянга га талбайд тариалалт хийснээс, буудайг 296.2 мянган га талбайд тариалсан байна. Тариалалтын урьдчилсан дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр тариа 16.4 мянган га-гаар, төмс 4.5, хүнсний ногоо хоёр, малын тэжээлийн ургамал 4.1 мянган га-гаар тус тус ахиу тариалжээ. Гэхдээ Эрдэнэт, Хөвсгөл, Булган, Орхон аймагт орсон усархаг борооны улмаас гуу, жалгын ойролцоох талбайн тариалан усанд урсах, тариа налах тохиолдол багагүй гарчээ.

Үүнд Хөвсгөл аймагт 400 га, Төв аймагт 80 га ногооны талбай усанд урссан байна. Мөн 296 мянга га талбайд улаан буудай тариалснаас өнөө жилд 440 орчим мянган тонн улаан буудайг хурааж авах төлөвтэй байгаа юм байна.

**ХӨДӨӨ АЖ АХУЙ**

Манай Ургамал хамгааллын хүрээлэн ОХУ-ын Новосибирск хотын “Сиббиофарм”, “Сибхолдинг”, Санкт-Петербург хотын Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран улаан буудай, ургамлын өвчинтэй тэмцэх, жижиг оврын үйлдвэр барихаар өнгөрсөн сард тохиролцлоо. 20 гаруй шинэ төрлийн ургамал хамгааллын бодис боловсруулах технологи бүхий энэхүү үйлдвэрийг байгуулснаар хил орчмын нутгаар тархалт хүрээ нь ихсэж байгаа мэрэгч амьтан, нугын бор эрвээхэй, царцааны тархалт, ургамал устгагчдын судалгааг нарийвчлан тогтоох юм.

**ЭРҮҮЛ МЭНД**

Манай улс давхардсан тоогоор дотооддоо жилд 280 орчим нэр төрлийн 8.1 тэрбум гаруй төгрөгийн эм үйлдвэрлэдэг байна. Гэвч үйлдвэрлэж буй эмийнхээ түүхий эд, бүтээгдэхүүнийг гаднаас 100 хувь импортлодог бөгөөд үүнд эмийн төрлийн ургамлууд хамаардаггүй аж. Харин жилд 33 орноос 2000 нэрийн 60 гаруй тэрбум төгрөгийн эм, бэлдмэл

импортлодог аж. Өдгөө Монгол Улсад 1891 нэр төрлийн эм, бэлдмэл хэрэглэхийг албан ёсоор бүртгэж, зөвшөөрсөн бол үүний 170 нэр төрлийн эмийг түгээмэл хэрэглэдэг гэх судалгаа байна.

**АЗИ**

Азийн валют худалдааны зах зээлд еврогийн ам.доллартай харьцах харьцаа буурч, 1.2 ам.доллартай тэнцэх болсон. Евро бүсийн өрийн хямралаас үүдэн Азийн хөрөнгийн бирж дэх хувьцааны үнэ бага зэрэг буурсан нь Ази тивийн их гүрнүүдийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй гэнэ. Учир нь Японы “Nikkei” 225-ийн хувьцаа 1.4 хувиар, Өмнөд Солонгосын “Kospi” 2.3 хувиар, Хонконгийн “Hang Seng” индекс 2.7 хувиар тус тус унасан нь дээрх таамгийг дэвшүүлэхэд хүргэжээ. Европ бол Азийн экспортын хамгийн том түнш. Энэ ч утгаараа бараа, бүтээгдэхүүний эрэлтийн хэмжээ еврогийн ханш буурч эхэлсэн нь Азийн зах зээлд түгшүүр зарлаад байна. Түүнчлэн Еврогийн иентэй харьцах харьцаа сүүлийн 11 жилд өмнө нь байгаагүйгээр буюу 94.91 болж унасан тухай ВВС мэдээллээ.

**ЕВРОП**

Европын Төв банкнаас инфляцийг жилийн хоёр хувиас бага зэрэг доогуур түвшинд барихыг зорьдог. Европын Холбооны банкны

Мөнгөний бодлогын зөвлөл Евро-бүсийн инфляцийн түвшинг 2012 онд дунджаар жилийн 2.4 хувь, 2013 онд дунджаар жилийн 1.6 хувьтай тэнцэнэ гэж таамаглаж байгаа аж. Нийт 17 орныг нэгтгэсэн Евро-бүсийн инфляцийн түвшин өнгөрөгч дөрөвдүгээр сард жилийн 2.6 хувьтай тэнцэж байснаа буурч, тавдугаар сард жилийн 2.4 хувьд хүрсэн тухай мэдээллийг Люксембург хотын Европын холбооны Статистикийн албанаас саяхан өгчээ. Мөн Евро-бүсийн экспорт өмнөх сараас 1.3 хувиар, харин импорт гурван хувиар тус тус буурсан байна.

**ХЯТАД**

Байгаль орчны бохирдлыг эсэргүүцсэн Хятадын иргэд Чидон хотод бохир ус дамжуулах шугам барих ажлыг эсэргүүцэж, шугамыг эвдлээ хэмээн тус орны Төрийн албанаас

мэдээллээ. Шанхай хотоос хойд зүгт орших Чидон хотод бослого гаргагчид гудамжинд жагсаж, орон нутгийн цагдаатай мөргөлдөөн үүсгэсэн байна. Жагсагчид шинээр барих цаасны үйлдвэрийн бохирын шугам сүлжээ нь далайн усыг бохирдуулна гэж үзжээ. Мянга мянган босогч машинуудыг унагаж, төрийн албанд дайран орж цонхоор бичиг баримтуудыг нь шиджээ. Мөн тэд албан хаагчдын хахуульд авсан дарснуудыг ч албаны өрөөнөөс нь ил гаргасан байна.

**ОРОС**

Оросын Гадаадын хөрөнгө оруулалтын зөвлөл нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа нэг их наяд рублийн (31 тэрбум ам.доллар) өртөгтэй хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулсан гэж Оросын Ерөнхий сайд Дмитрий Медведев



мэдэгдсэн байна. “Засгийн газрын хөрөнгө оруулалтын зөвлөл нь одоогоос дөрвөн жилийн өмнөөс үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэ хугацаанд нийт 147 хөрөнгө оруулагчаас санал хөтөлбөр хүлээж авсан билээ. Эдгээрээс найман саналд татгалзсан хариу өгсөн” гэж Медведев зөвлөлийн хурлаар хэлжээ. Тус хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хүрээнд нийт нэг их наяд рублийн дотоодын эдийн засагт зарцуулах юм. Ерөнхий сайд төрийн албан хаагчдад хандан хөрөнгө оруулахад таатай салбарыг улам өргөжүүлж, засаг захиргааны саадыг тогторыг бууруулахыг уриалсан байна.





## “DISCOVER MONGOLIA-2012” АРАВ ДАХЬ ЖИЛДЭЭ

Өнөө жилийн “Discover Mongolia”-гийн хувьд онцлог болно. Учир нь шинэ төр, засаг бүрэлдэж ажлаа эхлэх үед тус чуулга уулзалт болох юм. Тиймээс энэхүү арга хэмжээний “Засгийн газрын цаг” ихээхэн сонирхолтой өрнөнө.

### Д.БЭХЭЭ

Монголын уул уурхайн салбарыг дэлхийд танилцуулах зорилготой “Discover Mongolia” чуулга уулзалт, үзэсгэлэнг зохион байгуулснаас хойш арав дахь жилийнхээ намартай золгож байна. 10 жил тийм ч бага биш хугацаа. Он цагийн хэлхээсэнд жилээс жилд онцлох сэдэв, уриагаараа бусдаас тодрон ирсэн энэхүү чуулга уулзалтын ач холбогдлыг хүмүүс гадарлаж байгаа нь дамжиггүй.

Тэртээх 10 жилийн өмнөх Монгол Улсын эдийн засаг ямар байсан бэ. Лав л дэлхийн томчууд Азийн жижигхэн улсыг сонирхдоггүй, бараг мэддэг ч үгүй байсан байх.

Баримт дурдвал 1990-2004 онд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 172 сая ам.доллар, гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо нийтдээ 3691 байсан бол зөвхөн 2010 оны нэмэгдсэн тоо нь 769 болж өссөн байна. Тэгвэл өнөөдөр манай эдийн засгийн

өсөлт 17 хувьтай гарч, гаднынхныг гайхшрууллаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 65.3 хувийг геологи, уул уурхайн эрэл хайгуулын салбар эзэлж байна. Дэлхийн бүх том компани манай орныг сонирхоод зогсохгүй төлөөлөгчийн газраа, салбараа нээв. Дэлхийн хэмжээний том төслүүд хэрэгжиж эхэллээ. Улсын төсөвт мөнгө ихээр орж ирж эхэллээ. Төрийн түшээд бусад улс оронд айлчилж, толгой гудайн хандив гуйхгүйгээр харилцан ашигтай хамтран ажиллах түншийн холбоог чухалчлан явах боллоо. Энэ нь хөгжлийн нэг алхам биш гэж үү.

Миний бие яг 10 жилийн өмнө “Discover Mongolia” чуулга уулзалтыг анхлан сурвалжилж байлаа. Түүнээс хойш 3-4 жилийн турш энэхүү чуулганыг сурвалжилсан юм байна. Шинэлэг содон, манай улсдаа л хамгийн том хурал болдог байлаа. Төрийн болон хувийн хэвшлийн бүх л төлөөлөл маш идэвхтэй, санал санаачилгатай ▶

оролцдог. Хэвлэл мэдээллийнхэн ч чухал ач холбогдол өгч, тус хурлаас олон олон бичлэг, нийтлэлийн санаа олж авдаг том чуулган юм. 10 жилийн өмнө манай улсад олон улсын чанартай хурал семинар ховор болдог байв. Харин өнөөдөр шил даран зохион байгуулагдах болжээ. Уул уурхайн сэдэв ярихгүй семинар, арга хэмжээ байхгүй болов. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарын хөгжлийн үнэлэмж өнөөдөр ямар буйг уншигчид маань сайн мэднэ. Манай эдийн засгийн түлхэх гол хүч нь угаас уул уурхай юм. Энэ бүх эдийн засгийн, хөгжлийн үзүүлэлтэд “Discover Mongolia” чуулга уулзалт эерэгээр нөлөөлсөн гэж л би хэлэх гээд байна. Олон хүн надтай санал нийлэх биз ээ.

Тус чуулга уулзалтын 10 жилд зориулсан тусгай дугаарыг уншигч танаа хүргэж байна. Өнөө жилийн “Discover Mongolia-2012” нь “Хайгуул, олборлолтоос хөгжил дэвшил өөд хамтдаа” уриатайгаар зохион байгуулагдаж байна. Сэдвийн хувьд өнгөрсөн жил хариуцлагатай уул уурхайг онцлон ярилцсан бол энэ жилийнхээр Зүүн хойд Азийн орнуудын ашигт малтмалын төлөв байдлын талаар түлхүү хэлэлцэх ажээ. Зүүн Ази дотроо Монгол Улс ямар үүрэг гүйцэтгэх юм, Монголын уул уурхайн хөгжлийн боломж бололцоог хэрхэн ашиглаж хамтарч ажиллах зэрэг чиглэлээр төлөөлөгчид санал бодлоо хуваалцах ажээ.

Мөн энэ дугаарт уул уурхайн хөрөнгө оруулалтын орчин, газрын тосны хөгжил, гаднынхны одоо сонирхоод буй занар зэрэг сэдвээр бичсэн нийтлэлүүд орлоо. Манай сэтгүүлч Х.Хулан Германы компаниудын нийгмийн хариуцлагын туршлагаас судлаад ирсэн билээ. Түүний нийтлэл манай уул уурхайн компаниудад шинэ санаа оноо, мэдлэг мэдээлэл өгнө гэдэгт итгэлтэй байна. Сэтгүүлч Э.Зоригтын “Дархлаа ба уурхайн хаалт” нийтлэл компаниудад хэрэгтэй мэдээллийг өгсөн гэж үзэж байна. Уурхайн нөхөн сэргээлт, уурхайг хаасны дараа ажилчдын амьдрал яах вэ зэрэг олон асуудалд манай уул уурхайнхан тодорхой хариу хэлж чаддаггүй, тусгайлсан төлөвлөгөө ч байдаггүй явж ирснээс онгойсон нүх, сэндийчсэн тал нутгийн тоо олширсоор байгааг нуух юун.

Өнөө жилийн “Discover Mongolia”-гийн хувьд онцлог болно. Учир нь шинэ төр, засаг бүрэлдэж ажлаа эхлэх үед тус чуулга уулзалт болох юм. Тиймээс энэхүү арга хэмжээний “Засгийн газрын цаг” ихээхэн сонирхолтой өрнөнө. Шинэхэн Засгийн газар, сайдууд уул уурхайн салбарт ямар бодлого баримталж ажиллах, гадаадын хөрөнгө оруулагчидтай хэрхэн хамтран ажиллах, Оюутолгой, Тавантолгойн асуудлаар ямар байр суурьтай байгаа юм, Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах хуульд нэмэлт өөрчлөлт оруулах уу зэрэг олон асуулт тэднийг хүлээж байна. ■

## А.БИЛГҮҮН: ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТООС ХӨГЖИЛ ДЭВШИЛ ӨӨД ХАМТДАА

Зүүн хойд Азийн эрдэс, баялгийн нөөц, хэрэгцээ шаардлага, нийлүүлэлтээр тусад нь онцлон ярилцахаар төлөвлөсөн.

### Б.УУГАНБАЯР

“Discover Mongolia-2012” чуулга уулзалтын онцлог, хүлээж буй үр дүнгийн талаар “Прайм инфо” ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Билгүүнээс тодрууллаа.

**-Энэ оны чуулган өмнөх жилүүдээсээ юугаараа онцлог, ач холбогдолтой болох вэ?**

“Discover Mongolia-2012” нь “Хайгуул, олборлолтоос хөгжил дэвшил өөд” уриатай болно. Ирэх жил Оюутолгойн бүтээн байгуулалтын

ажил дуусч, олборлолт эхлэх гэж буйд ихээхэн ач холбогдол өгч байна. Мөн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэхэд анхаарах шаардлагатай байна. Чуулганы үеэр зөвхөн Монгол гэхгүй дэлхийд манайхыг тойрсон ашигт малтмалын ямар зах зээл байгааг судалж, мэдээлэл солилцоно. “Зүүн хойд Азийн эрдэс баялгийн эрдэс, бүтээгдэхүүний хэрэгцээ, нийлүүлэлт” сэдвээр ОХУ, Япон, Хятад, Солонгос, ▶

► Японоос мэргэжилтнүүд ирж илтгэл тавьж, зөвлөгөө өгнө. Ингэхдээ манай улс түүхий эд, эрдэс баялгийн бүтээгдэхүүнээ Зүүн хойд Азийн зах зээлд гаргахад ямар саад бэрхшээл, боломж буй талаарх судалгаа, шинжилгээг танилцуулахаараа ихээхэн онцлогтой болно.

**-Хэчнээн байгууллага, аж ахуйн нэгж оролцох болон чуулганы сэдвийн талаар тодруулахгүй юу?**

-Урьдчилсан байдлаар 90 гаруй компани чуулганы үеэрх үзэсгэлэнд оролцохоор бүртгүүлээд байна. Мөн уул уурхайн ханган нийлүүлэгч компаниуд гадаа талбайд үзэсгэлэнгээ гаргах санал ирүүлсэн. Өнгөрсөн хугацаанд “Discover Mongolia” олон улсын чуулга уулзалтад 20-иод орны 500 гаруй байгууллага оролцож иржээ.

Чуулганы сэдвийн хувьд эрдэс баялгийн нөөцийн нөхөн үйлдвэрлэл буюу хайгуул, олборлолт, гүн боловсруулалтыг дотооддоо хэрхэн хийх талаар түлхүү ярилцаж, хэлэлцэнэ. Зүүн хойд Азийн эрдэс, баялгийн нөөц, хэрэгцээ шаардлага, нийлүүлэлтээр тусад нь онцлон ярилцахаар төлөвлөсөн. Мөн гадны хөрөнгө оруулалтыг зохицуулах, хууль эрхзүйн орчинг илүү боловсронгуй болгох талаар ч санал солилцоно. Дээр нь бид “Засгийн газрын цаг”-т шинэ Засгийн газар бүрдэж буйтай холбоотойгоор ихээхэн ач холбогдол өгч байгаа. Учир нь шинэ Засгийн газрын уул уурхай болон хувийн салбарт чиглэсэн бодлого, хандлага нь ямар байхыг тодорхойлох юм.

**-Гадаадын хөрөнгө оруулагчид манай хууль эрхзүйн орчноос гадна хөрөнгө оруулалт хийхдээ сонирхдог гол зүйл нь юу вэ?**

-Гаднын хөрөнгө оруулагчид мэдээж хамгийн түрүүнд хууль эрхзүйн орчинг судална. Ер нь уул уурхайн салбарыг дэд бүтэцгүйгээр төсөөлөх боломжгүй. Тиймээс дэд бүтэц хэр сайн хөгжсөн гэдгийг онцолж авч үздэг. Одоогоор манай дэд бүтэц тааруухан дүн авахаар байгаа нь хөрөнгө оруулагчдыг үргээдэг нэг шалтгаан. Мөн хүний нөөцийн чадавхийн асуудал ч чухал. Монгол Улсыг гаднын хөрөнгө оруулагчид ихээхэн сонирхоод буйн гол шалтгаан нь хөрш Хятадын зах зээлтэй шууд холбоотой. Учир нь Хятадын зах зээл дээр манай Монголын ашигт малтмалын ямар ч түүхий эд гарсан бусад улстай өрсөлдөхүйц чадвартайд байгаа юм.

**-“Нээлт олборлолтоос хөгжил дэвшил өөд” гэсэн өвөрмөц уриа үгийг сонгожээ. Урианыхаа талаар тайлбарлахгүй юу?**

-Энэхүү чуулга уулзалтын ерөнхий хорооны зохион байгуулагчаар Монгол Улсын анхны Ерөнхийлөгч асан П.Очирбат ажилладаг. Тэрбээр чуулгын уриаг санаачилсан. Энэ жилийн хувьд Монголоос ашигт малтмалыг түүхийгээр бус хагас болон бүтэн боловсруулж гаргахыг ихэд чухалчилж үзэж байна.

Монголчууд өнгөрсөн хавар Энэтхэгийн томоохон компанитай Гангийн үйлдвэр барих санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэ нь нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэл болсон гэж хэлж болно. Тэгэхээр “Нээлт, олборлолтоос хөгжил дэвшил өөд” уриа нь аль болох нэмүү өртөг шингэсэн



Фотог Э.Зоригт

бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон болохыг уриалж байгаа юм.

**-“Discover Mongolia” чуулга уулзалтыг 10 жилийн турш тасралтгүй зохион байгуулж, төр, засаг, уул уурхайн салбарынхан, хувийн хэвшлийнхэн, гадаадын хөрөнгө оруулагчдын дуу хоолойг сонссоор байна. Тэгвэл тус чуулганы үр дүнд улсын төрийн бодлого, эдийн засгийн хөгжилд ямар ахиц, өөрчлөлт гарсан бэ?**

-Манай улсын эдийн засаг сүүлийн хэдхэн жилийн дотор хурдацтай өслөө. Цаашдаа ч өсөлт нэмэгдэхээр байгаа. Үүний уг үндэс нь гадаадын хөрөнгө оруулалт юм. Манайх 2002 оноос “Discover Mongolia” уулзалтыг зохион байгуулж байна. 2006 онд Оюутолгойн орд ашиглалтад анх ороход иргэдийн зүгээс уул уурхайн эсрэг жагсаал, цуглаан зохион байгуулж байсан үед ч энэ уулзалтыг зохион байгуулж ирсэн.

Мөн ураны талаарх манай улсын бодлого гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээсэн ч бид аль болох зөв байр сууринаас хамтарч ажиллахыг зорьсоор байна. Дээр нь манай чуулга, уулзалтаас гарсан бодлого, саналыг төрийн бодлогод тусгаж, ажил хэрэг болгосон тохиолдол олон бий. Энэ мэтчилэн бид улсынхаа хөгжилд ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлд эргээд харахад багагүй ажил хийжээ. ■

е

## ЗҮҮН ХОЙД АЗИЙН ОРНУУДЫН АШИГТ МАЛТМАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ БА НИЙЛҮҮЛЭЛТ

Европын хямралаас үүдэлтэй энэхүү эдийн засгийн удаашрал нь 2012 онд ч үргэлжилсээр байх хандлагатай байна.

Б.ЦЭЦЭЭ

### БНХАУ



Хятад улс 1978 оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлд суурилсан эдийн засаг руу шилжих өөрчлөлтийг эхлүүлснээр өнөөдөр хүртэлх 30 жилийн хугацаанд эдийн засгийн тасралтгүй өндөр үзүүлэлтээр гайхуулж ирсэн.

Эдийн засаг нь дэлхийд хоёрт орж Азидаа дангаар ноёлдог орон юм. Тус улсын өнгөрсөн хугацаан дахь эдийн засгийн дундаж өсөлт нь жилийн 9.7 хувь байжээ. Харин 2010 оны 10.4 хувийн өсөлт, 2011 онд 9.2 болж буурчээ. Европын хямралаас

үүдэлтэй энэхүү эдийн засгийн удаашрал нь 2012 онд ч үргэлжилсээр байх хандлагатай байна. Энэ жилийн гуравдугаар сард тус улсын Засгийн газар 12 дахь таван жилийн төлөвлөгөөг баталсан бөгөөд эдийн засгийн шинэчлэлийг үргэлжлүүлж, экспортын бүтээгдэхүүний хэт хамаарлыг багасгахын тулд дотоодын хэрэглээг нэмэгдүүлэхээр зорьж буйгаа онцолжээ. Хятад нь 2001 онд эдийн засгаараа Японыг гүйцэж, дэлхийн хоёр дахь хүчирхэг эдийн засагтай орон болсон юм.

БНХАУ нь алт, нүүрс, газрын тос, байгалийн хий, төмөр, зэс, газрын ховор элемент зэрэг байгалийн баялгийн нөөц арвинтай. Хятадын уул уурхайн салбар дэлхийд гуравдугаарт эрэмблэгддэг ч өөрсдийн үйлдвэрлэсэн ашигт малтмалын бүтээгдэхүүний дийлэнхийг дотооддоо хэрэглэдэг. Дэлхийн нийт вольфрамын 70 хувийг үйлдвэрлэж газрын ховор элементийн нөөц, экспортоор мөн цемент, цагаан тугалга, төмрийн үйлдвэрлэлээр

дэлхийд тэргүүлдэг улс юм. Нүүрсний нөөцөөрөө дэлхийд гуравт ордог манай урд хөрш 2011 онд дэлхийн нийт нүүрсний эрэлтийн 48.18 хувийг дангаараа эзэмшиж байсан бөгөөд дотооддоо 3.19 тэрбум тонн нүүрс хэрэглэсэн тооцоо гарчээ.

Өнгөрсөн онд нүүрсний импорт нь 10.8 хувиар өсч, 182.4 сая тонн болсон нь тус улсыг дэлхийд нүүрсний хэрэглээнээс гадна импортоор тэргүүлэхэд хүргэсэн. Харин газрын тосны нөөцөөр дэлхийд 14 дүгээрт, импорт, дотоодын хэрэглээгээр гуравт ордог байна. Тус улсын газрын тосны нэг өдрийн хэрэглээ 2011 оны судалгаагаар 9.4 тонн байжээ. Импортын голлох түнш нь өнгөрсөн онд Япон, Өмнөд Солонгос, АНУ, Герман, Австрали байв. Ашигт малтмалын бүтээгдэхүүний хувьд газрын тос, төрөл бүрийн түлш, төмөрлөг бүтээгдэхүүнийг их хэмжээгээр худалдан авдаг байна. Экспортын барааны хэмжээгээр дэлхийд нэгт, импортоор гуравт ордог улс юм.

### ОХУ



ОХУ-ын эдийн засгийн өсөлт 1998 оноос хойших 10 жилийн хугацаанд дунджаар долоон хувьтай явж ирсэн билээ. Харин 2008-2009 оны хоорондох санхүүгийн хямралаас үүдэн газрын тосны ханш газардсанаар Оросын банк, компаниудын олон улсаас авдаг зээл багасч, хүндхэн цохилтод орсон

юм. Тус улсын ДНБ-ий өсөлт 2009 онд -7.8 хувьтай байсан бол өнгөрсөн хоёр жилд 4.3 хувийн өсөлт үзүүлжээ.

Ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын хувьд голчлон Нидерланд, Хятад, Итали, Герман, Польш зэрэг орон руу газрын тос, байгалийн хий, металлын төрлийн бүтээгдэхүүн ▶

► нийлүүлдэг байна. Харин импортын голлох хамтрагч нь Хятад, Герман, Украин, Итали улс бөгөөд төмөр, ган гэх мэт уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан авдаг.

ОХУ өнгөрсөн онд газрын тос үйлдвэрлэлийн хэмжээгээр Саудын Арабыг давж, дэлхийд тэргүүлж эхэлсэн бол байгалийн хийн үйлдвэрлэлээр дэлхийд хоёрт ордог байна. Байгалийн хийн

хамгийн баян нөөцтэй орон буюу 44.8 их наяд шоо метр нөөцтэй. Харин нүүрсний нөөцөөр дэлхийд хоёрт бичигддэг бол газрын тосны хувьд 60 тэрбум баррель нөөцтэй буюу наймд эрэмблэгддэг. Төмрийн хүдэр болон хөнгөн цагааны төрлийн бүтээгдэхүүний экспортоор дэлхийд хоёрт жагсдаг ОХУ нь өдөрт 10 гаруй сая тонн газрын тос үйлдвэрлэн гаргаж, таван сая гаруйг

нь экспортолдог байна. Байгалийн хийн үйлдвэрлэл нь жилд 600 тэрбум шахам шоо метртэй тэнцэх бөгөөд экспортын хэмжээ нь жилдээ 200 тэрбум байдаг учир тус улс нь дэлхийн хамгийн том байгалийн хийн ханган нийлүүлэгч юм. Түүнчлэн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээр дэлхийд тавд ордог байна.

## БНАСУ



Хойд Солонгосын эдийн засаг жил дараалан хасах дүн үзүүлсээр байгаа бөгөөд 2009 онд 0.9 хувийн бууралттай байсан бол 2010 онд 0.5 хувиар доошилсон үзүүлэлттэй гарчээ.

Хойд Солонгосын эдийн засгийг тэтгэгч түлхүүр салбаруудын нэг нь уул уурхай. Газар нутгийн 80 гаруй хувьд нь эрдэс баялаг өргөн тархсан, 200 гаруй

төрлийн эрдэс бүхий том хэмжээний ордуудтай. Одоогоор олж илрүүлээд буй эрдэс баялгийн дийлэнхийг нүүрс, төмрийн хүдэр, вольфрам, бал чулуу, алт, цайр, молибден, шохойн чулуу, магнезит гэх мэт эзэлдэг. Эдгээр ашигт малтмалыг томоохон уурхайн хэмжээнд хөгжүүлэн ажиллуулах бүрэн боломжтой аж.


Тус улс химийн үйлдвэрлэлд өргөн хэрэглэдэг магнийн нөөцөөр Хятадын дараа буюу дэлхийд хоёрт ордог. Мөн вольфрамын нөөцөөр дэлхийд зургаад жагсах нөөцтэй байх магадлалтай гэнэ. Ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт нь 2002 онд 50 сая ам.доллартай тэнцэж байсан бол өнгөрсөн онд 17 дахин буюу 860 сая ам.доллар болтлоо өсчээ.

“Yonhap” мэдээллийн агентлаг болон Сөүлийн “IBK” эдийн засгийн судалгааны газрын хамтарсан судалгаагаар Хятад улс 2010 оны

1-9 дүгээр сарын хооронд 245 сая ам.доллар буюу гурван сая гаруй тонн ашигт малтмал импортлосон бол 2011 оны мөн үед 852 сая ам.доллартай тэнцэх өсөн сая шахам тонн эрдсийг Хойд Солонгосоос худалдан авсан нь дөрөв дахин өссөн үзүүлэлт юм. Дээрх Хятад руу экспортлосон 8.42 сая тонн эрдэс баялгийн дийлэнх нь буюу 8.19 сая тонн нь сайн чанарын чулуун нүүрс байжээ.

Манай урд хөрш Хойд Солонгосын хамгийн том эдийн засгийн түнш юм. Тус улс чулуун нүүрсээ Хятадад нэг тонныг нь 101 ам.доллараар арилжиж байхад олон улсын шаардлагад нийцсэн сайн чанарын чулуун нүүрс дэлхийн зах зээл дээр нэг тонн нь 200 ам.доллар байна. Хятад өнгөрсөн жил Хойд Солонгос руу 732 мянган тонн ашигт малтмалын бүтээгдэхүүн экспортолсны дийлэнх нь түүхий нефьт байжээ.

## БНСУ



1960 оны үед Африк, Азийн ядуу буурай орнуудтай адил хэмжээнд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний үзүүлэлттэй байсан БНСУ өнгөрсөн 40 жилийн хугацаанд асар хурдацтай өсөн дэвжиж, дэлхийн

өндөр хөгжилтэй орнуудын эгнээнд шилжин, өндөр технологид суурилсан үйлдвэрлэгч эдийн засагтай орон болсон билээ. Өнөөдөр Өмнөд Солонгос нь дэлхийд эдийн засгаараа 15 дугаарт жагсдаг бол Азидаа дөрөв дэх том эдийн засагтай орон юм.

Ашигт малтмалын нөөцийн дийлэнх нь Хойд Солонгост байдаг бөгөөд нийт алт, төмрийн нөөцийн ердөө 10 хувь нь Өмнөд Солонгост бий гэнэ. Харин тус орны өмнөд хэсэг нь вольфрам, бал чулууны нөөцөөр арвин. Хэдий нүүрс, төмрийн хүдэр, молибден Өмнөд Солонгост байгаа ч нөөц маш бага учир энэ талын олборлолт нь ч тийм их биш аж. Тиймээс тус улс ашигт малтмалын ихэнх хэрэгцээгээ тэр

дундаа газрын тосыг гаднаас авдаг. Голлох импортлогч орон нь Хятад, Япон, АНУ, Саудын Араб, Австрали. Ашигт малтмалын бүтээгдэхүүний хувьд түүхий болон боловсруулсан нефьт, шатахуун түлш, төмөр, ган болд, нүүрс, зэсийн хүдэр байгалийн хийг их хэмжээгээр импортлодог.

Дэлхийд экспортын барааны хэмжээгээр наймд, импортоор есд ордог байна. Ашигт малтмалын салбарт зонхилох импортын бүтээгдэхүүн нь нефьт бөгөөд өдөрт 3.074 сая баррель газрын тос импортлодог Өмнөд Солонгос нь дэлхийд тав дахь том газрын тос импортлогч юм. Өмнөд Солонгосын газар нутаг дээр ердөө л 139 сая тонн нүүрсний нөөц байдаг бол тус улс жилдээ 120 саяас давсан ►►

► нүүрсний хэрэглээтэй ажээ.


Солонгосын нүүрсний хэрэглээ нь өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд эрчим хүчний үйлдвэрлэлд нийт импортлосон нүүрснийхээ тал хувийг зарцуулдаг байна. Харин дотоодын нүүрсний олборлолт нь хэрэглээнээсээ гурав

дахин бага. Иймээс Өмнөд Солонгос нь дэлхийд нүүрсний импортоороо Хятад, Японы дараа орж нүүрсний хэрэглээг нь Австрали Индонез улс хангадаг аж. Харин байгалийн хийн бүтээгдэхүүний хувьд импортоос тэр чигтээ хамааралтай учир өнгөрсөн 10 жилийн хугацаанд байгалийн

хийн импорт нь бараг хоёр дахин нэмэгдсэн байна. Байгалийн хийн голлох импортлогч нь Катар, Малайз, Оман, Индонез.

Газрын тосны импортоор дэлхийд тавд, нүүрсний импортоор гуравт ордог бол шингэн байгалийн хийн импортоор хоёрт ордог орон юм.

## Япон



Дэлхийн II дайны дараах Засгийн газрын хамтын ажиллагаа, өндөр технологийг хөгжүүлэх дотоод боломж бололцоо, хөгжлийн төлөөх хүсэл зориг, эдийн засгийн доогуур өсөлт зэрэг нь тус улсад өндөр технологид суурилсан эдийн засгийг хөгжүүлэх хөшүүрэг болсон гэж үздэг.

Японы үйлдвэрлэлийн салбар гаднаас орж ирэх түүхий бүтээгдэхүүн болон шатахуунаас ихээхэн

хамааралтай. Япон нь эдийн засгаараа дэлхийд дөрөвт ордог. Манай урд хөрш эдийн засгийн өсөлтөөрөө 2001 онд тус улсыг ардаа орхисон бол Энэтхэг 2011 онд Японыг гүйцжээ. Японы Засгийн газрын гаргасан төлөвлөгөө 2009 оны санхүүгийн хямралыг гэтлэхэд ихээхэн тусалсан ч 2011 оны хавар тус улсад болсон өсөн баллын хүчтэй газар хөдлөлт үйлдвэрлэлийг тасалдуулж, эдийн засгийг нь сөхрөхөд хүргэсэн. ДНБ-ийх нь өсөлт хямралын үед эдийн засгийн өсөлт нь 2009 онд -5.5 хувьтай байсан бол 2010 онд сэргэж 4.4 хувиар өссөн ч өнгөрсөн тохиосон байгалийн гамшгаас үүдэн -0.7 хувьтай болжээ.

Эрдэс баялгийн нөөц харьцангуй багатай учир ашигт малтмалын бүтээгдэхүүний хэрэгцээгээ ихэвчлэн гаднаас худалдан авдаг. Япон нь дэвшилтэт технологи үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгчдийн нэг бөгөөд машин,

электрон тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ган төмөр, өнгөт металл, хөлөг онгоц зэрэг бүтээгдэхүүн голчлон үйлдвэрлэдэг. Арлын энэ улс дэлхийд импорт, экспортын хэмжээгээрээ тавд ордог байна. Япон улс ашигт малтмалын бүтээгдэхүүн тэр дундаа шатахуун, шингэн байгалийн хий, нүүрс зэргийг их хэмжээгээр импортлодог бол экспортод зөвхөн боловсруулсан төмөр болон ган болдын төрлийн бүтээгдэхүүнийг гаргадаг. 1975 оноос хойш нүүрсний импортоор дэлхийд тэргүүлэгч байсан ч өнгөрсөн онд нүүрсний импорт нь 5.1 хувиар унаж, 175.2 сая тонн болсноор Хятадын дараа орох болжээ. Коксжих нүүрсний импорт нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.4 хувиар унаж, 63.5 сая тоннд хүрчээ. Үүний зэрэгцээ төмрийн үйлдвэрлэл нь энэ жилийг оруулаад хоёр дахь жилдээ унасан үзүүлэлттэй гарах төлөвтэй байгаа аж. ■

Эх сурвалж: *The World Factbook, World Coal Association, Sourcewatch, ГХЯ-ны Азийн газар.*

## ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХААНЧЛАЛД МОНГОЛ УЛС

Манай улсын хувьд 1.6 тэрбум тонн нүүрсний нөөцтэй гэдэг нь дэлхийн нүүрсний судлагдсан нийт нөөцийн 10 хувь юм.

### Б.ЭНХЦЭЦЭГ

Зүүн хойд Азийн бүс нутагт Орос, Хятад, Монгол болон Хойд Солонгос улс ашигт малтмалын арвин нөөцтэй. Харин Өмнөд Солонгос, Япон улсын хувьд эрдэс баялгийн нөөц багатай учир ашигт малтмалын бүтээгдэхүүний эрэлт ихтэй худалдан авагч гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл,

энэ бүс нутагтаа Азийн таван барын эгнээнд зүй ёсоор багтдаг тэдний хувьд ноу хау, өндөр технологи гэх мэт давуу тал олонтой. Харин том хөршүүдтэй, баялаг ихтэй Монголыг газрын тос, төмөр замаар бараг л харцаараа хөдөлгөдөг нь ОХУ бол экспорт, импортын бүтээгдэхүүний ►

► цорын ганц гарц гэдгээр бардамнадаг нь Хятад. Тэд баян, бид ч бас баян. Ингээд бодохоор Зүүн хойд Ази нь эдийн засгийн гайхамшиг, ашигт малтмал, технологийн дэвшил, хүний хөгжил цөм бүрдсэн онцгой бүс нутаг болж таарах нь.

Хүссэн хүсээгүй Монгол дэлхийн эдийн засгийн тэр дундаа Зүүн хойд Азийн эдийн засгийн чухал хэсэг. Далайд гарцгүй ч энэ бүс нутгийн хамгийн ашигтай байршилд буюу хоёр их гүрний том зах зээлийн голд оршдог Монгол хэмээх их газрын энэ оронд дэлхийн улс орнуудын эрэлт хэрэгцээ болох алт, зэс, нүүрс, төмрийн хүдэр, газрын тос, уран гэх мэт бүх эрдэс бий.

Албан ёсны статистик мэдээгээр 2011 онд манай улсын нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 68 хувийг уул уурхай, олборлолт, боловсруулалтын салбар эзэлсэн байна. Уул уурхайн үйлдвэрлэлийн ашиг ийнхүү өссөн шалтгаан нь сүүлийн үед олон улсын зах зээл дээрх ашигт малтмал тэр дундаа зэс, алт, нүүрсний үнэ нэмэгдсэнтэй холбоотой. Ашигт малтмалын экспортын хэмжээ ч дагаад 71 хувиар нэмэгдэж, улмаар энэ оны эхний хагаст 992 сая ам.доллараас 1.7 тэрбум ам.доллар хүртэл өсчээ. Мөн нийт экспортын бүтээгдэхүүний 85 хувийг ашигт малтмал дангаараа эзэлж байгаагаас Хятад улс дийлэнх хувийг нь худалдан авчээ.

Манай улсын хувьд 1.6 тэрбум тонн нүүрсний нөөцтэй гэдэг нь дэлхийн нүүрсний судлагдсан нийт нөөцийн 10 хувь юм. Хоёр жилийн өмнө буюу 2010 онд 25 сая тонн нүүрс олборлож байсан бол 2011 онд 33 сая нүүрс гарган авч, 22 саяыг нь экспортолжээ. Мөн одоогоор тогтоосон 33 ордод 660 шахам сая тонн батлагдсан төмрийн хүдэр байгаа гэдэг. Монгол Улсын цэвэр зэсийн батлагдсан нөөц нь 36.3 сая тонн бөгөөд 2011 онд 117 мянган тонныг олборлосон нь урьд жилүүдийнхээс буурсан үзүүлэлт ч ирэх жилүүдэд энэ тоо тогтмол өсөх хандлагатай байна.

Түүнээс гадна манай улс уран, газрын ховор элементийн арвин нөөцтэй, ирээдүйд бүс нутгийн эрэлт, нийлүүлэлтэд голлох байр суурь эзлэх боломжтой. Хойд Солонгос нь манайхтай байгалийн баялгийн хувьд нэлээд төстэй бөгөөд мөн адил нүүрс, алт, цайр, магнезитийн нөөцтэй аж.

## Сул талыг давуу болгох нь

ОХУ-ын Сибирь, Алс Дорнод болон Монголын ашигт малтмалын гол зах зээл нь Хятад, Япон, Өмнөд Солонгос. Тус бүс нутгийн өсөн нэмэгдэж буй ашигт малтмалын түүхий эдийн эрэлт хэрэгцээг хангах нь технологийн болон дэд бүтцийн шинэчлэл хийх давхар боломж олгох сайн талтай. Энэ бүсийн хөгжил нь нэг талаас ашигт малтмал нөгөө талаас техник, технологийн хөгжил, дэвшилтэй нягт холбоотой аж. Тиймээс ашигт малтмалын түүхий эд хэрэглэдэг салбарууд технологийн хөгжил дэвшлийн ачаар ихээхэн өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа билээ. Гэвч дэд бүтцийн шинэчлэлийг авчрахын тулд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай нь мэдээж.

Өнгөрсөн хугацаанд Зүүн хойд Азийн орнуудаас манайд

орж ирсэн шууд хөрөнгө оруулалтын 80 гаруй хувийг Хятад эзэлж байгаа бол хоёр дахь нь Өмнөд Солонгос. Дээрх гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 65 хувь нь уул уурхайн салбарт оногдож байгаа гэдгийг Гадаадын хөрөнгө оруулалтын газраас мэдээлсэн юм.

Монголыг бусад бүс нутгийн орнуудтай харьцуулбал, дэлхийн голлох зах зээл Хятад улстай ойрхон учир ашигт малтмалаа нийлүүлэхэд газарзүйн асар том давуу талтай гэж үздэг. Улмаар энэ нь өрсөлдөх чадвар сайтай байхад ч нөлөөлнө гэж байгаа. “Дэлхийн уул уурхайн том компаниуд Хятадын зах зээл дээр гарах гэж тэмцэлдэж байна. Нэг талаас Хятадын том зах зээлтэй хилзалган оршдог нь бидний хувьд түүхэн боломж” хэмээн “FSCO Mongolia” компанийн

ерөнхий захирал Д.Жаргалсайхан хэлээд харин Зүүн хойд Азийн бусад оронд ашигт малтмал нийлүүлэхэд тээврийн зардал өндөртэй нь бидэнд хүндрэл учруулдаг талтайг мөн онцолсон билээ.

Урд хөршийн хувьд давуу талаа ашиглаж, монополь нөхцөл байдлыг бий болгодог ч өөрөө ашигт малтмалын бүтээгдэхүүний томоохон үйлдвэрлэгч юм. Харин уул уурхайн үйлдвэрлэлээрээ дэлхийд дээгүүр байранд ордог Орос коксжих нүүрс зэс, жоншны нөөц багатай учир тус улсын энэ төрлийн зах зээл нь манайд нээлттэй бөгөөд энэ төрлийн бүтээгдэхүүнийг Монголоос авах сонирхолтойгоо ч илэрхийлдэг. Тэгвэл яагаад эдгээр эрдсээ ОХУ руу экспортлож болохгүй байна вэ. Энд нөгөө л тээвэрлэлтийн өртөг өндөр томоохон саад тээглүүр болж байна. Монгол Улсын сул тал бол дэд бүтцийн дорой хөгжил.

ГХЯ-ны Азийн газрын захирал Б.Ганболд “Бид бүс нутгийн бусад оронд ашигт малтмалын бүтээгдэхүүнээ экспортлоход учирч буй хүндрэл буюу сул талаа давуу ►►



► болгон ашиглах боломжтой. Гэвч юуны өмнө эдийн засгийн болон улс төрийн тогтвортой байдлыг хангах, тэр дундаа хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь чухал. Мөн гол түнш орнуудтай хоёр болон олон талт чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах зэргээр бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн механизмуудыг чадамгай ашиглах ёстой” гэв.

Монгол Улс олборлосон ашигт малтмалаа бараг 100 хувь БНХАУ-д нийлүүлдэг. Тус улсад гаргаж буй ашигт малтмалын экспортын тал орчим хувийг нүүрс эзэлдэг, Үүнээс гадна зэсийн баяжмал, газрын тос, цайрын баяжмал орно. Өнгөрсөн онд манай улс Хятадын нийт коксжих нүүрсний импортын 45 хувийг нийлүүлжээ. Урд хөрш нь манай зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмалын гол зах зээл бол Өмнөд Солонгос нь молибдений хүдэр болон баяжмалын томоохон импортлогч юм.



Харин нийлүүлэлтийн хувьд цаашид тус бүс нутагт ОХУ, Монгол зэрэг орон зонхилох үүрэгтэй оролцох дүр зураг харагдаж байгааг мэргэжилтнүүд ярьж байна.

## Зүүн хойд Ази хаашаа явж байна вэ

Зүүн хойд Азийн орнуудын эдийн засгийн түргэн өсөлт нь түүхий эдийн эрэлтийг улам нэмэгдүүлж байна. Үүнд: Хятад, Өмнөд Солонгосын сүүлийн үеийн эдийн засгийн өсөлт дэлхийн дундажаас дээгүүр байгаа нь нөлөөлөхийн зэрэгцээ ОХУ, Монголын эдийн засгийн шинэчлэл ч өндөр өсөлтөд хувь нэмрээ оруулж буй аж. Урд хөршийн хувьд 2012 онд эдийн засаг нь найман хувиар өснө гэж шинжээчид үзэж байгаа ч тус улсын ашигт малтмалын хэрэглээ, аж үйлдвэрийн өсөлтөд дэлхийн эдийн засгийн байдал мөн нөлөөлөх бололтой байна. Мөн Европын холбооны ерийн хямрал гүнзгийрч, Хойд Америкийн эдийн засгийн өсөлт удаашрах төлөв нь зарим талаар Хятадын түүхий эдээс хамаарах хамаарлыг нэмэгдүүлэх нь тодорхой болоод байна гэдгийг ГХЯ-ны Азийн газрын захирал тэмдэглэсэн

юм.

Зүүн хойд азийнхан нэг талаас бие биенийхээ дутууг нөхөж, дундуурыг дүүргэх оюуны ба эдийн баялаг ихтэй ч эрэлт, хэрэглээний шуурга ширүүсч буй өнөө үед өөр хоорондоо өрсөлдөж, өрсөх нь эрчимжиж байна.

Бүс нутагтаа эрдсийн импортоос шууд хамааралтай Япон, Солонгос улс байгалийн баялгийн төлөөх тулаанд Хятадтай байнга тэмцэлддэг. Өмнөд Солонгосын Засгийн газар стратегийн ач холбогдол бүхий уран, нүүрс, төмрийн хүдэр зэрэг зургаан төрлийн эрдсийнхээ бусад улс орноос хангадаг 12 хувийг 2020 он гэхэд 43 хувь болтол өсгөхөөр төлөвлөж байгаагаа энэ онд мэдэгдсэн билээ. Экспортод хөтөлөгдсөн эдийн засагтай Солонгос орны хувьд ашигт малтмалын их хэмжээний тогтмол нийлүүлэлттэй болсноор дотоод нөөцийнхөө тал хувийг хадгалж, энэ нь хомсдол үүсэхэд гаргаж ирэх Б төлөвлөгөө нь болох учиртай гэнэ.

Харин Хятадын зэсийн хэрэгцээ ирэх жилүүдэд багасах тооцоо байгаа ч өнгөрсөн 20 жилд хэрэгцээ нь дунджаар 13.6 хувиар нэмэгдсэн нь цаашид үргэлжлэх төлөвтэй аж. Одоогоор нүүрснээс гаргаж авах эрчим хүчний хэмжээ нь багасч байгаа бөгөөд тус улсын Засгийн газар 2020 он гэхэд нийт эрчим хүчний 60 хувийг нүүрснээс гаргаж авахаар төлөвлөж байна. Гурван жилийн дараа буюу 2015 онд одоогийн эрчим хүчний жилийн хэрэглээ 90 сая тонн нүүрс нь 200 сая тоннд хүрэх аж. Тиймээс Хятадын нүүрс эрчим хүчний голлох эх үүсвэр нь байсаар байх бөгөөд түүнийг дагаад нүүрсний хэрэглээ нь гарцаагүй өснө гэдгийг Олон улсын энергийн агентлаг болон “Жи Пи Морган” санхүүгийн фирм саяхан мэдээлсэн билээ.

Зарим олон улсын байгууллагын судалгаагаар Хятадын эрдэс баялгийн хэрэгцээ 2020 он гэхэд одоогийнхоос 40 хувиар өсөх төлөв бий.

Харин манай хойд хөршийн хувьд Сибирь, Алс Дорнодоор дамжин өнгөрүүлэх нөөц бололцоо хязгаарлагдмал тул жилдээ 60 сая тонн бүтээгдэхүүн төмөр замаар зөөвөрлөн гаргах боломж байгаа аж. Тиймээс ОХУ түүхий эдийн экспортоо нэмэгдүүлэх үүднээс БНХАУ-ын Дачин руу газрын тосны хоолой мөн “Алтай” байгалийн хийн хоолойг тавьж эхлээд байгаа. Үүнээс гадна тус улс Хятадад нийлүүлэх цахилгаан эрчим хүчний экспортоо 60 дахин нэмэгдүүлэхээр тооцоолоод байгаа аж.

Зүүн хойд Азийн төвийн тоглогч Хятад нь Хойд Солонгостой ашигт малтмалын салбарт нягт хамтран ажилладаг цорын ганц түнш. Хойд Солонгос өнөөдөр уул уурхайгаас ихээхэн хамааралтайн хувьд ашигт малтмалын судалгаа шинжилгээгээ нарийвчилж, тоног төхөөрөмжөө шинэчлэхээр оролдож байна. Хятад, Хойд Солонгос хоёр улсын хамтарсан судалгааны баг саяхнаас эрдэс баялгийн эрэл хайгуул эхлүүлсэн бөгөөд өнгөт ба хар төмөрлөгийн эрдэст ихээхэн ач холбогдол өгч байгаа аж.

Зүүн хойд Азийн ашигт малтмалын эрэлт нийлүүлтийн тэмцэлдээнд Монгол нэгэнтээ том байр суурь эзлэх болсон ч байр сууриа бататгасан ганхашгүй бөх улс болохын тулд тоглоомын дүрэм, тоглогчдоо сайн мэддэг байх нь хамгаас чухал аж. Бидэнд сул тал олон бий. Гэвч сул тал зарим үед давуу тал болох нь бий. ■

## П.ОЧИРБАТ: ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ӨӨДӨӨС ШОРОО ЦАЦАХГҮЙ БАЙХ ЮМСАН

Уул уурхай Монголыг Азийн бар болгох шатандаа явна. Хөрөнгийн урсгал зах зээлээ даган урсдаг жамтай. XXI зууны эрэлтийг Ази тив тодорхойлж байна. Нийлүүлэлтийн боломж энэ тивд тухайлбал, Монголд тодорхой хэмжээгээр байна.

Б.БАЯРТОГТОХ



Фотог Ү.Одбаяр

*“Discover Mongolia-2012” чуулга уулзалтыг Зохион байгуулах хорооны дарга, уулын инженер, академич, Монгол Улсын анхны Ерөнхийлөгч асан Пунсалмаагийн Очирбаттай ярилцлаа.*

**-Өнөөдрийн өндөрлөгөөс “Discover Mongolia”-гийн 10 жилийн үүх түүх, алдаа оноог харахуйд ямар сэтгэгдэл төрж байна вэ?**

“Discover Mongolia” нэртэй чуулга уулзалтын 10 жилийн түүх бол Монгол Улсын эдийн засаг нээлттэй болсныг нотлох, Монголын хөгжилд гадаадын хөрөнгө оруулалтыг татах арга замыг оролцогч талуудын харилцан ашигтай хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлж болох эрэл хайгуулын түүх байлаа гэж хэлж болно. Ялангуяа Монголын эрдэс баялгийн салбарт олон талын хамтын ажиллагааны үүд хаалгыг нээж, 1990-2012 он хүртэлх хугацаанд тус салбарт оруулсан гадаадын хөрөнгө оруулалтын 90 орчим хувийг сүүлийн долоон жилд оруулсан байна. Үүний үр дүнд Монголын экспортын 90 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзлэх болжээ. Монголын эдийн засагт гарч буй эерэг үзүүлэлтэд өнгөрсөн арван жил зохион байгуулж ирсэн энэхүү чуулга уулзалтын тодорхой ажлын үр дүн шингэсэн.

**-Өнөөдөр анхны чуулга уулзалтын талаар дурсвал.**

-Дэлхийн зах зээл Монголд нээлттэй болж, үүн дотроо эрдэс баялгийн салбарт гаднын хөрөнгө оруулалтыг татах, аль болох нээлттэй байх хүсэл эрмэлзлэл тээсэн чуулга уулзалт 2002 онд анх болж байсан. Монголын уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт нээлттэй шүү гэсэн итгэл үнэмшлийг олон хүнд төрүүлсэн. “Дэлхийн хөрөнгө оруулагчдад Монголыг нээж өгье” гэсэн уриа дэвшүүлж, тэр зорилгодоо ▶

► хүрэхийн төлөө тууштай, жил бүр уламжлал болон зохион байгуулагдаж ирлээ. Гаднын хөрөнгө оруулагчдад Монголын баялгийг нээхэд хөрөнгө оруулж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэе гэсэн уриалгыг дэвшүүлсэн. Ерөөсөө дэлхийн хөрөнгийн капиталд Монголын эрдэс баялгийн салбарын анхны үүд хаалгыг нээсэн чуулга уулзалт болж байлаа. Үүгээрээ ач холбогдол нь үнэлэгдэх ёстой.

**–“Discover Mongolia” чуулга уулзалт олон “дүү” дагуулж байгаа. Энэ жилийн чуулга уулзалт урьд жилүүдийнхээс ямар онцлогтой болох вэ?**

–Энэхүү чуулганы жишээгээр эрдэс баялгийн цогцолборын геологийн, нүүрсний, металлын зэрэг салбар чиглэлээр олон улсын чуулга уулзалт байнга зохион байгуулагдаж байна. Энэ оны чуулганы гол онцлог нь “Хайгуул олборлолтоос боловсруулалт өөд” гэсэн шинэ зорилт дэвшүүлж байгаад оршино.

**–“Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” шинэ хуулийг уул уурхайн салбарынхан таатай хүлээж аваагүй, тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулагчид. Магадгүй чуулга уулзалтын хамгийн халуун сэдэв энэ шинэ хууль болно байх. Та шинэ хуулийн талаар ямар бодолтой байна вэ?**

–Газрын хэвлийн баялаг төрийн өмч байдгийн хувьд түүнд төрийн зохицуулалт байх ёстой. Асуудлын гол нь манайхан зах зээлийн харилцааны ерөнхий зарчимд нийцэхгүй зохицуулалт их хийж байна. Аливаа аж ахуйн нэгжийн хувьцаа эзэмших боломж чөлөөтэй байх ёстой. Үндэсний хуримтлал багатай манай улсын хувьд эрсдэл, хөрөнгийн багтаамж ихтэй эрдэс баялгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах нь геоэдийн засгийн бодлогын хувьд оновчтой биш зохицуулалт.

Гаднынхан Монгол Улсын хуулийг нэг их шүүмжилж ярихгүй байх. Тэд соёлтой хүмүүс. Тэдэнд хохирол учирсан тохиолдолд олон улсын шүүхэд зарга мэдүүлээд хохирлынхоо

асуудлыг шийдвэрлүүлчихнэ. Харин гадаадынхан хөрөнгө оруулахаасаа болгоомжилж эхэлбэл манайд хохиролтой байж мэднэ.

Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд “Тогтвортой байдлын гэрээ”-ний тухай нэг зохицуулалт байдаг. Уг нь төрийн бодлого нь тодорхой, эрх зүйн орчин нь тогтвортой байдаг улстай Тогтвортой байдлын гэрээ байгуулах шаардлага байдаггүй. Манайд энэ бүхэн тогтворгүй учраас л түүнийгээ барьцаа болгож Тогтвортой байдлын гэрээ байгуулдаг. Эцэст нь хуулийн дагуу ийм гэрээ байгуулсан этгээдээ хараан зүхэж, шонд дүүжилж, шоронд хатаах юм ярьдаг. Уг нь бизнесийнхээ соёлыг дээшлүүлчихвэл ийм гэрээ байгуулах шаардлагагүй л дээ.

**–Тэгвэл одоо хэрэгжиж буй Ашигт малтмалын тухай хууль хэр төгс хууль вэ. Тус хуульд ямар өөрчлөлт, зүйл заалт дутагдалтай байна вэ?**

–Аливаа хуулийг төгс төгөлдөр гэж үнэлэх хэцүү. Амьдрал баян, хүний эрэлт хязгааргүй. Үүнтэй уялдан аливаа хуулийн үйлчлэх хүрээг хязгаарлах, тэлэх, орон зайг оновчтой тогтоох шаардлагатай байдаг. Монгол Улсын хувьд тодорхой хугацаанд / ойрын 30-40 жилд/ газрын хэвлийн баялгийг судлах, хайх, олборлох, боловсруулах хүрээг тэлэх замаар эдийн засгийн бүтцийг өөрчилж, олон салбартай, нийгмийн хөгжлийг хангах хуримтлалтай болох нөхцлийг бүрдүүлэх шаардлага байгаа юм. Ашигт малтмалын хууль дээрх шаардлагад нийцсэн байх ёстой. Тус хуульд байгаль, экологийн тэнцвэрийг хадгалахаас өөр хязгаарлалт тавих шаардлагагүй.

**–Боловсруулах үйлдвэр, түүнийг дагасан дэд бүтэц, тээвэрлэлтийн асуудал анхаарлын тэмдэгт үлдэж байна. Оюутолгой, Тавантолгойн ордыг дагасан “Эрдэнэт” хот шиг шинэ суурин сүндэрлэх боломжийг та хэрхэн харж байна вэ?**

–Зах зээлийн зарчмаар эдийн засгийн суурь бүтцийг улс өөрөө бүрдүүлдэг. Суурь бүтэц гэдэг нь түлш, эрчим хүч, тээвэр, холбоо, усан хангамж зэргийг хэлдэг. Би үүнийг

дэд бүтэц гэж нэрлээд заншчихсан. Хот байгуулалт бол нийгмийн нэгэн дэд бүтэц. Суурь бүтцээ түшиглэж аж үйлдвэр, эдийн засгийн дэд бүтэц хөгждөг. Уул уурхайн үйлдвэрлэлд нэг өвөрмөц онцлог байдаг. Тэр нь тухайн орд газрыг эзэмших асуудал нь хот байгуулалтын үндэс болдог. Эрдэнэт, Бор-Өндөр, Багануур, Шарын гол, Налайх зэрэг хот, тосгон, суурин уурхайг түшиглэн байгуулагдсан. Гадаадад ч ийм л зарчмаар цөөнгүй хот, тосгон байгуулсан байдаг.

Оюутолгой, Тавантолгойн тухайд ийм зарчмаар хэрэгжих байх. Зах зээлийн нөхцөлд уурхайчдын хот тосгон барьж байгуулах арга хэлбэр арай өвөрмөц хэлбэртэй байх болов уу. Нийгмийн зориулалттай сургууль, эмнэлэг, театр, спортын болон инженерийн байгууламжийг төрийн санхүүжилтээр, орон сууцны барилгуудыг төлөвлөгөөний дагуу хувийн хөрөнгө оруулалтаар, худалдаж авах замаар Эрдэнэт шиг шинэ суурин сүндэрлэх боломж бий.

Өмнөговийн Цогтцэций суманд Ухаа худгийн уурхай уурхайчдынхаа тосгоныг бариад эхэлчихсэн. Төвлөрсөн цахилгаан хангамж, ус, дулааны асуудлыг шийдсэн бэлээхэн туршлага байна. Оюутолгойнон Ханбогд сумын төвийг өргөтгөх замаар хот байгуулалтаа шийдвэрлэх хувилбар ярьдаг. Үйлдвэрийн барилга байгуулалтын үед “Ирж ажиллаад буцаад харьдаг” ажлын горимыг 1974 оноос Өрнөдийн орнуудад нэвтрүүлж эхэлсэн нь одоо манай зарим уурхайд хэрэглэгдэж байна. Аливаад сайн муу юм зэрэгцэн оршдог болохоор энд ч бас сайн муу тал бий.

**–Гадаадын хөрөнгө оруулалттай хамт санхүүгийн эрх чөлөө, менежментийн болон технологийн ноу-хау орж ирдэг гэдэг. Тэгвэл өнгөрсөн хугацаанд уул уурхайн салбарт технологийн шинэчлэлт, түүнийг дагасан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөн үү. Төрөөс ямар бодлогоор дэмжих хэрэгтэй вэ?**

–Хөрөнгө оруулагч бүр өөрийн хөрөнгийг хамгийн үр ашигтай, өрсөлдөх чадвартай зарцуулахыг зорьдог. Энэ бол зах зээлийн жам, хууль. Тийм учраас хамгийн ►

▶ тэргүүний технологи, менежментийг сонгож хэрэглэдэг. Хамгийн ашигтай, найдвартай зах зээлийг сонгодог гэсэн үг. Ийм зарчмыг Оюутолгой, Ухаа худаг, Нарийн сухайтын ордуудыг ашиглахад хэрэглэснийг би мэднэ. Нүдээр үзсэн. Дэлхийд дэлгэрч амжаагүй ховор технологи, ноу-хауг дээрх уурхайнууд ашиглаж байгаа. Оюутолгойн хайгуулд хэрэглэсэн цооногоос салаалуулж цооног өрөмдсөн “модны үндэс” технологи, “өөрөөр нь блоклон нураах” ашиглалтын систем зэрэг олон ноу-хау бий. Ус чандмань эрдэнэ зарчмыг агуулсан усны нэвчилт, ууршилтаас хамгаалсан хаалттай усан сангийн байгууламж, усныхаа хэрэгцээний 90 гаруй хувийг эргэлтийн усаар хангах зэрэг шинэ технологиуд нэвтэрч байна. Ухаа худагт коксжих нүүрсийг баяжуулах фабрик байгуулан ашиглаж нэмүү өртөгтэй шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулж байна.

Оюутолгойн алт-эсийн баяжмалын тодорхой хэсгийн хайлах, цэвэршүүлэх үйлдвэрийг Монгол Улс өөрөө хөрөнгө босгож байгуулах нь чухал. Кокс-химийн үйлдвэр байгуулах асуудлыг Монголын тал өөрөө гангийн үйлдвэр байгуулах асуудлыг Хятад, Энэтхэг улсуудтай харилцан ашигтай байх нөхцлийг олж шийдвэрлэх. Эдгээрийг хөгжүүлэхэд шаардлагатай суурь бүтцийг тэр өөрөө буй болгох шаардлагатай. Төрийн бодлого ийм л ажилд чиглэвэл зохино. Уул уурхайгаас олсон орлогын нэг хэсгийг УИХ-ын гишүүдийн мэдэлд тарааж өгөөд нөгөө хэсгийг нь сонгуулийн амлалтад цацаад байж болохгүй.

**-Экспортын 90 гаруй хувийг эзэлж буй уул уурхайн бүтээгдэхүүнд экспортын татвар тогтоох шаардлага бий юү?**

-Уул уурхайн бүтээгдэхүүнийг тухайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг харгалзан экспортын татварын хэмжээг тогтоож болно. Уул уурхайн бүтээгдэхүүнд олборлосон хүдэр, нүүрс байна. Баяжмалууд нь зэсийн, молибдений, алтны, төмрийн, жоншны, цайрын, тугалганы, вольфрамын, ураны шав нунтаг, нүүрс. Цэвэршүүлсэн алт, зэс, цайр, тугалаг, ган, вольфрам, кокс, хий, нүүрсний болон занарын тос гэх мэт.

Түүхий эдийн түвшинд байгаа уул уурхайн бүтээгдэхүүнд экспортын татвар тогтоож харин нэмүү үнэтэй боловсруулсан бүтээгдэхүүнд экспортын татвар тогтоохгүй байж болно.

**-Өнгөрсөн жилийн “Discover Mongolia” чуулга уулзалтын үеэр хариуцлагатай уул уурхайн асуудлыг түлхүү хөндөж байсан. Үүний үр дүн энэ онд гарсан уу?**

-Уул уурхайн ажлыг хариуцлагагүй эрхэлж буй аж ахуйн нэгж цөөнгүй байна. Тэдгээрийг төрийн хуулийн дагуу дэглэх хэрэгтэй. Уул уурхайн нэр барьсан нэн хариуцлагагүй “нинжа” нар хэмээх этгээдийг хуулийн дагуу журамлаж, аж ахуй эрхлэгч, мэргэжлийн байгууллагатай хоршиж ажиллах, бие даасан аж ахуйн нэгж артелийн зохион байгуулалтад оруулж, хяналттай, дэг журамтай болгох хэрэгтэй. “Хариуцлагатай уул уурхай”-г нэг удаа яриад цэгцэлнэ гэвэл гоомой хэрэг болно. Үүнийг байнга ярьж, хатуу шаардаж, тэсэж үлдэх эсэхийг нь хуулийн биелэлтээр шалгаруулдаг байвал зохино. Үүний тулд хууль бодитой, үндэслэл сайтай байх ёстой.

**-“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор барихаар ТЭЗҮ болон хөрөнгийн асуудал нь тодорхой болоод ирлээ. Уул уурхайн боловсруулах үйлдвэрийн салбар шинэ шатанд гарах гарц нээгдэж байна гэж үзэж болох уу. Төрөөс бодлогоор боловсруулах үйлдвэрийн салбараа хэрхэн дэмжих ёстой вэ?**

-Аж үйлдвэрийн цогцолборыг байгуулах үндсэн зарчим бол нэгдүгээрт, боловсруулах түүхий эдийнхээ баазыг түшиглэсэн байх, хоёрдугаарт, суурь бүтэцдээ ойр байх, гуравдугаарт, хүний нөөц, хөгжилтэй холбогдсон дэд бүтцийг харгалзахад оршдог. Сайншанд энэ зарчимд хэр нийцэж байгаа юм бол доо.

Уул уурхайн боловсруулах үйлдвэрийг шинэ шатанд гаргах газар Сайншанд гэж үзэх үндэслэл байхгүй. Боловсруулах үйлдвэрийн түүхий эд болгон техник, эдийн засгийн өвөрмөц шалгууртай. Хүдэр, нүүрс мэтийн хатуу ашигт малтмалыг боловсруулах үйлдвэрийн цогцолбор ордынхоо

орчимд байх нь илүү ашигтай байдаг бол нефть боловсруулах үйлдвэр нь хэрэглэгчдээ ойр байх нь экологи, эдийн засгийн болон аюулгүй байдал талаасаа илүү найдвартай гэж үздэг. Боловсруулах үйлдвэрийн байршлыг ямар чиглэл барьж хаана хөгжүүлэхээ сонгох, үйлдвэрлэх хүчний хөгжил байршлыг тодорхойлдог шинжлэх ухаанд тулгуурлаж уг асуудлыг шийдвэрлэх ёстой. Энэ бол дур зоргоороо шийдэх хэрэг биш л дээ.

**-Дэлхийн уул уурхайн салбарын хөгжлийн хандлага хаашаа замнаж байна вэ. Тэр дунд Монголын уул уурхайн салбарын хөгжил хаана нь явна вэ?**

-Хүн төрөлхтөн амьдралынхаа хэрэгцээний 90 хувийг байгалийн баялгаас авч хэрэглэдэг. Дэлхийн хүн ам эрчимтэй өсөж байна. Үүнийг дагаад эрдэс баялгийн түүхий эдийн хэрэглээ өсөж, нөөц нь багасна. Дэлхийн уул уурхайн үйлдвэрлэл нь эрдэс баялгийн нөөцтэй орныг түшиглэж хөгжинө. Хөрөнгө, технологи, менежментийн урсгал тэр зүгт чиглэнэ гэсэн үг. Технологийн инновацын үйл явц түргэсэж экотехнологийн түвшинд хүрнэ.

Эрчим хүчний хангамж дэлхийн хэмжээний асуудал. Үүнийг шийдвэрлэх гол эх үүсвэр нь нүүрс, шатах занар, уран, нар, салхи, ус. Нефть, байгалийн хийн нөөц харьцангуй бага, үнэт чанар өндөртэй учир эрчим хүчний эх үүсвэр гэхээсээ химийн үйлдвэрийн олон зуун нэр төрлийн бүтээгдэхүүний түүхий эд болгон ашиглах нь илүү ач холбогдолтой. Монгол Улсын эрчим хүчний хатуу түлшний эх үүсвэр нүүрс, шатах чанар, ураны олборлолт боловсруулалтад чиглэсэн түлш эрчим хүчний цогцолборын хөгжлийг тэргүүлэх чиглэлтэй байна. Энэхүү цогцолборын анхдагч нь уул уурхайн үйлдвэрлэл.

Технологийн инновацыг дагаад алт, мөнгө, зэс, ховор металл, газрын ховор элемент зэрэг бага оврын металлын хэрэгцээ нэмэгдэнэ. Үүнийг дагасан уул уурхайн өнгөт төмөрлөгийн цогцолбор Монголд хөгжих учиртай. Хөгжиж буй болон өндөр хөгжилтэй орнуудын металл байгууламжийн хэрэгцээ цаашид ▶

► нэмэгдэнэ. Мөн хөгжилтэй орнууд “ядаргаанд” орсон металл хийц байгууламжуудаа сэлбэж шинэчлэнэ. Хөгжиж байгаа нь ялангуяа бүс нутагт барьж байгуулах инженерийн болон иргэний байгууламжийн металлын хэрэгцээ асар их. Үүнийг дагаж уул уурхайн хар төмөрлөгийн цогцолбор Монголд хөгжих өргөн боломж бий.

Уул уурхай Монголыг Азийн бар болгох шатандаа явна. Хөрөнгийн урсгал зах зээлээ даган урсдаг жамтай. XXI зууны эрэлтийг Ази тив тодорхойлж байна. Нийлүүлэлтийн боломж энэ тивд тухайлбал, Монголд тодорхой хэмжээгээр байна.

**-Гаднын хөрөнгө оруулагчдын сонирхол, тэдний хөрөнгө оруулалтын урсгал алсдаа хаашаа чиглэх бол. Наана нь бид ямар стандарт, шалгуур, нөхцөл болзол хангах шаардлагатай вэ?**

-Дэлхийн зах зээлтэй, дэлхийн стандарт, зах зээлийн жам дүрмээр л харьцаж сурах хэрэгтэй. Дангаарших юмаа дотроо үлдээж даяаршлын зарчмаар дэлхийтэй харьцахаас өөр зам байхгүй. Бусдын сүмд өөрийн тарнтай орж болдоггүй юм гэдэг. Хөрөнгө оруулагчдын өөдөөс шороо цацахгүй байх юмсан. Хэн хэндээ харилцан ашигтай байх хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого бариасай. Дэлхийн үнийн супер өсөлтийн мөчлөг дуусахаас өмнө амжиж өргөн цар хүрээтэй нэлээн хэдэн төслийн тохиролцоо хийгээд авахад бодлогоо чиглүүлээсэй гэж бодож сууна.

Уул уурхайн хөгжлийн хандлагад нэмж хэлэх зүйл гэвэл нээж олсон баялаг бүрээ зараад байж болохгүй. Үүцлэх юмаа хадгалж үлдэх ёстой. Энэ асуудлыг зах зээл, үнэ ханш, технологийн хөгжлийн чиглэлийг нарийн судалж шинжлэх ухаанд үндэслэн уян хатан зохицуулж байвал зохино.

**-Азийн бүс нутгийн уул уурхайн хөгжлийн хэтийн төлөв ямар байна вэ. Бид уурхайн ямар бүтээгдэхүүнээ үйлдвэрлэлд түлхүү чиглүүлж, аль эрдэс баялгаа хямгадах учиртай вэ?**

-Би өмнөд хөршийнхөө эрчимтэй хөгжлийг өөрийн орны хөгжлийн хүчин зүйл болгон ашиглах хэрэгтэй.

Ихэнх тохиолдолд овор ихтэй, даац хүндтэй байдаг уул уурхайн бүтээгдэхүүний хэрэглэгч ойр байх тусам ашигтай байдаг хуультай. Тийм болохоор бид ашигтай зах зээлд л борлуулалтаа хийх ёстой шүү дээ. Эцсийн эцэст аливаа бүтээгдэхүүнийг борлуулахын тулд л үйлдвэрлэдэг биз дээ. Гэхдээ бидэнд бас бодох юм бий. Бид бүтээгдэхүүнээ зах зээлийн үнээр, ханган нийлүүлэх үнээр борлуулж чадаж байна уу гэдгийг бодох л хэрэгтэй.

Дэлхийн эдийн засгийн шинэ загварт шилжих хэрэгтэй. Геоэдийн засгийн шинэ загвар нь даяарчлагдсан системт иргэншлийн

**Энэ удаагийн чуулга  
уулзалтаас уул  
уурхайн боловсруулах  
үйлдвэрийн  
технологийн шинэ  
чигүүд гарч ирэх байх  
гэж хүлээж байна.  
Уул уурхайгаас орж  
ирж буй орлогыг  
монголчууд хэрхэн  
хөгжлийн хүчин зүйл  
болгон зөв ашиглах  
асуудал хөндөгдөж  
яригдана.**

олон шинэ үнэт зүйл агуулсан загвар юм. Тухайлбал, “Стратегийн үр ашиг” гэдэг шинэ категори байна. Энэ нь сонгодог эдийн засгийн ашиг гэдэг ойлголтоос илүү дээд зэрэглэлийн үзүүлэлт юм. Үүний эдийн засгийн шинэ агуулга логик нь өртгийн хуулийн үйлчилгээний хүрээнд урьд өмнө нь тусгагддаггүй байсан үндэс угсааны, сэтгэл зүйн, уламжлалт харилцааны, оюун санааны зэрэг олон хүчин зүйлийг оролцуулан тооцохыг чухалд үзэж байна.

Стратегийн үр ашиг гэдэг нь дэлхийн орлого руу нэвтэрч орох, стратегийн тэнцвэрийг

олох, интернациональжсан нөхөн үйлдвэрлэлийн сүлжээг үүсгэх зэрэг геоэдийн засгийн механизмыг ашиглан Дэлхийн геоэдийн засгийн зураг дээр идэвхтэй ажилласнаар олох үр дүн юм. Манайхны баримталдаг гурав дахь хөршийн бодлого, нэг зах зээлээс хэт хамааралтай байхаас зайлсхийх зэрэг бодлого геоэдийн засгийн бодлогын шинэ агуулгатай нийцэж байгаа юм.

**-Манай улсын хувьд өмнөд хөршдөө уул уурхайн бүтээгдэхүүнээ экспортолсоор өнөөг хүрлээ. Шинэ зах зээл, шинэ үүд хаалга нээх боломж бий юү?**

-Манай улсын уул уурхайн салбарын хөгжлийн жанжин шугам нь Монгол Улсаа ойрын 10 жилд цахилгаан энерги импортлогч орноос экспортлогч орон болгох, уул уурхай металлургийн цогцолборуудыг байгальд ээлтэй экотехнологиор хөгжүүлсэн улс болгох, эрдэс баялгийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэлхийн стандартад хүргэсэн байх зэрэг бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Байгалийн баялгийн орлогоос иргэддээ хүртээх асуудал дэлхийн улс орнуудад онолын хувьд их маргаантай байдаг. Практик дээр ч оновчтой тогтсон аргачлалгүй, ихэнх тохиолдолд төгс хүрээнд нийгмийн үйлчилгээгээр дамжуулан хүргэдэг хэлбэртэй байдаг. Монгол Улс ашигт малтмалын ордын хувьцааны тодорхой хэсгийг иргэддээ үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн нь дэлхийд шинэ зүйл. Энэхүү хөрөнгөө хэрхэн захиран зарцуулах нь хувьцаа эзэмшигчдийн мэдлийн ажил юм даа.

Энэ удаагийн чуулга уулзалтаас уул уурхайн боловсруулах үйлдвэрийн технологийн шинэ чигүүд гарч ирэх байх гэж хүлээж байна. Уул уурхайгаас орж ирж буй орлогыг монголчууд хэрхэн хөгжлийн хүчин зүйл болгон зөв ашиглах асуудал хөндөгдөж яригдана. Төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө хамтарч ажиллах боломжийн талаар тал бүрээс нь санал бодлоо солилцох ач холбогдолтой гэж үзэж байна. ■

## БОДЛОГОО ХЭРЭГЖҮҮЛЭХ Л ҮЛДЛЭЭ

### Б.ТОГТОХ

#### Зам

Манай улс өнөөдөр нийтдээ 6734.4 км урт сайжруулсан авто замтай. Үүнээс 3015.6 нь км хатуу хучилттай, 1815 км нь төмөр зам юм. Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамнаас боловсруулсан тооцоогоор жилд дунджаар 500-800 км зам барьж байж 2016 он гэхэд 21 аймгийн төвийг нийслэлтэй холбоно гэсэн судалгааг хийжээ. Жилд дунджаар 100-160 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн урьдчилсан дүн мэдээ ч бий. Энэ нь манай ДНБ-ий хоёр хувьтай тэнцэх хөрөнгө юм.

Уул уурхайн бүс нутаг гэж хэлж болох Өмнөговь аймагт хувийн хөрөнгө оруулалтаар компаниуд хатуу хучилттай зам барьж байгаа хэдий ч дэд бүтцийн хөгжил муу хэвээр байна. “Тавантолгойн уурхай”-гаас Цагаан хад хүртэлх замд л гэхэд 2010 оноос хойш 40 гаруй автын осол гарсан бөгөөд тус замд тээвэрлэлт хийхийг МХЕГ-аас хоригложээ. Шалтгаан нь мөнөөх зам. Харин Ухаа худагаас Гашуун сухайт хүртэл хатуу хучилттай авто зам барихаар “Эрдэнэс Тавантолгой”, “Тавантолгой” компаниуд хоорондоо ярилцаж байгаа аж. Монгол Улсын Засгийн газраас зам тээврийн сүлжээний сайжруулалтад зориулсан хөрөнгө оруулалтыг харахад 2009 онд 94.7 тэрбум, 2010 онд 109.2 тэрбум байсан бол 2011 онд 166.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулжээ.

#### Төмөр зам

Төмөр замын тээврийн төрийн бодлогын хүрээнд 2011-2014 оны хооронд ойролцоогоор 5.684 км шинэ төмөр зам барихаар тогтжээ. Монгол Улсын төмөр замд төрөөс баримтлах бодлогын дагуу Даланзадгад-Чойбалсан хүртэл 1100 км зам тавьж, дараагийн ээлжинд Нарийн Сухайт-Шивээхүрэн, Ухаахудаг-Гашуунсухайт, Хөөт-Нөмрөг, Хөөт-Бичигт чиглэлд нийт 900 км зам тавихаар Засгийн газраас баталжээ. Энэ хүрээнд төрөөс зүүн аймгуудыг хамрах “Хөөт-бичигт” чиглэлийн төмөр замын техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийг боловсруулах судалгаа, шинжилгээг хийгээд эхэлсэн байна.

Харин баруун бүсийн төмөр зам буюу “Баруун босоо тэнхлэг”-т шинээр төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажилд хоёр жилийн хугацааг заажээ.

Тус төмөр замыг төр хувийн хэвшилтэй хамтарч концессын гэрээгээр барих бөгөөд ирэх есдүгээр сарын 1 гэхэд ажлын даалгавраа боловсруулаад, зөвлөх



шалгаруулах тендерийг зарлан явуулж, энэ оны сүүлчээр ялагчийг тодруулах юм байна.

Дэлхийн банкны Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн зохицуулагч Б.Энхбаатар “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын гуравдугаар үе шат буюу баруун босоо чиглэлийн төмөр замын судалгааны ажлыг эхлүүлсэн. Өөрөөр хэлбэл, ямар маршрутаар аль чиглэлд хэр хэмжээний төмөр зам барихыг судлана. Төрийн бодлогод өргөн царигтай төмөр зам тавихаар тусгасан. Бид хамгийн бага өртгөөр баруун бүсийн ордуудын ашигт малтмалыг тээвэрлэх ажлыг эхлүүлж байна. Баруун бүсэд Хөшөөтийн коксжих нүүрс, Баян айргийн алт, зэс, Таян нуурын төмрийн хүдэр гээд том ордууд байгаа. Цаашид манай улсын хувьд уул уурхайг хөгжүүлэх үндсэн гарц бол төмөр зам. Байгаль экологид сөрөг нөлөө бага төмөр замаар ашигт малтмалаа тээвэрлэж экспортлох нь эдийн засгийн хувьд ч үр өгөөж нь маш өндөр” хэмээн ярьсан.

Засгийн газраас Эрдэнэт-Мөрөн-Овоотын чиглэлд 628 км төмөр зам барихаар шийдвэрлэсэн. Уг төмөр замыг барихад ойролцоогоор 2.2 тэрбум ам.доллар шаардлагатай бөгөөд тус төмөр замаар жилдээ Овоот-Мөрөнгийн чиглэлд 13.5 сая тонн, Мөрөн-Эрдэнэтийн чиглэлд 22.2 сая тонн ачаа тээвэрлэж хоногт 11-18 хос галт тэрэг нэвтэрнэ хэмээн төлөвлөжээ.

Одоогийн байдлаар уул уурхайн салбарыг дэмжих зам тээврийн бодлогын хүрээнд Монгол Улсын үндэсний замын сүлжээний төрийн нэгдсэн бодлого, Төмөр замын тээврийн төрийн бодлогыг хэрэгжүүлж байна. Эдгээр бодлогын зорилго нь уул уурхайн гол бүс нутагт орших нүүрсний орд газруудад анхаарал хандуулж, авто болон төмөр замаар тээвэрлэх нүүрсний тээвэрлэлтийг хөнгөвчлөх дэд бүтцийг сайжруулахад орших аж. Тэгэхээр бодлого нь буйгаа боловч хэрэгжүүлэлт дутаад байгаа нь харагдана. ■

# DISCOVER MONGOLIA 2012

2012 ОНЫ НАЙМДУГААР САРЫН 30-31

## PREMIER:



## PLATINUM:



## GOLD SPONSORS:



## SPONSORS:



## EVENT SPONSORS:



What drives you *drives us...*



## ORGANIZER:



## SUPPORTERS:



info@discovermongoliaforum.com  
www.discovermongoliaforum.com

## “Discover Mongolia”-2012 БАГА ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

|   |
|---|
| <b>2012 оны 8 сарын 29 (Чуулганы бүртгэл нээгдэнэ)</b><br>Хүүхдийн ордонд бүртгэл эхэлнэ  |
| <b>2012 оны 8 сарын 30 (Чуулганы эхний өдөр)</b>  |
| <b>1-Р ХУРАЛДААН: НЭЭЛТИЙН ИЛТГЭЛҮҮД</b><br>Хурлын дарга: П.Очирбат, Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, чуулга уулзалтын Зохион Байгуулах Хорооны Тэргүүн                |
| П.Очирбат, Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, чуулга уулзалтын Зохион Байгуулах Хорооны Тэргүүн<br><b>"Хайгуул олборлолтоос хөгжил дэвшил өөд"</b>                       |
| Карр МакКарди, Бер Долбер группын ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал<br><b>"Уул уурхайгаас эдийн засгийн салбаруудад үзүүлэх нөлөөллийн үнэлгээний аргачлал"</b>          |
| Питр Николлс, Оюу Толгой компанийн дэд ерөнхийлөгч<br><b>"Оюу Толгойн бүтээн байгуулалт/ Оюу Толгой - Монголын бахархал"</b>  |
| Н.Золжаргал, Монголбанкны дэд ерөнхийлөгч<br><b>"Уул уурхайн салбараас Монголын эдийн засагт болон мөнгөний бодлогод үзүүлэх нөлөөлөл"</b>                            |
| Урбан Раснак, Эрчим Хүчний Хартийн ерөнхий нарийн бичгийн дарга<br><b>"Зүүн хойд Ази дахь эрчим хүчний эрэлт нийлүүлэлт"</b>  |
| <b>ЦАЙ КОФЕНЫ ЗАВСАРЛАГА (1-Р ХУРАЛДААН ӨНДӨРЛӨНӨ)</b>  |
| <b>2-Р ХУРАЛДААН: ЭРДСИЙН НӨӨЦИЙН НӨХӨН ҮЙЛДВЭРЛЭЛ</b><br>Хурлын дарга: Д.Жаргалсайхан, Эм Ай Эйч Группын Ерөнхийлөгч   |
| Питер Акерли, Эрдэнэ Ресурс компанийн ерөнхийлөгч<br><b>"Алтан нар: Баруун өмнөд Монгол дахь Алтны шинэ илрэл"</b>  |
| Дэвид Полл, Аспайр Майнинг Лимитед компанийн гүйцэтгэх захирал<br><b>"Монголын хойд хэсэгт хөрөнгө оруулалтын анхаарлыг хандуулах нь"</b>                             |
| Андроу Стюарт, Занаду Майнс компанийн Монголыг хариуцсан менежер, ахлах геологич<br><b>"Зэс-Алтны шилдэг компанийг байгуулах нь"</b>                                  |
| Д.Жаргалсайхан, Эм Ай Эйч группын ерөнхийлөгч<br><b>"Эрдсийн нөөцийн нөхөн үйлдвэрлэл туршлага"</b>   |
| Б.Оюунгэрэл, Сноудэн группын зөвлөх геологич<br><b>"CRIRSCO ба Монгол Улс"</b>  |
| <b>АСУУЛТ, ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>   |
| <b>ҮДИЙН ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА (2-Р ХУРАЛДААН ӨНДӨРЛӨНӨ)</b>   |
| <b>3-Р ХУРАЛДААН: ОЛБОРЛОЛТ</b><br>Хурлын дарга: Д.Дамба, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн Ерөнхийлөгч   |
| Маттиу Гили, Оюу Толгой компанийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал<br><b>"Эхний хүдэр"</b>  |
| Г.Батцэнгэл, Энержи Ресурс компанийн гүйцэтгэх захирал<br><b>"Монгол улс дахь нүүрсний уурхайн олборлолт: давуу болон сул талууд"</b>                                 |
| Граем Ханкок, Эрдэнэс Таван Толгой компанийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал<br><b>"Таван Толгой төслийн өнөөгийн нөхцөл байдал"</b>                                   |
| Грахам Чапман, Шарын Гол компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн<br><b>"Шарын Гол: Шинэ эхлэл"</b>  |
| Иан Ранги, Ранги Лимитед группын ерөнхийлөгч<br><b>"Уул уурхайн эдийн засаг"</b>  |
| Д.Дамба, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн ерөнхийлөгч<br><b>"Уул уурхайн салбарт тулгамдсан асуудлууд"</b>   |
| <b>ЦАЙ КОФЕНЫ ЗАВСАРЛАГА (3-Р ХУРАЛДААН ӨНДӨРЛӨНӨ)</b>  |
| <b>4-Р ХУРАЛДААН: ЗҮҮН ХОЙД АЗИ ДАХЬ АШИГТ МАЛТМАЛЫН ЭРЭЛТ НИЙЛҮҮЛЭЛТ</b><br>Хурлын дарга: Д.Төрбат, Бэр Долбэр Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирал                      |
| Кулешов Владимир Владимирович, Оросын шинжлэх ухааны академийн Эдийн засаг, үйлдвэрлэлийн институтын дарга<br><b>"Орос улс дахь ашигт малтмалын эрэлт нийлүүлэлт"</b> |
| Гён Чул Ким, Солонгосын тээврийн институтын ерөнхийлөгч<br><b>"Солонгос улс дахь ашигт малтмалын эрэлт нийлүүлэлт"</b>  |

|   |
|---|
| Ёошиаки Нишимура, Зүүн хойд Азийн Эдийн засгийн судалгааны институтын дарга<br>"Япон улс дахь ашигт малтмалын эрэлт нийлүүлэлт"   |
| Чи Рен Жоу, Хятадын Эдийн засгийн судалгааны төвийн дарга<br>"Хятад улс дахь ашигт малтмалын эрэлт нийлүүлэлт"  |
| М.Уянга, Эрнст Энд Йонг Монголиа компанийн гүйцэтгэх захирал<br>"Уул уурхайн салбар дахь олон улсын бизнесийн эрсдэл 2012-2013"   |
| <b>АСУУЛТ, ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>   |
| <b>ХҮЛЭЭН АВАЛТ (ЧУУЛГАНЫ ЭХНИЙ ӨДӨР ӨНДӨРЛӨНӨ)</b>   |
| <b>2012 оны 8 сарын 31 (Чуулганы удаах өдөр)</b>  |
| <b>5-Р ХУРАЛДААН: СУУРЬ БҮТЦИЙН ХӨГЖИЛ</b><br>Хурлын дарга: Э.Содонтогос, Ньюком Группын харилцаа, хамтын ажиллагаа эрхэлсэн захирал  |
| Чой Жонг Күүк, Монголын Хөгжлийн Банкны Зээлийн газрын захирал<br>"Монголын Дэд бүтцийг санхүүжүүлэх нь"  |
| Д.Цэвээнжав, Гаалийн Ерөнхий Газрын дарга<br>"Хил Гааль нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх"  |
| Камерон Дорр, Седжман группын Азийг хариуцсан ерөнхий менежер<br>"Нүүрсний боловсруулах үйлдвэрийг Монголд хэрэгжүүлэх нь"  |
| Б.Энхбаатар, Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн зохицуулагч<br>"ТВА"   |
| <b>ЦАЙ КОФЕНЫ ЗАВСАРЛАГА (5-Р ХУРАЛДААН ӨНДӨРЛӨНӨ)</b>  |
| <b>6-Р ХУРАЛДААН: АШИГТ МАЛТМАЛЫН ГҮН БОЛОВСРУУЛАЛТ</b><br>Хурлын дарга: Н.Алгаа, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн Гүйцэтгэх захирал   |
| Антон Р.Даммер, Жени Ойл энд Газ ХК-ийн ахлах зөвлөх<br>"Шатдаг занарын боловсруулалт: давуу болон сул талууд"  |
| Ж.Золжаргал, МАК компанийн технологи, судалгааны төвийн захирал<br>"Нүүрснээс шингэрүүлсэн хий гаргаж авах тухай"   |
| Ракеш Кулшрешда, СЭЙЛ Дэд захирал /Төлөвлөлтийн хэлтэс/<br>"Гангийн үйлдвэрлэл Монголд"   |
| Виктор Андрейв, Таллин технологийн их сургууль, Вирумаа коллежийн дарга<br>"Шатдаг занарын тухай"   |
| <b>АСУУЛТ, ХАРИУЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</b>   |
| <b>ҮДИЙН ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА (6-Р ХУРАЛДААН ӨНДӨРЛӨНӨ)</b>   |
| <b>7-Р ХУРАЛДААН: ЭРХ ЗҮЙ, ТАТВАРЫН ОРЧНЫ ШИНЭ ХАНДЛАГА</b><br>Хурлын дарга: Жим Двайер, Монголын Бизнесийн Зөвлөлийн Гүйцэтгэх захирал   |
| Девид Уайш, АНУ-ын ЭСЯ-ны Эдийн засаг, худалдааны хэлтсийн дарга<br>Жеймс Лиотта, МахониЛиотта компанийн партнер<br>Д.Жаргалсайхан, Тоймч, Дефакто нэвтрүүлгийн хөтлөгч<br>Д.Ончинсүрэн, Делойтте Онч ХХК-ийн ерөнхий захирал |
| Жеймс Пассин, Файрберд Менежмент компанийн сангийн менежер<br>"Амжилттай уул уурхайн компаниудын ажлын зарчмыг танилцуулах нь"  |
| <b>ЦАЙ КОФЕНЫ ЗАВСАРЛАГА (7-Р ХУРАЛДААН ӨНДӨРЛӨНӨ)</b>  |
| <b>8-Р ХУРАЛДААН: ЗАСГИЙН ГАЗРЫН ЦАГ</b><br>Хурлын дарга: Д.Дамба, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн Ерөнхийлөгч  |
| Монгол Улсын Засгийн Газар  |
| Эрдэс баялаг, эрчим хүчний яам  |
| Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Ашигт малтмалын газар   |
| Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци   |
| <b>ЧУУЛГАНЫ ХААЛТ</b><br>П.Очирбат, Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, чуулга уулзалтын Зохион Байгуулах Хорооны Тэргүүн   |
| <b>ХААЛТЫН АЖИЛЛАГАА</b>  |
| <b>ОРОЙН ЗООГ</b>   |

е е е

## МОНГОЛ УЛС БА ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Улсын төсвийн орлогыг уул уурхайн салбар бараг л 100 хувь хангахын зэрэгцээ хамгийн өндөр цалинг олгож, түүнийг бараадсан ханган нийлүүлэлтийн салбарт том хувьсал гарлаа.

### Б.ЯРУУ

Монгол Улсын нийт хөрөнгө оруулалт сүүлийн 10-аад жилийн хугацаанд эрчимтэй өсөж, ДНБ-ий 40 хүртэлх хувьтай тэнцэх болсныг Сангийн яамнаас онцлов. Тодруулбал, нийт хөрөнгө оруулалтад дотоодын хөрөнгө оруулалт 40, гадаадын хөрөнгө оруулалт 60 хувийг эзэлж, уул уурхайн салбарын эдийн засагт эзлэх хувь хэмжээ гүнзгийрчээ.

Царцанги байсан эдийн засаг цагийн аясаар гэсэж эхлэв. Дэлхийн зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний үнэ сүүлийн 10 жилийн хугацаанд огцом өслөө. Уул уурхайн баялгийг дагасан хөрөнгө оруулалт Монголд санхүүгийн эрх чөлөө олгохын зэрэгцээ хөгжлийн ноу хау нэвтрүүлж, тэргүүн туршлагаа нутагшуулсан гэдэгт эргэлзэх хүн байхгүй л болов уу.

### Нэг

Манай улсын нийт экспортын 98.6 хувийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж байна. Улсын төсвийн орлогыг уул уурхайн салбар бараг л 100 хувь хангахын зэрэгцээ хамгийн өндөр цалинг олгож, түүнийг бараадсан ханган нийлүүлэлтийн салбарт том хувьсал гарлаа. Уул уурхайд 50 гаруй мянган хүн ажиллаж, тэдгээрийн ар амьдралыг тус салбар үүрч явна.

“Эдийн засгийн өсөлт өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд дунджаар 7.8 хувь, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3000 ам.долларт хүрч, гадаад худалдааны нийт бараа


эргэлтийн хэмжээ бараг хоёр дахин нэмэгдсэний зэрэгцээ манай улсын гадаад валютын нөөц 2008 оныхоос дөрөв дахин нэмэгдсэн” гэж Сангийн яамныхан тэмдэглэлээ.

Өнгөрсөн 5-6 жилд манай эдийн засаг дунджаар долоон хувьтай өсөхөд уул уурхайн салбар гол дүрд нь тоглосон бөгөөд тус салбарын ДНБ-д эзлэх хувь 2002 онд 10 хувь байсан байна. Тэгвэл сүүлийн таван жилийн дүнд ДНБ-ий 40 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээнд очжээ. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчинд өнгөрсөн 10 жил өсөлт, хөгжлийн эрин үе байсан бол ирэх 10 жилийн төлөв байдал тун таагүй эхэлж байна. Нэг үгээр

хэлбэл, Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль нь үүний хариулт болж магадгүй ажээ.

### Хоёр:

“Metals Economics Group”-ийн тооцоолсноор БНХАУ өнгөрсөн онд уул уурхайн салбартаа 611 сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалтыг татаж долдугаарт жагссан байна. Харин Монгол Улс 107 сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт татсанаар 25 дугаарт орсон хэмээн эдийн засагч Д.Жаргалсайхан хэллээ. ▶



Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалтын газар



Фотог Б.Бямба-Очир

► Уул уурхайн салбар нь 2011 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 20.2, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 69.6, экспортын бүтээгдэхүүний 89.2 хувийг тус тус үйлдвэрлэжээ. Манайх алт, зэс, нүүрс, жонш, цайр, төмрийн хүдэр, гянтболд олборлож байгаагаас зэсийн баяжмал, катодын зэс, молибден, нүүрс, төмрийн хүдэр, цайрын баяжмалыг Хятад, жоншны баяжмалаа ОХУ, АНУ, Украин, алтаа Канад, АНУ, Их Британи болон урд хөршид экспортолж байна. Гадаад зах зээлийн гарц нээх шинэ зорилт, шинэ сорилт тулгараад буйг тус салбарынхан учирласан ч хууль эрх зүйн орчин, түүний саадыг гаднын хөрөнгө оруулалт давж чадах эсэхэд итгэлгүй байгаагаа ч илэрхийллээ.

“Экспортыг дэмжсэн салбарын эдийн засгийн аюулгүй байдалд гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль халдсан. Хөрөнгө оруулагчдад тогтвортой, тодорхой, тэгш шударга үйлчлэх орчин л хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, татвар нь төлж болох хэмжээтэй, төрийн хүнд суртал бага байх учиртай” гэж Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа ярилаа.

## Гурав:

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагууд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт 20 гаруй төрлийн татвар, хураамж, төлбөр төлөх замаар Монгол Улсын эдийн засагт хувь нэмрээ ихээхэн оруулж байгаа аж. Тухайлбал, хайгуулын болон ашиглалтын лицензийн төлбөрөөр 2002 онд 3.1, 2003 онд 3.5, 2004 онд 8.2, 2005 онд 19.2 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт оруулсан байна.

Мөн 2004 онд гэхэд л орлогын албан татвар /62 тэрбум төгрөг/, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /23.9 тэрбум төгрөг/, газар усны төлбөр /7.2 тэрбум төгрөг/ буюу нийтдээ 271.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байдаг. Үүнээс хойших өөрчлөлтийг одоогийн эдийн засгийн өнөөдрийн өсөлтөөр хэмжиж болох биз ээ.




Манай эдийн засагт цутгаж буй хөрөнгө оруулалт зөвхөн уул уурхайн салбарт л шингэж буй ч уул уурхай дагасан үйлчилгээ болон барилга, ханган нийлүүлэлтийн салбарт тодорхой хэмжээнд дэвшил авчирсан. Гадаадын хөрөнгө оруулалтыг хэмжиж үзэхэд түүний 90

орчим хувь нь уул уурхайн салбарт оногдож байна. “Олон улсын ил тод байдал” байгууллагаас гаргасан 2009 оны судалгаанд Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтыг татах үзүүлэлтээрээ тэргүүлэх гуравдугаар зэрэглэлд багтсан бол бүс нутгийн хэмжээнд татварын хувь хэмжээгээрээ хамгийн бага /аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын хувь хэмжээ -10 хувь, НӨТ-25 хувь/ аж.

Монголчууд эдүгээ хөрөнгө оруулагчдыг урин дуудаж байгаа ч Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг гэнэт гаргаж, “бэлэг” барилаа. Хэлэлцээрийн ширээнд сууж, үзэглэхээр зэхэж буй хөрөнгө оруулалтын олон гэрээнд тус хуулийн зүйл, заалт цэг тавьж, тээглүүр болж дөнгөв. Уг хуулийг “урт насгүй” хэмээн үзэх нэгэн ч бий. Санхүүгийн эрх чөлөөний хөшүүрэг болсон хөрөнгө оруулалт уул уурхайн салбарт ус агаар мэт чухал байгаа нь үнэн. Цаашилбал улс орны хөгжлийн эдийн засагт ч хөрөнгө оруулагчид хүндтэй байр суурь эзэлсэн хэвээр байх нь ойлгомжтой. Тиймээс л уул уурхай, түүнд хөрөнгө оруулагчид нь нэгэн зоосны хоёр тал аж. ■


2000-аад оныг бодвол монголчууд гадаадын хөрөнгө оруулагчдын өмнө гэдийдэг болж байна. Уул уурхай, байгалийн баялаг дагасан их хөрөнгө оруулалт, сонирхол манайхыг чиглэх болсон энэ үеийг 2000 онтой харьцуулах аргагүй. Айлаар бол хажуу айл, саахалт, ах, дүү хамаатан саднаасаа атга гурил, умх мах гуйгаад ч амьдралд нь олигтой нэмэр болж чаддаггүй байсан үе бий, бидэнд. Харин өнөөдрийн өндөрлөгт хүрэхэд “Discover Mongolia” олон улсын чуулга уулзалт, үзэсгэлэн ихээхэн

нөмөр, ач тусаа өгсөн билээ. Учир нь уул уурхайн дэлхийн гигант, ақулуудыг, томоохон хөрөнгө оруулагчдыг хүрз, жоотуунаас өөр багажгүй шахуу улстай танилцуулж, арга туршлагаас гадна хөрөнгө оруулалтыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлжээ. Уг арга хэмжээ анх зохиогдож байсан үе буюу 2002 онд Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 172.51 ам.доллар байсан бол 2011 онд 4.986.034.12 ам.доллар болтлоо нэмэгджээ.



Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн /сая ам.доллараар/

|                            | 2008      | 2009      | 2010    | 2011      | 2011/2010% |
|----------------------------|-----------|-----------|---------|-----------|------------|
| Зэсийн баяжмал             | 835 6666  | 501 924   | 770 595 | 963 596   | 25.0       |
| Катодын зэс                | 18 526    | 11 850    | 20 357  | 21 028    | 3.3        |
| Чулуун нүүрс               | 182 437,3 | 305 728,3 | 874 565 | 2 239 322 | 156,0      |
| Төмрийн хүдэр, баяжмал     | 92 285    | 88 770    | 250 942 | 437 328   | 74,3       |
| Цайрын хүдэр баяжмал       | 154 617   | 122 494   | 134 135 | 142 678   | 6,4        |
| Молибдены баяжмал          | 82 344    | 50 309    | 51 992  | 46 394    | -10,8      |
| Жонш                       | 59 197,2  | 48 223,9  | 63 196  | 94 877    | 50,1       |
| Боловсруулаагүй алт        | 599 883   | 308 473   | 178 320 | 113 047   | -36,6      |
| Боловсруулаагүй газрын тос | 101 937   | 115 633   | 154 937 | 252 192   | 62,8       |

**Экспортын бараа бүтээгдэхүүн /улс орноор/  
2010 оны арванхоёрдугаар сар**

**Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл**

| Бүтээгдэхүүн             | Хэмжих нэгж | 2008.I-VII | 2009.I-VII | 2010.I-VII | Өөрчлөлт /хувиар/ |
|--------------------------|-------------|------------|------------|------------|-------------------|
| Нүүрс                    | Мян.тн      | 5100.9     | 6 346.0    | 11 615.4   | 83.0              |
| Газрын тос               | мян.баррель | 617.8      | 757.3      | 1 247.6    | 64.0              |
| Зэсийн баяжмал /35%/     | мян.тн      | 208.2      | 207.7      | 208.4      | 0.3               |
| Молибдений баяжмал /47%/ | тн          | 2 328.0    | 2 814.0    | 2 765.6    | -1.7              |
| Алт                      | кг          | 7 923.4    | 4 833.3    | 3 429.3    | -29.0             |
| Төмрийн хүдэр            | мян.тн      | 81.0       | 772.3      | 1 264.7    | 63.8              |
| Хайлуур жонш             | мян.тн      | 82.7       | 61.4       | 85.4       | 39.1              |
| Цайрын баяжмал           | мян.тн      | 85.9       | 76.4       | 67.2       | -11.9             |

**Монгол Улсад бүртгэгдсэн Гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо/салбараар/**

| Салбарын нэрээр   | 1990-2004    | 2005       | 2006         | 2007         | 2008         | 2009       | 2010       | 2011       | Нийт          |
|---|--------------|------------|--------------|--------------|--------------|------------|------------|------------|---------------|
| Худалдаа, нийтийн хоол  | 969          | 522        | 1,112        | 1,505        | 1,515        | 572        | 731        | 872        | 7,798         |
| Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт                  | 272          | 27         | 22           | 23           | 4            | 12         | 14         | 22         | 396           |
| Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл | 327          | 15         | 14           | 20           | 4            | 6          | -          | 1          | 387           |
| Аялал жуулчлал  | 176          | 57         | 35           | 23           | 12           | 1          | 2          | 6          | 312           |
| Хөнгөн үйлдвэр  | 167          | 7          | 14           | 1            | 1            | -          | -          | -          | 190           |
| Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл                             | 172          | 5          | 2            | -            | -            | -          | -          | -          | 179           |
| Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт              | 149          | 4          | 7            | 4            | -            | -          | -          | -          | 158           |
| Тээвэр  | 101          | 7          | 3            | 1            | 1            | 2          | 3          | 9          | 127           |
| Мэдээлэл, холбооны технологи                                  | 72           | 7          | 11           | 7            | 6            | 2          | 1          | -          | 106           |
| ХАА-газар тариалан, МАА                                       | 86           | 8          | 5            | 1            | -            | 1          | 1          | 4          | 106           |
| Мебель, модон эдлэл   | 71           | 2          | 4            | -            | -            | -          | -          | -          | 77            |
| Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл                  | 60           | 1          | 3            | -            | -            | -          | -          | 1          | 65            |
| Банк, санхүүгийн үйл ажиллагаа                                | 36           | 2          | 5            | 7            | 4            | 2          | 2          | 2          | 59            |
| Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ                              | 47           | 1          | 2            | -            | 1            | -          | 1          | 1          | 53            |
| Эрчим хүч   | 39           | 4          | 1            | -            | -            | -          | -          | -          | 44            |
| Нийтийн ахуйн үйлчилгээ                                       | 36           | 2          | 2            | -            | -            | -          | -          | -          | 40            |
| Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл                               | 23           | 3          | 3            | -            | -            | -          | -          | -          | 29            |
| Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл                               | 21           | -          | -            | -            | -            | -          | -          | -          | 21            |
| Үнэт зүйлс, бэлэг дурсгал                                     | 7            | -          | 1            | -            | -            | -          | -          | -          | -8            |
| Бусад   | 860          | 297        | 262          | 21           | 3            | 15         | 14         | 15         | 860           |
| <b>Нийт ГХОК-ийн тоо</b>                                      | <b>3,961</b> | <b>971</b> | <b>1,505</b> | <b>1,609</b> | <b>1,551</b> | <b>613</b> | <b>769</b> | <b>933</b> | <b>11,642</b> |

**Монгол Улсад бүртгэгдсэн Гадаадын шууд хөрөнгө оруулалт  
/хамгийн их хөрөнгө оруулсан эхний таван улс/**

| Улсын нэрээр        | 1990-2004  | 2005       | 2006       | 2007       | 2008       | 2009       | 2010       | 2011         | Нийт         |
|---------------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|--------------|--------------|
| БНХАУ               | 441,786.38 | 227,922.28 | 172,014.03 | 339,614.67 | 497,800.88 | 613,058.80 | 176,038.36 | 1,015,265.04 | 3,483,500.44 |
| Нидерланд           | 5,265.58   | 221.70     | 475.86     | 58.50      | 4,069.20   | 51,028.60  | 232,962.18 | 1,816,714.10 | 2,110,795.73 |
| Виржини арлууд (УК) | 48,394.23  | 5,033.92   | 6,111.67   | 35,449.00  | 6,157.89   | 19,305.18  | 101,986.27 | 610,933.11   | 833,371.25   |
| Люксембург          | 2,911.70   | 1,809.30   | 10.00      | 3,118.917  | 195.80     | 1,012.65   | 25,589.47  | 476,652.07   | 511,299.92   |
| Сингапур            | 8,513.28   | 4,645.78   | 728.60     | 700.00     | 32,339.86  | 9,359.44   | 31,075.00  | 402,738.17   | 490,100.13   |

Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалтын газар

## ХАЗАЙСАН УУ, ХАЛЬТИРСАН УУ

Тус хууль нь нэг талаараа ихээхэн эргэлзээтэй мессежийг хөрөнгө оруулагчдад өгсөн. Гаднынхныг “Манайд хөрөнгө оруулаач ээ гэж гуйчихаад тодорхой бус хөрөнгө оруулалтын хуулиа дагаж мөрд, үгүй бол хэцүүхэн шийтгэл амсана шүү” гэж байгаа юм.

### Б.МӨРӨН

*“Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална” хэмээн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд өгүүлсэн байдаг.*

*Тэгвэл энэ оны таевдугаар сард дээрх үзэл баримтлалыг нэвт шингээсэн гэж хэлж болох Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг УИХ баталсан. Стратегийн ач холбогдолтой гэж үзсэн уул уурхай, банк санхүү, мэдээлэл, харилцаа холбооны салбарт гаднын хөрөнгө оруулалтыг тодорхой хувиар хязгаарлан төрийн зохицуулалт хийхээр болсныг хүн бүр өөр өөрийнхөөрөө дүгнэн тайлбарлаж байна. Магадгүй Монголд хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого хазайсан эсвэл хальтирсан ч байж мэдэх ажээ.*

*Стратегийн ач холбогдолтой гэх дээрх гурван салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хэмжээ 49 хүртэл хувь байхаар хуульд заасан бөгөөд илүү гарсан тохиолдолд, түүнчлэн хөрөнгө оруулалтын хэмжээ 100 тэрбум төгрөгөөс давсан бол Засгийн газар, цаашилбал УИХ -аар шийдвэрлүүлэхээр зохицуулжээ. Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга Н.Энхтайванаар ахлуулсан ажлын хэсэг Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн хүрээнд Засгийн газрын журмыг боловсруулж, шинэ Засгийн газарт тангилцуулахаар бэлтгэж байна. Ингээд тус хуулийн талаар санаа бодлоо хуваалцсан хүмүүсийн яриаг хүргэе.*

### Үндэсний болон ард нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд гаргаж тавих ёстой

#### Ц.Элбэгдорж /Монгол Улсын Ерөнхийлөгч/

-Бид өөрийнхөө үндэсний болон ард нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд гаргаж тавих ёстой. Үүнийг л баримталж байгаа. Гадаадын хөрөнгө оруулалт, төрийн хөрөнгө оруулалтыг зохицуулах, зөвшөөрөлтэй холбоотой хуулийн төслийг гурван жилийн өмнөөс өргөн барьж, нээлттэй хэлэлцэж байгаад сая шийдлийг нь оллоо. Түүнээс биш, “Чалко”-гийн асуудал гарч ирэнгүүт бид энэ тухай ярьж эхэлсэн юм биш. Бид улс дотроо өөрийнхөө төрийн өмчид хязгаарлалт тавьдаг атлаа гадаадын төрийн өмчид хязгаарлалт тавихгүй сууж болохгүй шүү дээ. Хамгийн сайн зохицуулалттай, сайн хууль гаргалаа гэж би хэлж чадахгүй. Учир нь энд шүүмжлэлтэй хандах зүйлүүд бий. Байнга нээлттэй байх хуулийг сайжруулах боломж бий. Түүний дотор бидэнтэй хамтран ажилладаг болон Монгол Улсад хөрөнгө оруулахыг сонирхож буй хүмүүсийн санаа бодлыг ч цаашдаа нээлттэй сонсох болно.

### Хөрөнгө оруулалтыг гаргах амархан, татахад хэцүү

#### Д.Жаргалсайхан /Эдийн засагч/

-Энэ хууль нь гадаадын хөрөнгө оруулалтууд дотроос гадаадын төрийн өмчийн компаниудыг оролцохыг хязгаарласан. Энэ нь бол зөв. Харин тус хуульд ямар үед зөвшөөрөл өгөх юм, ямар үед өгөхгүй байх юм гэж зааж өгөөгүй.

Аливаа улс орон гадаадын хөрөнгө оруулалтыг татаж байж л хөгждөг. Дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай болохын тулд бидэнд хөрөнгө оруулалтаас гадна технологи, менежментийн ноу хау хэрэгтэй. Энэ бүгдийг өөрсдөө худалдаад авч дийлэхгүй. Харин энэ бүгд тухайн компанитайгаа цуг ороод ирдэг. Ер нь гадаадын хөрөнгө оруулалтыг гаргах амархан, татахад хэцүү. Зарчмын асуудал бол Монгол Улсыг хөгжүүлэхэд гадаадын хөрөнгө хэрэгтэй юм. Учир нь дотоодын ▶

▶ хөрөнгө хангалтгүй, бидний хөрөнгө газар доороо байна шүү дээ. Түүнийг гаргаж ирээд борлуулж, орлогоороо сэргээгддэг, эрдэм соёлын хөрөнгө болгохын тулд бидэнд цаг хугацаа, мэдлэг чадвар, маш их хөрөнгө хэрэгтэй. Энэ бүхнийг бид гадаадын, гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтуудаас авна. Үндэсний аюулгүй байдал чухал л даа. Гэхдээ түүний нэрийг бариад түүндээ эсрэг байдлаар нөлөөлөх алхам хийх ёсгүй.

## Хөрөнгө оруулагчдын хөл тавихаар зэхэж байсан улаан хивсийг суга татах шиг болсон

*Майкл Олдрич /Олон Улсын хуулийн фирм болох “Хоган Ловеллс”-ийн Монгол дахь салбарын захирал/*

-Тус хууль нь нэг талаараа ихээхэн эргэлзээтэй мессежийг хөрөнгө оруулагчдад өгсөн. “Манайд хөрөнгө оруулаач ээ” гэхихээд гаднынханд тодорхой бус хөрөнгө оруулалтын хуулиа дагаж мөрд, үгүй бол хэцүүхэн шийтгэл амсана шүү” гэж байгаа юм. Санаа нь зөв боловч хөрөнгө оруулалтын орчин нь өөрөө тус хуулийг засаж залруулж, дутуу ойлгомжгүй байдлыг нь цэвэрлэхийг шаардаж байна. Саяхан батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хууль хөрөнгө оруулагчдын хөл тавихаар зэхэж байсан улаан хивсийг суга татах шиг л боллоо. Тус хуульд тодорхойгүй, ойлгомжгүй зүйл их байна. Ямар ч хөрөнгө оруулагч тодорхой бус байдалд дургүй.

## УИХ-аар дамжина гэвэл Монголд хөрөнгө оруулах хүн олдохгүй

*Д.Ачит-Эрдэнэ /Монголын олон улсын хөрөнгийн корпорацийн ерөнхийлөгч/*

-Энэхүү хуулийн дагуу уул уурхай, банк санхүү, мэдээлэл, харилцаа, холбооны салбарт гаднын хөрөнгө оруулалтыг зохицуулахаар болсон нь зах зээлийн өсөлт хөгжлийг сааруулах, түүний эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг хааж байгаа хэрэг. Тиймээс улс орны эдийн засагтай амин холбоотой салбарын хууль, эрх зүйн орчин нарийн тооцоо судалгаатай, тогтвортой, өөрийн орны хэв шинжийг хадгалсан, хэтэрхий нэг талыг барьсан байж болохгүй л дээ.

Уул уурхай ч гэлтгүй эдийн засаг нь амжилттай хөгжиж буй орнуудад Гаднын хөрөнгө оруулалтын зөвлөл гэж байдаг. Манайд баталсан хуулиа хэрэгжүүлэх, түүнийг дагаж мөрдөх эрх зүйн тодорхой орчин алга. Өөрөөр хэлбэл, хэтэрхий нүсэр бүтэцтэй, зорилго, зорилт нь тодорхойгүй хуулийг баталж байна. Нэгдүгээрт, манай төр хуулийн дор амжилттай яваа, өөрөө өөрийгөө аваад явчихаж буй салбарт хэтэрхий их оролцох гэж байгаа нь буруу. Хоёрдугаарт, төрийн оролцоо хэтрээд ирэхээрээ бизнесийн салбарын асуудлыг гацаах, хүнд суртал, авлига гээд нийгмийн болохгүй бүхнийг бий болгох учир дутагдалтай байдаг. Уул уурхайн салбарын хууль эрх

зүйн орчинд гаднын хөрөнгө оруулалттай холбоотой зүйл заалт нь олборлолтоос илүүтэй хайгуул нь нээлттэй байх ёстой. Хайгуул асар их алдагдалтай.Тиймээс л төрийн оролцоо аль болох бага байх учиртай.

Зах зээлийн эрх мэдлийг төр бус түүнийг хөдөлгөж буй бизнесийнхэн залж байвал илүү шударга юм. Хэрэв хуулийн нэрээр төрийн оролцоо нэмэгдээд байвал зах зээлд цөөхөн тооны тоглогч л үлдэнэ. Хөрөнгө оруулалтын 51 хувийг Монголын тал эзэмшинэ, түүнд нь төр их бага хэмжээгээр оролцож, Засгийн газар, УИХ-аар дамжина гэвэл Монголд хөрөнгө оруулах хүн олдохгүй.

## Шинэ Парламент хуулийг засаж залруулах байх аа

*Д.Жаргалсайхан /“FSCO Mongolia” компанийн ерөнхий захирал/*

-Лондонд төвтэй эдийн засгийн судалгааны төв дэлхийн улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдлыг судалдаг. Тус байгууллагаас Монголын эдийн засгийн анхны тайланг гаргасан байна лээ. Уг тайланг үзэхэд “Монголын эдийн засгийн цаашдын өсөлтийг хангахад нийтдээ 40-50 тэрбум ам.доллар хангалттай” гэж тэмдэглэсэн байсан. Нэг үгээр хэлбэл, бидэнд ийм хэмжээний мөнгө хэрэгтэй гэсэн үг. Харин нэг тэрбум ам.доллар гэдэг монголчууд бидэнд их тоо. Манай банкуудын нийт хөрөнгийн хэмжээ нь миний олж мэдсэн судалгаагаар найман тэрбум ам.доллар. Гэтэл цаана нь үлдэж буй санхүүжилтийн эх үүсвэрийг бид хаанаас гаргах вэ. Тиймээс хүссэн хүсээгүй гадаадын хөрөнгө оруулалт чухал болж байна.

Өнгөрсөн хавар УИХ-аас баталсан Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль нь нэгдүгээрт, төрийн өмчийн оролцоотой гаднын компани Монголд орж ирэхэд үүсэж болох сөрөг үзэгдлээс хамгаалах зорилготой боловч үнэн хэрэгтээ гаднын хөрөнгө оруулалтыг хязгаарласан хууль болсон.

Төр, хувийн хэвшил ялгаагүй гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан шүү дээ. Өөрөөр хэлбэл, өмнөө тавьсан зорилтоо уг хууль биелүүлж чадаагүй. Хоёрдугаарт, стратегийн салбар гэдэг энэхүү ойлголтыг тодорхойлохгүй бол инээдтэй юм гарч ирээд байна л даа. Хуулийнхаа тодорхой заалтуудыг харж үзэх учиртай. Тухайлбал, стратегийн салбар гэсэн тодорхойлолтыг өгөхдөө “Хүн амын үндсэн хэрэгцээг хангасан...” гэсэн үг, өгүүлбэр оруулаад баталчихсан байна.

Тэгвэл хүн амын үндсэн хэрэгцээнд хамгийн түрүүнд уул уурхай, банк санхүү орохгүй байх. Харин амьсгалах, хооллох, унтах, амрах, идэх нь үндсэн хэрэгцээ. Тиймээс хүний үндсэн хэрэгцээтэй болгоныг стратегийн салбар гэж нэрлээд байж болохгүй л дээ. Гаднын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль “Бушуу туулай борвиндоо баастай” үлгэрээр зорилгоо оносонгүй. Шинэ Парламент тус хуулийг засаж, залруулах байх гэж найдаж байна. ■



“Discover Mongolia” чуулга уулзалтыг үүсгэн байгуулагчид “Зүүн гар талаас Э.Содонтөгос, Г.Анхбаяр, Д.Төрбат, Д.Жаргалсайхан, Н.Алгаа

## “DISCOVER MONGOLIA” МОНГОЛД ӨНГӨТ ЭСГИЙГ МООДОНД ОРУУЛСАН

“Mongolian Economy” сэтгүүл “Discover Mongolia” олон улсын чуулга уулзалтын үүсгэн байгуулагчдыг редакцидаа урьсан юм. Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, “FSCo” корпорацийн гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан, “Монруд” компанийн захирал Г.Анхбаяр, эдүгээ “Behre Dolbear” компанийн эрдэс баялгийн салбарын зөвлөгч Д.Төрбат, “Ньюком” группийн Харилцаа, хамтын ажиллагааны захирал Э.Содонтөгос нар манай редакцид цуглалаа.

“Discover Mongolia” чуулга уулзалт есөн нас хүрэхдээ ямар зам туулав? Монгол дээл, жанжин малгай, эсгий цүнхтэй холбоотой санаанд оромгүй олон сонирхолтой дурсамж руу “Mongolian Economy” сэтгүүл өнгийж харлаа.

Бид энэхүү редакцийн уулзалтыг өнгөрсөн жилийн “Discover Mongolia-2011” чуулганд зориулж хийсэн билээ. Өнөө жил тус чуулга уулзалт, үзэсгэлэнгийн 10 жилийн ой тохиож буй учраас дээрх ярилцлагыг товчлон хүргэж байгаа юм.

**–“Discover Mongolia”-г зохион байгуулах санаагаа анх яаж олж байсан тухайгаа ярихгүй юу?**

**Д.Жаргалсайхан:** -Канадад PDAC гээд Монголын уул уурхайн үндэсний ассоциацитай их төстэй чиг үүрэг бүхий төрийн бус байгууллага байдаг юм. Тэднийх жил бүрийн гуравдугаар сард Торонто хотод хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг, үзэсгэлэнтэй хавсарч зохион байгуулдаг л даа. Тэгээд Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжиж орсноос хойш манай холбогдох яамныханд урилга өгч, Монголын төлөөллийг оролцуулах талаас анхаарч эхэлсэн. 1993 онд тухайн үеийн Геологи, эрдэс баялгийн сайд Цогтбаатар намайг тэр уулзалтад авч явсан юм.

**Н.Алгаа:** -Жанжин малгайтай, монгол дээлтэй хоёр хүний сураг л гарч байлаа ш дээ (инээв).

**Д.Жаргалсайхан:** -Тэр үеийн зураг надад байдаг юм, хүсвэл сонирхож болно шүү. Сайд бид хоёр Торонтод цугласан хөрөнгө оруулагчдын анхаарлыг Монгол руугаа хандуулах гэсэндээ үндэсний иж бүрэн хувцастай явсан. Тэгсэн чинь хуралд

оролцогчид нь Монголын уул уурхай гэхээсээ илүү бидний хувцаслалтыг сонирхоод, хөөргөө гаргаж ирээд тамхилсан чинь нөгөөдүүл чинь бүр жигтэйхэн (инээв).

**Н.Алгаа:** -Ш.Отгонбилэг агсан УИХ-ын гишүүн байх үедээ эрдэс баялгийн салбарт байнгын ажиллагаатай төрийн бус байгууллага хэрэгтэй гэж үзээд уул уурхайн ассоциацийг санаачлан байгуулсан л даа. Өөрөө ерөнхийлөгч нь болж, намайг захирлаар нь сонгосон юм.

**Д.Жаргалсайхан:** -2001 онд Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгчөөр би сонгогдчихов оо. Алгаа бид хоёр нягтлантайгаа гурвуулаа жижгэвтэр ганц өрөөнд л ассоциацийг хүчирхэг байгууллага болгоно гэсэн зорилготойгоор ажлаа эхэлж байлаа. 1997 оны Ашигт малтмалын тухай хууль батлагдсанаар гадаадын мөнгөтэй хүмүүсийг Монгол руу оруулах нөхцөл бүрдсэн шүү дээ. Гэвч зөвхөн хууль гаргаад хөрөнгө оруулагчид ирдэг юм биш байна. Тэд чинь ирээд бие биетэйгээ уулздаг, мэдээлэл авдаг, төр, засгийнхны санаа бодлыг сонсдог байх хэрэгтэй ▶

► юм байна гэдгийг ойлгосон. Тэгээд л нөгөө Торонтод болдог PDAC-гийнх шиг хурлыг Монголд хийгээд үзвэл яасан юм бэ гэсэн санаа орж ирсэн. Анх 2002 онд “Discover Mongolia” гэдэг нэр байхгүй, ассоциаци дангаараа “UB Palace”-д уул уурхайн үзэсгэлэн, чуулга уулзалт зохион байгууллаа.

**Н.Алгаа:** -250 сандал засуулчихаад, шөнө нь нойргүй хонолоо. Хүн ирэх болов уу, ирэхгүй болов уу, мэдэхгүй байхгүй юу (инээв). Анх удаагаа л олон зуун хүн оролцох хурал зохион байгуулж байгаа нь тэр. Туршлага байхгүй, эргэж харах болгонд нэг юм дутуу юм шиг санагдаад.

**-Тэгээд хүмүүс ирсэн үү? Гаднынхан ер нь хэр сонирхож байсан бэ?**

**Н.Алгаа:** -250 сандал дүүрч, санаа амарсан даа.

**Д.Жаргалсайхан:** -Тэр бидэнд их урам өгсөн. Гэхдээ хувийн компаниудын дэмжлэг, тодорхой санхүүжилтгүйгээр томоохон хурал хийхэд хэцүү гэдгийг бас ойлгосон. Тэгээд 2003 онд нэлээд хэдэн компанид мөнгө төгрөгөөр туслаач гэж санал тавьсны дагуу “Майн инфо”, “Монруд” хамгийн түрүүнд гараа сунгасан. Тэр үед Төрбат “Майн инфо”-гийн ерөнхий менежер, Анхаа “Монруд”-ын ерөнхийлөгч байлаа. Тус бүр таван мянган доллар гаргая, орлого олбол тэндээсээ нөхнө, олохгүй байлаа ч бид өөрсдөө шатая гэсэн. Тэгээд зохион байгуулах хороо байгуулагдаад, нэртэй, логотой болоод, “Discover Mongolia” мэндэлсэн түүхтэй. Тухайн үеийн таван мянган долларыг ч их бүдүүн зүрхтэй хүмүүс л гаргадаг байлаа шүү дээ.

**-Гадаад сурталчилгаагаа яаж хийдэг байсан бэ. Тэр үед Монголын уул уурхайн салбар дэлхийд танигдаагүй байсан болохоор бэрхшээл мэдээж гарч л байсан биз дээ?**

**Н.Алгаа:** -10 мянган долларын долоон мянга нь Хойд Америктаа хамгийн нөлөө бүхий “Northern Miner” гээд уул уурхайн сонинд реклам гаргахад зарцуулагдсаныг сайн санаж байна. Сэтгүүлүүдэд бол

реклам гаргана гэж саналтгүй. Үнийг нь дийлэхгүй. Гэхдээ гадаадад сурталчилгаагаа явуулаад эхлэхээр бүртгэлийн хураамж, спонсороос санхүүжилт орж ирдэг л юм билээ.

**Э.Содонтгогос:** -Гадаад руу чиглэсэн PR хийдэг байсны хүчинд Английн “Mining Journal”, Канадын “Northern Miner”, Австралийн “Asia Miner” зэрэг хэвлэлийг Монголд анх татаж оруулж ирсэн юм шүү дээ. Бид хэдэн жилийн турш Австрали, Канад зэрэг оронд болдог уул уурхайн хурлуудад сурталчилгаа, танилцуулгаа хүргэдэг байлаа.

**Н.Алгаа:** -Анхны “Discover Mongolia”-д дэлхийн төмөрлөгийн үйлдвэрлэлээр хоёрдугаарт ордог “Vale” компаниас нэг нөхөр ганцаараа ирдэг юм байна. Бид ч тэр хүнтэй сайн уулзаж, ярилцалгүй яах вэ. Тэгсэн чинь нутагтаа очингуутаа удирдах зөвлөлийн хүмүүстээ Монголын талаар танилцуулсан байгаа юм. Тэгээд л Улаанбаатарт төлөөлөгчийн газраа нээчихсэн. Бидний хувьд энэ их том амжилт байлаа.

**-“Discover Mongolia”-г зохион байгуулах явцад дурсамжтай сайхан зүйлс мэдээж олон л байсан биз дээ?**

**Д.Жаргалсайхан:** -Анхны чуулга уулзалтаар спонсорууддаа өгсөн эсгий цүнх одоо ч бидэнд бий. Ер нь бид хурлаас орж ирэх мөнгийг ямар нэг байдлаар Монголдоо л шингээхийг хичээдэг байсан. Хэрвээ та нар анзаардаг бол манайхан томоохон хурлын үеэр нэг хар цүнхэнд материалуудаа хийгээд тараадаг шүү дээ. Тэр нь Эрээнээс ч авсан юм уу, бүү мэд. Харин бидний цүнх бол их өвөрмөц, үндэсний хэв шинж агуулсан байдаг юм.

**Д.Төрбат:** -Тэр чинь их сонин түүх л дээ. Дарханы ерх толгойлсон, эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг Норвегийн төслөөр сургалтад хамруулаад, эсгийгээр яаж бүтээгдэхүүн хийхийг зааж өгөөд, хоршоо болгон бүртгүүлээд байсан юм. Тэгээд тэр эмэгтэйчүүд дөнгөж ажлаа эхэлж байхад нь бид бариад авсан. Тэгсэн чинь анх удаа том захиалга авч байгаадаа бөөн баяр болсон эмэгтэйчүүд маань тооцоогоо жаахан

буруу хийчихжээ. Нөхдүүд гэнэдээд бага үнэ хэлчихсэн чинь дараа нь ашиг багатай болж таарахгүй юу. Уг нь тэр олон цүнхийг хугацаандаа амжиж хийхийн тулд тэд гэртээ хүртэл гараа цэврүүттэл ажилласан. Тиймээс бид тэднийг “Discover Mongolia”-гийн хүлээн авалтдаа урьж, ашгийг нь нэмж өгөх замаар дэмжиж байлаа.

**-Тэгээд эсгий цүнх хөрөнгө оруулагчдад таалагдаж байв уу?**

-Таалагдалгүй яах вэ, нэхнэ шүү дээ, нөгөө цүнхээ гээд.

**Н.Алгаа:** -Гадаадын зочид амьдралдаа тийм цүнх хараагүй байх (инээв). Тиймээс их баяртай байсан. Ганц дутагдалтай тал нь бариулгүй юм болохоор сугавчлах хэрэг гарна, гэтэл эсгийний үс хувцсанд нь наалдаад байсан.

**Д.Жаргалсайхан:** -Бид жил бүр цүнхнийхээ дизайныг сайжруулж ирсэн. Гол нь монгол хэв шинжийг агуулсан байх учиртай.

**Э.Содонтгогос:** -“Discover Mongolia” өнгөт эсгийг Монголд моодонд оруулсан байх аа. 2005 онд цагаан эсгий дээр логотоо өнгөөр хийж, инноваци бий болгосон. Тэрний дараахан Улаанбаатарт өнгөт эсгийний дэлгүүрүүд үүдээ нээсэн ш дээ.

**-“Discover Mongolia”-г төр, засгийн зүгээс яаж дэмжиж байв?**

**Д.Төрбат:** -Төр ер нь саад л болохгүй бол бидэнд буян үйлдэж байгаа хэрэг шүү дээ.

**-Анхны чуулга уулзалтын талаар гадны хэвлэл мэдээлэлд тодорхой мэдээ гараагүй гэсэн бол одоо дэлхийн томоохон агентлагууд бүгд л “Discover Mongolia”-г сурвалжлахаар зорьж ирдэг болж. Ийм цаг ирнэ гэж есөн жилийн өмнө бодож байсан уу?**

**Г.Анхбаяр:** -Яг үнэнийг хэлэхэд би лав бодож байгаагүй.

**Н.Алгаа:** -Мөрөөдөж л байсан даа.

**Д.Жаргалсайхан:** -Гэхдээ хоёр дахь уулзалтын үеэр цар хүрээ нь өргөн болоод, гаднынхан нэлээд их сонирхож ирсэн шүү дээ.

**Г.Анхбаяр:** -Би энд нэг л зүйлийг онцолмоор байна. Өнөөдөр хүн бүр уул уурхай ярьдаг болж. 1997 оны ►

► Ашигт малтмалын тухай хуулийг болсон, болоогүй гээд л янз бүрээр тайлбарлаад байна. Уул уурхай өргөжин тэллээ, хөгжлөө гэж байна. Гэхдээ тэр үед яг арьс махаараа гаднын хөрөнгө оруулагчдыг татах гээд явж байсан хүмүүс энэ бүхнийг мэднэ үү гэхээс биш, өнөөгийн улсууд мэдэрч чадахгүй. Яагаад гэвэл анх биднийг гадаад яваад хөрөнгө оруулалт татъя гэхээр Монгол гэж ямар орон хаана байдгийг ч мэддэггүй байлаа шүү дээ. Тийм үед, тийм хууль хийсэн тулдаа өнөөдөр гаднынхан Монголд их хэмжээгээр хөрөнгө оруулж байгаа юм. Одоо бараг л гаднынхан өөрсдөө ороод ирчихсэн юм шиг яриад байдаг, үнэндээ бодлогын чанартай тэд нарыг чинь оруулж ирсэн юм.

**-Сүүлийн хэдхэн жилийн хугацаанд манай уул уурхай ихээхэн өргөжөөд байна. Оюутолгой, Тавантолгойн уурхай ашиглалтад орох гэж байгаагаас**



**гадна үндэсний компаниуд олон улсын хөрөнгийн зах зээлээс мөнгө босгож эхэллээ. Энэ бүхнийг дагаад “Discover Mongolia” яаж өөрчлөгдөж байна вэ?**

**Н.Алгаа:** - Бид жил бүр нөхцөл байдал ямар байна вэ гэдгийг ажиглаж, түүнтэйгээ уялдуулан хурлынхаа чигийг гаргадаг. Анхандаа “Discover Mongolia” хайгуулд ихээхэн анхаарал төвлөрүүлдэг байлаа. Одоо жинхэнэ хөгжлийн төслүүдийг онцгойлж байна. Өөрөөр хэлбэл, Тавантолгой, Оюутолгой, тэдгээрийг дагасан ханган нийлүүлэлтэд анхаарлаа хандуулаад ирж байна.

**Э.Содонтөгос:** -Ер нь “Discover Mongolia”-г зүгээр нэг арга хэмжээ гэж бодохоос илүү Монголын уул уурхайн салбарт болж байгаа үйл явдал, эволюци гэж ойлгох хэрэгтэй болов уу. Эхлээд бид Монголд ийм их баялаг байна шүү, ирээд Монголыг нээцгээ гэж байлаа. Харин одоо бүгдээрээ Монголыг хамтдаа, хариуцлагатайгаар хөгжүүлэе гэж уриалж байна. Түүнчлэн Mining ABC буюу уул уурхайн цагаан толгойн сургалт явуулахаас гадна нарийвчилсан чиглэлээр, тухайлбал усны хайгуул зэрэг сэдвээр тусгай семинар зохион байгуулах жишээтэй. Ерөнхийдөө “Discover Mongolia”-г хөгжлийн, боловсролын, танин мэдэхүйн цогц үйл явдал гэж харах хэрэгтэй болж байна.

**Д.Жаргалсайхан:** -Өнгөрсөн хугацаанд бүх юм сайхан байсан уу гэвэл үгүй. Алдаж оносон зүйл байлгүй яах вэ. 2004-2005 онд Монголын уул уурхайг тойрсон хийрхэл явлаа шүү дээ. Монголын нийгмийн дайрч өнгөрч байгаа бүх бэрхшээлийг “Discover Mongolia” ч дайрч өнгөрч байгаа юм. Тэр байтугай, 2005 онд бил үү дээ, хурлын гадаа хэсэг залуу ирж жагссан. Уул уурхай хэрэггүй гээд.

**-Таван жилийн дараа “Discover Mongolia”-гийн цар хүрээ ямар болсон байх бол.**

**Н.Алгаа:** -“Discover Mongolia”-г Азийн томоохон уулзалт болгох мөрөөдөлтэй явдаг.

**Д.Жаргалсайхан:** -Мөрөөдөл дуусчихвал амьдрал дуусчихна шүү дээ. Бидний 2002 онд халуун сэтгэлээрээ эхлүүлсэн ажил үр дүнгээ өглөө, гэхдээ одоо бид зайгаа тавьж өгөх ёстой. Яагаад гэвэл бидний цаг үе өнгөрч байна, нийгмээс тавигддаг шаардлага ч өндөр болж байна. Миний зүгээс “Discover Mongolia”-гийн өдөр тутмын ажилд оролцооморгүй байгаа, тиймээс ч одоо дандаа залуучууд зохион байгуулж байгаа шүү дээ. Канадын PDAC шиг болчихоосой, хэрэгтэй улсууд нь санаа оноогоо солилцдог байнгын индэр болоосой л гэж зорьдог.

**Э.Содонтөгос:** -Гэхдээ бид зохион байгуулах хорооны гишүүд хэвээрээ байгаа. Залуучуудаа чиглүүлээд л, санаа бодлоо хэлж байгаа гэсэн үг. Гэхдээ хамаг юманд нь оролцоод байхгүй. Тэдэнд эрх чөлөөг нь өгч байгаа.

Эцэст нь “Discover Mongolia”-г хараад манай төр, засаг уул уурхайн чиг хандлагыг ойлгодог болчихоосой гэж бодож байна. “Fashion TV”-гийн арваннэгдүгээр сарын сезоныг үзээд, энэ жил Нью-Йоркт хүүхнүүд ингэж гангарах нь дээ гэж боддог шиг “Discover Mongolia”-г хараад, ирэх жил бид энэ тал дээр илүү анхаарах ёстой юм байна шүү гэж боддог болоосой. ■



**НОГООН**  
ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ  
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

**НОГООН  
ХӨГЖЛИЙН  
ТӨЛӨӨ**

## PMONGOLIAN ECONOMY

**-“Discover Mongolia” олон улсын чуулга уулзалт 10 дахь жилдээ зохион байгуулагдах гэж байна. Энэхүү чуулга уулзалт, үзэсгэлэн Монгол Улсын хөгжилд ямар хувь нэмэр оруулсан гэж Та бодож байна вэ?**



**Катлин Морэнски /Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ-ны Хэргийг түр хамаарагч/**

-Энэхүү чуулга уулзалтад АНУ-ын Элчин сайдын яам жил бүр оролцож ирсэн. “Discover Mongolia” чуулга уулзалт Монгол Улсад уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдыг татахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн гэж бодож байна. Тус салбарынхантай шинэ харилцаа холбоо тогтоох, хуучны түнштэйгээ уулзах, Монголын уул уурхайн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаарх мэдээллийг үнэн бодитоор нэг дороос авч болох арга хэмжээ юм. Энэхүү чуулган нь АНУ-ын олборлох үйлдвэрт хөрөнгө оруулагчдын анхаарлыг нэлээд татдаг билээ. Иймээс ч манай улсын уул уурхайн үйлчилгээ үзүүлэгч компаниуд, тоног төхөөрөмжийн худалдаа эрхлэгчид өргөнөөр оролцдог. Урьдчилсан байдлаар тооцоход АПУ-гаас 100 гаруй оролцогч үзэсгэлэн гаргах, илтгэл тавих, мөн хурлын төлөөлөгч статусаар оролцох болов уу.

Зүүн хойд Азийн эдийн засгийн хувьд дэлхийн хамгийн чухал бөгөөд эрчимтэй бүс нутгуудын нэг мөн. АНУ-ын хувьд Зүүн хойд Азийн зах зээлийг сонирхох нь дамжиггүй. АНУ-аас Монголд нийлүүлсэн нийт экспортын хэмжээ өнгөрсөн онд 300 сая ам.долларт хүрсэн ба 2012 онд энэ тоо улам өсч, Монгол Улсад бараа бүтээгдэхүүнээ экспортолдог орнуудаас эхний гуравт багтана гэдэгт итгэж байна.

Мөн бид хөрөнгө оруулалтын томоохон боломжуудыг сонирхож байгаа. АНУ-ын уул уурхайн шилдэг компаниудын нэг “Пибоди Энержи” Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран Таван Толгойн нүүрсний ордыг ашиглах төсөлд оролцох боломжийг эрэлхийлж буйг та бүхэн мэдэж байгаа. Таван Толгойн ордод хийх урт хугацааны, олон тэрбум долларын энэхүү томоохон хөрөнгө оруулалт нь дэлхийд шилдэгт тооцогддог Америкийн технологи, туршлагыг Монголд авчрах бөгөөд хоёр орны харилцааг улам бататгаж, шинэ төвшинд гаргах сайхан боломжийг нээх билээ.



**Ванг шао лонг /Хятадын Элчин сайд/**

-Олон улсын уул уурхайн хөрөнгө оруулагчдын “Discover Mongolia” форумд оролцоно гэж бодож байна. Энэ жил арав дахь удаагаа зохион байгуулагдах гэж байгаа уул уурхайн үзэсгэлэн нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, уул уурхайн компаниудад хоорондоо танилцаж, хэтийн хамтын ажиллагаагаа өрнүүлэхэд ихээхэн ач холбогдолтой. Тус чуулга уулзалт нь эдүгээ дэлхийн тавцанд уул уурхайн салбарын хамгийн чухал арга хэмжээ болж танигдаж чадлаа. Хятад болон Хонгконгийн олон компани энэхүү чуулганд оролцох болно. Арга хэмжээний цар хүрээ өргөжих тутамд Хятадын компаниудын анхаарлыг татна гэж үзэж байна.

Зүүн хойд Ази нь эдийн засгийн асар их потенциалыг агуулж байна. Өргөн зах зээл, байгалийн нөөц болон эрчим хүчний нөөц арвинтай энэ бүс нутгийн орнуудад боловсруулах болон үйлдвэрлэлийн салбар хүчтэй хөгжсөн билээ. Дэлхий дахинаа эдийн засгийн дарамт шахалт тулгарсан байна. Европын өрийн асуудал өнөө хүртэл үргэлжилсээр. Дэлхий эдийн засгийн өсөлт бууралтад орсон энэ цаг үед Зүүн хойд Азийн улс орнуудын хамтын ажиллагаа улам чухал болж байна.



**Грегори Гөүлдхок /Канадын Элчин сайд /**

-Канадын ЭСЯ-наас энэхүү арга хэмжээнд дөрөв дэх удаагаа оролцож байгаа. “Discover Mongolia” бол Монголын уул уурхайтай холбоотой асуудлыг сонирхсон хүн бүр заавал оролцох ёстой арга хэмжээ юм. Арван жилийн ойн хөтөлбөр ихээхэн сонирхолтой санагдаж байна. Канадын компаниуд Монголын уул уурхайн салбарын томоохон хөрөнгө оруулагчид байсаар ирсэн бөгөөд тус улсад урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааг өрнүүлэх зорилготой билээ. Манай олон компани чуулганы ивээн тэтгэгчээр оролцохын зэрэгцээ төлөөлөгчөөр мөн илтгэл тавихаар оролцоно.

Канадын уул уурхайн компаниуд Зүүн хойд Азид төлөөлөлтэй. Канад Улс өөрийн компаниудын үйл ажиллагаагаа идэвхтэй явуулдаг улс орнуудад шилдэг стандарт, туршлагаа шилжүүлэхийн зэрэгцээ бүх нийтэд ашигтай тогтвортой хөгжлийн өсөлтөд хувь нэмрээ оруулахдаа баяртай байдаг. Мөн Канадын КНХ-ын үндэс тус бүс нутгийн үндэсний бодлогын хүрээнд хэрэгждэг юм. Монгол Улс тус бүсийн ардчилал, ил тод байдлын илэрхийлэл нь мөн. Тийм ч учраас манай улс ►

- ▶ хөрөнгө оруулалтын зорилгот бүсээр сонгосон. Хөрөнгө оруулагчид тогтвортой байдалд ихээхэн ач холбогдол өгдөг.

#### Ли Таэ-ро /Солонгосын Элчин сайд/



–“Discover Mongolia” хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт энэ арваад жилд өөрийн байр суурийг баттай эзэлжээ. Миний бодлоор олон улсын чуулга уулзалтууд нь Монголын эдийн засгийн хөгжлийн явцыг харж болох нэгэн боломжийг нээж өгдөг чухал үйл ажиллагаа юм. Засгийн газрын болон эдийн засгийн гол салбаруудын чухал төлөөлөгч нар уулзаж, уул уурхайд төрөөс баримтлах бодлого, өнөөгийн байдал, хэтийн төлөв байдлыг танилцуулж, үүнийхээ дагуу илтгэл, оролцогчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулдаг нь цаашдын ажилд чухал хувь нэмэр болдог болов уу.

Сүүлийн үед Европын эдийн засгийн хямрал нь Америк, Япон зэрэг хүчирхэг оронд нөлөөлж, эдийн засгийн зогсонги байдал улам даамжрах, мөн Хятад улсын эдийн засгийн өсөлтийн зогсонги байдалтай цаг хугацааны хувьд дээрх хурал зохион байгуулагдаж байгаагаараа онцлог. БНСУ-ын Элчин сайдын яам, БНСУ-ын Ашигт малтмалын газар (KORES), Уул уурхай, нөхөн сэргээлтийн агентлаг (MIRECO) зэрэг төрийн байгууллага болон Монголын эдийн засаг, уул уурхайн салбаруудад хөрөнгө оруулах сонирхолтой нэр хүнд бүхий томоохон компаниуд, жижиг, дунд үйлдвэрийн төлөөлөл уг хуралд жил болгон оролцоор ирсэн бөгөөд энэ жил ч оролцохоор төлөвлөж байна.

Дэлхийн эрдэс баялгийн салбарт Монгол Улсын нэр хүнд жилээс жилд өсөж байгаа билээ. Солонгос нь газар доорх байгалийн нөөц баялаг гэх юм бараг байхгүй орон шүү дээ. Үйлдвэрлэлд шаардлагатай байгалийн гаралтай түүхий эдийн 97 хувийг гаднаас импортолж, тэр чинээгээрээ импортын хамааралтай байдаг. Тиймээс түүхий эдийн хомсдол улам хурцадмал болж байгаа энэ цаг мөчид Монгол Улстай байгалийн баялгийн салбарт хамтарч ажиллах нь манай улсын хувьд чухал ач холбогдолтой юм.



#### Кристофер Чарлес Стюарт /Их Британийн Ерөнхий сайд/

–Английн ЭСЯ-наас Монголын уул уурхайн салбарын томоохон арга хэмжээ болох энэхүү чуулганд оролцох болно. Тооны хувьд бус чанар чухал гэж үзэж байна. Тус чуулга уулзалтад Английн компаниудыг оролцоно гэсэн хүлээлттэй байгаа. Монгол Улс дэлхийн эдийн засгийн өсөлт мөн түүнчлэн гол үндэс суурь нь болоход голлох үүрэгтэйг Английн Засгийн газраас хүлээн зөвшөөрч байна. Иймд тус улсад гүйцэтгэх үүрэг, төлөөллөө өргөжүүлж байгаа.

#### Хьюстэн Спэнсэр /Оюу Толгой ХХК-ийн ОНХХ-ийн Дэд ерөнхийлөгч/



–Монгол Улсыг дэлхийд сурталчлахад томоохон үүрэг гүйцэтгэдэг олон улсын чуулга уулзалт юм. Энэ хурлыг манай компани хоёр жил дараалан, ивээн тэтгэж байгаадаа баяртай байна.

Арван жилийн өмнө Оюутолгой ордыг дөнгөж илрүүлж байсантай харьцуулахад өнөөдөр бид дэлхий дээрх хамгийн дэвшилтэт техник технологи бүхий уурхайг Монголд нээхэд хэдхэн долоо хоног үлдээд байна. Манай компани уурхайг анхлан төлөвлөсөн хугацаанаасаа хагас жилийн өмнө барьж дуусгах гэж байгаа. Хэдийгээр олборлолт эхлээгүй ч Оюутолгой төслөөс Монгол Улсад 900 тэрбум төгрөг хэдийнэ орж иржээ. Энэ төслийн Монголд үзүүлэх эдийн засгийн шууд болон шууд бус үр ашиг ирэх жилүүдэд улам нэмэгдэнэ. Ажлын байр ч нэмэгдэж, бизнесийн салбарууд төрөлжиж, олширно.

Газар доорх баялгаа зөв ашиглаж, үүнээс орж ирэх ашгийг оновчтой зарцуулбал Монгол Улс хурдацтай хөгжиж болохыг “Discover Mongolia” шиг олон улсын чуулга уулзалтууд харуулдаг билээ.



#### Аршад Саиед /Пийбоди Энержи компанийн Монгол болон Энэтхэг улсыг хариуцсан ерөнхийлөгч/

–Өнгөрсөн 10 жилийн хугацаанд “Discover Mongolia” нь Монгол Улс ашигт малтмалаар ихээхэн баялаг орон болохыг дэлхийн хэмжээнд танилцуулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Харин одоо ашигт малтмалын энэхүү баялгийг яалангуяа нүүрсний баялаг нөөцийг үр дүнтэй ашиглаж, хөгжүүлэхэд дэлхийн хэмжээний томоохон компаниудын, жишээ нь, Пийбодигийн шилдэг стандарт, тэргүүн туршлагуудыг нэвтрүүлэн Монголын дэлхийн хэмжээний уурхайнуудыг цогцоор нь тогтвортой замаар хөгжүүлэх цаг болсон. Ингэснээр Монгол Улсын одоо төдийгүй хойч үеийнхэнд хүртээмжтэй ээлтэй бодлого байх болно. ▶▶



#### Лу.Гантөмөр /УИХ-ын гишүүн/

-Энэ чуулганы гол ач холбогдол нь төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагч гэсэн гурван талт чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг явдагт байгаа юм. Энэ үеэр гадна, дотны хөрөнгө оруулагчид мэдээлэл болоод туршлага солилцохын зэрэгцээ нэвтрүүлж буй шинэ технологи танилцуулдагаараа давуу талтай. Төрийн бодлогод “Discover Mongolia” чуулга уулзалтаас гарсан олон шийдвэр туссан байдаг. Мөн дотоодын үйлдвэрлэгчдэд олон боломж гарсан. Хамгийн гол нь тус чуулга уулзалт нь нэгэнтээ хэвшсэн ажил болж буй нь талархуштай.

Цаашдаа бизнес эрхлэгчдийн дуу хоолойг сонсдог тодорхой бүтцүүдтэй байх хэрэгтэй. Ерөнхий сайдын дэргэдэх Бизнесийн зөвлөл ажлаа сайн хийх хэрэгтэй байна. Засгийн газар, УИХ бизнес эрхлэгчдийн саналыг сонсдог болох нь чухал. Уул, уурхайн салбарынхан хөрөнгө оруулалт болон бусад чиглэлээр ихээхэн хүлээлттэй байгаа. Тиймээс уул уурхайн стандартын шинэчилсэн загварыг танилцуулж, салбарынхаа бодлогоо зангидаж, шинэчлээсэй гэж бодож байна.



#### С.Дэмбэрэл /УИХ-ын гишүүн/

- “Discover Mongolia” нь гадаадын хөрөнгө оруулагчдыг дотоодыхонтой холбохын зэрэгцээ гаднынхан манай улсын Засгийн газрын бодлого, хууль, эрхзүйн орчныг таньж авснаараа хөрөнгө оруулалт хийх итгэлийг төрүүлдэг. Дээр нь гаднын хөрөнгө оруулагчид манай хөрөнгө оруулалтын хууль эрхзүйн орчин, ерөнхий төлөв байдал, цаашдын хандлагыг мэдсэнээр хөрөнгө оруулалт хийх тогтвортой орчин мөн, эсэхийг мэдэх боломж бүрддэг юм. Нөгөө талаас гаднын хөрөнгө оруулалтын шинэ мэдлэг, туршлагыг бид суралцаж, авч үлддэг. Манай шинэ Засгийн газар, УИХ Монгол Улсын хөгжлийн бодлогынхоо урт болон дунд, богино хугацааны төлөвлөлтөө гаргаж, хөрөнгө оруулалтын хууль, эрхзүйн орчинг илүү бат, бөх, боловсронгуй болгох шаардлагатай байна.



#### С.Ганбаатар /УИХ-ын гишүүн/

-“Discover Mongolia” чуулга уулзалтыг дэмждэг хүний нэг нь би. Ер нь манай улсад дэлхий нийтэд ч тулгамдаж буй асуудлын нэг нь үл ойлголцол. Тэгэхээр уул уурхайн салбарынхан, хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийнхэн нэг дор цуглаж, ярилцах боломж, гарц шийдлийг хамтдаа хайдгаараа үнэхээр зөв арга хэмжээ юм. Ялангуяа манай эдийн засаг, улсын хөгжилд өндөр ач холбогдолтой учир төрийн бодлогоор гадаадын хөрөнгө оруулалт, түүний зохицуулалтыг дэмжиж ажиллах нь зүйтэй. Мөн гадаадын хөрөнгө оруулагчид манай улсад ирж, иргэд, бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийнхэн юу хүсэж, хэрхэн хамтрах ажиллах чиглэлтэй байгааг ч тодорхойлж өгөх онцлогтой. Нөгөө талаас гаднын хөрөнгө оруулагчид ч манай улсын хууль эрхзүйн орчин, хөрөнгө оруулалт хийх бололцоотой салбарын талаарх мэдээллийг бүрэн авах боломж бүрддэг цогц арга хэмжээ болдог гэж миний хувьд дүгнэдэг.



#### Ж.Батбилэг /Ашигт малтмалын газар Нүүрс судалгааны хэлтсийн Гүн боловсруулалт, төслийн тасгийн дарга/

- “Discover Mongolia” чуулга уулзалт нь гадаадын томоохон уул уурхайн компаниудыг Монголд оруулж ирэхэд мэдээллийн болон бусад талаараа багагүй үүрэг гүйцэтгэсэн. Үүнээс хойш уул уурхайн чиглэлийн “Coal Mongolia”, “Mining Mongolia” зэрэг томоохон хурал зохиогдож эхэлсэн. Дэлхий нийт “Discover Mongolia” олон улсын чуулга уулзалтыг мэддэг болж, оролцох сонирхол нь ч нэмэгдэж байна. Хурлын үеэр олон сонирхолтой илтгэл тавьж, уул уурхайн салбарын асуудлыг тал бүрээс нь хөндөж ярьдгаараа онцлог. Уул уурхайн салбарын хурал семинар өнгөрсөн жилд 10 гаруй болсон. Ийм хурлуудын чиг үүрэг нь хөрөнгө оруулагчдыг татах нэг хэлбэр болж буй учир дэлхийн зах зээл дээр манай хувьцааг сонирхож эхэлж байна. “Discover Mongolia” өнөөдөр хөрөнгө оруулалтын чуулган нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэдэг чиглэлд анхаарч байна. Өнөөдөр тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалттай Коксын үйлдвэрийн төсөл, Нүүрс шингэрүүлэх цогцолбор үйлдвэрийн 2-2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай зургаан төсөл яригдаж байна. Цаашдаа түүхий эдээ бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр барих болон өндөр технологи оруулж ирэх чиглэлд хэрэгжих байх аа. ▶



► **Д.Галсандорж /Монголын экспортлогчдын холбооны Ерөнхийлөгч/**

-Уул уурхай, геологийн салбарт ажиллаж буй дотоод, гадаадын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулахад “Discover Mongolia” чуулга хувь нэмрээ оруулж байна. Ер нь манай геологийн салбарын хурдац уул уурхайн салбараасаа хоцроод байна шүү дээ. Өөрөөр хэлбэл, өнөөдөр олж нээгээд буй эрдэс баялгийн нөөц багасч байна. “Discover Mongolia” чуулга уулзалт эрэл хайгуулын салбарт гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулахад томоохон хувь нэмэр оруулсан. Ялангуяа Канад, Австрали, Япон, Солонгосын компаниуд эрэл хайгуулын ажил хийх болсон нь сайшаалтай хэрэг. Зарим компани нь манайд социализмын үед илрүүлсэн ордуудад үргэлжлүүлэн хайгуул хийж, нөөцийг нь шинээр тогтоох тохиолдол нэлээдгүй байна. Жишээ нь Хөвсгөл аймгийн хэд хэдэн нүүрсний ордод түшиглэж цахилгаан станц байгуулах саналыг гаднынхан тавилаа. Мөн тус чуулга уулзалт нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд уул уурхайн томоохон компаниудыг Монголд татахад багагүй хувь нэмэр оруулсан. Цаашдаа зохион байгуулалт, сэдвийн хүрээгээ илүү боловсронгуй болгох чиглэлд анхаарч ажиллах нь зүйтэй болов уу.



**Б.Батмөнх /“Шарын гол” компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/**

-Манай компани энэ жил алтан ивээн тэтгэгчээр оролцож байгаа. Тус уулзалт нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдыг татах томоохон арга хэмжээ юм. Энэ үүргээ ч сайн биелүүлж ирсэн. Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарын чуулган олон болж буй ч салбартаа анхдагч төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагуудыг хамруулсан өргөн цар хүрээтэй уулзалт болдгоороо ихээхэн онцлогтой.

Сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулагчид болон уул уурхайн салбарт хандсан хуулиуд батлагдаж буй ч зарим талаараа энэ нь хөрөнгө оруулагчдаа үргээж, салбарынханд дараа болох тохиолдол гарч байна. Жишээ нь, саяхан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль мэндэлсэн ч хүмүүс ам муутай байгаа. Мөн Зорилтот татварын тухай хууль ч гэж бий. Ер нь төр, засгийн зүгээс дэлхийн эдийн засаг тогтворгүй байгаа энэ үед улс орныхоо эдийн засгийг нуруундаа үүрч яваа уул уурхайн салбараа аль болох дэмжсэн, зөв бодлого явуулах хэрэгтэй. Тэгэхгүй бол дөнгөж өндийж буй уул уурхайн салбарынхныг гааль, татварын янз бүрийн дарамтад оруулаад ирвэл эргээд эдийн засагтаа хүнд цохилт болно шүү дээ. Тиймээс “Discover Mongolia” чуулганаар Засгийн газарт зориулсан санал, зөвлөмжийг түлхүү гаргаж, ирэх дөрвөн жилд уул уурхайн салбарт явуулах шаардлагатай бодлогын талаар санал бодлоо сайтар хуваалцаж, уриалга гаргах хэрэгтэй.



**Жим Двайер /Монголын бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал/**

-Манай Бизнесийн зөвлөлөөс “Discover Mongolia” чуулга уулзалтыг ихээхэн сайшаан дэмждэг. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд тус чуулган нь Монголын хөгжлийн хөдөлгүүр уул, уурхайн салбарт хэрэгтэй байсан гадаадын хөрөнгө оруулалтыг татах гол сурталчилгаа болсон бөгөөд эерэг мэдээлэл, мессежүүдийг үргэлж өгсөөр ирсэнд нь талархдаг. Цаашдаа ч хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллах болно



**Demir Yener /USAID Бизнес санаачлага төслийн Санхүүгийн болон Компанийн засаглалын зөвлөх /**

-“Discover Mongolia” чуулга уулзалт нь гадны хөрөнгө оруулагчдад Монголыг таниулж, дэмжихэд ашиг тустай, үр дүнгээ өгч буй уламжлалт арга хэмжээ юм. Миний бодлоор Монгол Улс одоо доорх салбарыг олон улсад таниулах хэрэгтэй. Үүнд: бизнесийн таатай орчин бий болгох, татвар төлөлт, гаалийн нөхцлөө сайжруулах, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах, иргэддээ ажлын зөв дадал хэвшил, ёсзүйг хэвшүүлэх, боловсролын салбар, сургалтын орчныг сайжруулах, олон улсын гэрээ хэлэлцээрт оролцох боломжыг дээшлүүлж, хөрөнгө оруулагчдыг татах орчноо илүү нээлттэй болгон, шинэчлэх хэрэгтэй болов уу. Дээр нь хөрөнгө оруулагчдын итгэл найдварыг унагах ёсгүй. Монголыг зөвхөн уул уурхайн хөгжлөөр бүү төсөөлөөсэй. Тэгэхээр “Discover Mongolia” чуулга уулзалтаар дамжуулан Монгол уул уурхайн салбараас гадна бусад хөгжлийн боломж, онцлогуудаа мөн гаргаж ирэх хэрэгтэй. ■

# е “DISCOVER MONGOLIA” 10 ЖИЛ





П -1997Р

## ЭЦЭГ ХУУЛИЙН ОРГИЛ ЦАГ

Уруудаж явсан эдийн засаг өсөлтөөр өндийж, эрдэс баялгийг нь дэлхий шохоорхож, тунхаг хуулийн үр дүнг сүүлийн 10 жилийн хугацаанд монголчууд өдгөө хүчтэй мэдрээд эхэллээ.

### Б.ЦАХИУР

*“Mongolian economy” сэтгүүл энэ дугаараас эхлэн 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн талаарх цуврал нийтлэлийг уншигчдадаа хүргэж байна. Энэхүү хуулийн зорилго, үзэл санаа, үр дүнд өнөөгийн уул уурхайн салбарын хөгжил цэцэглэж эхэлсэн билээ. Хамгийн гол нь 1997 оны Ашигт малтмалын тухай хууль хэрэгтэй, хэрэггүй хэмээн маргалддаг хүмүүст бодит үнэнийг хүргэх, нөгөө талаар тус хуулийг мэдэхгүй яваа өнөөгийн залууст мэдлэг мэдээлэл өгөхөд манай нийтлэлийн зорилго оршино.*

*Та санаа бодлоо манай сэтгүүлийн редакцийн хаягаар илгээж болно.*

Уул уурхайн салбарыг зангидаж буй хууль эрх зүйн орчинг чамлаж, түүнийг үгүйсгэх бүрт Ашигт малтмалын тухай хуулийн үзэл баримтлалд өөрчлөлт орж, тэрбээр өнгө зүсээ хувиргасаар өнөөдөртэй золгожээ. Нэг үгээр хэлбэл, Ашигт малтмалын тухай хууль нь бусад хуулиас хамгийн олон удаа “гоо сайхны хагалгаа”-нд орсон гэсэн үг. Цаг үеийн шаардлага, хөгжлийн төлөөс, нийгмийн захиалга, улс орны эдийн засгийн эрх ашгийн төлөө тус хууль хорин жилийн хугацаанд дөрвөн удаа “мэс ажилбарт” орсон байна.

Уул уурхайн салбарыг урдаа барих эдийн засгийн бамбай болтол нь “ивээн тэтгэсэн” 1996 оны М.Энхсайханы Засгийн газрын туг болсон гол бүтээл нь 1997 оны Ашигт малтмалын тухай хууль. Сайн муу нийлж сав дүүрдэг ч сайн хууль батлахыг хичээсэн тарчиг эдийн засагтай 1996 оны Засгийн

газрын нэрийн хуудас болон түүхэнд үлджээ. Тиймээс л М.Энхсайхан ба түүний нөхдөөр овоглосон эрх чөлөөт лебираль хууль Монголын уул уурхайг дэлхийд танилцуулж, гаднын хөрөнгө оруулалтыг Монголд авчирсан юм. Зөвхөн уул уурхайн салбарт санхүүгийн эрх чөлөөг олгоод зогссонгүй, улс орны эдийн засгийн ачааны хүндийг уул уурхайд үүрүүлсэн билээ.

“Унтаа байсан уул уурхайн салбарыг энэхүү шинэ хууль сэрээж, гадаад худалдааны дүр төрхийг өөрчилж, харанхуй байсан хөрөнгө оруулалтын талбарт гэгээ татуулсан он жилүүд 1997 оноос тодорсон” гэж УИХ-ын Даргын зөвлөх Д.Даваасамбуу онцлов.

Уруудаж явсан эдийн засаг өсөлтөөр өндийж, эрдэс баялгийг нь дэлхий шохоорхож, тунхаг хуулийн үр дүнг сүүлийн 10 жилийн хугацаанд

монголчууд өдгөө хүчтэй мэдрээд эхэллээ. Эдийн засагт боломж, зах зээлд гарц нээсэн 1997 оны Ашигт малтмалын тухай хуульд хөшөө босгосон ч багадамгүй хэмээх мэргэжилтэн олон тааралдав.

Ашигт малтмалын тухай хуулийн алдаа оноог өнгөрсөн хугацаанд шүүн хэлэлцээд хоёрдахь нэмэлт өөрчлөлт ба шинэчилсэн найруулгын аль нэгийг нь шинэ УИХ-д оруулахаар зэхэж буй. “Нэмэлт өөрчлөлт бус шинэчилсэн найруулгын дүнд шинэ хуультай болж магадгүй” хэмээн Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа ярьсан.

Тэгэхээр уул уурхайн салбарын “улаан зангиа” гэж хэлж болох Ашигт малтмалын тухай хуульд сүүлийн зургаан жил гар хүрээгүй ч УИХ-ын шинэхэн болоод хашир гишүүд дээрх хуулийн сэвлэг дахийг удахгүй үргээж магадгүй нь. Түүнчлэн энэ ▶



хуулийн төслөөр “Иргэний танхим”-д хэд хэдэн удаа хэлэлцүүлэг өрнүүлсний зэрэгцээ эрдэмтэн, судлаачдын баг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор ажиллаж байна. Тэд уул уурхайн салбарын “малгай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар тус хуулийн алдаа эндэгдэл, зөрүүтэй ойлголт, үр дүнг засахаар анаж сууна.

Сайн хуультай байх нь хэтийн ирээдүйд тустайг бид мэдсэн бас мэдэрсэн. Тиймээс манайх 1997 оны Ашигт малтмалын тухай эцэг хуулийнхаа ачийг санаж, түүний “залуу нас”-ны алдаа оноог ярилцах нь зүйтэй. Ер нь уул уурхайн салбарыг тэтгэн бойжуулж, Монголын эдийн засгийг өөд нь татах үндсийг тавьсан эцэг хуульд талархах ёстой. Түүний алдааг нь бодитоор харж, амьдралд ойрхон, уул уурхайн салбартаа нийцтэй, хөгжил цэцэглэлтийн хөлд чөдөр тушаа болохгүй хууль эрх зүйн орчинтой болох нь нийтийн хүсэл. Тиймээс 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн мөн чанар, үнэт зүйлийг энэ удаа түлхүү онцоллоо.

Цаг үеийн шаардлагаар хууль эрх зүйн орчин хөдөлж, түүний хөдөлгөөн нь тухайн салбараа нийтэд нь хөндөж байдаг зүй тогтолтой. Учир нь хууль бол хууль. Түүнд хэн ч дур мэдэн гар хүрэх, дуртай үедээ засаад байх эрх мэдэл, хүч чадал, итгэл үнэмшил, эр зориг үгүй билээ.

Монгол Улсын УИХ Ашигт малтмалын тухай хуулийг 1994 онд баталсан түүхтэй. Тус хуульд байгалийн эрдэс баялаг ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байх эрхийг нээж, төр өмчлөгч хэмээн хуульчилжээ. Түүнчлэн ашигт малтмалыг хайх, ашиглах зөвшөөрлийг гадаад, дотоодын хуулийн этгээдэд олгох, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, иргэд Монгол Улсын газрын баялгийг эзэмших, ашиглах эрхийг ч мөн нээсэн. Товчхондоо хөтөч хууль юм.

Парламентын баталсан 1997 оны Ашигт малтмалын тухай хууль нь гаднын хөрөнгө оруулагчдад илүү таатай, зах зээлийн боломжийг нээсэн лебираль хууль болжээ. Мөн дэлхийн уул уурхайн оргил цагтай Монголын энэхүү хуулийн хэрэгжилт

дунд үедээ золгосон нь эртний ерөөл болсныг учир мэдэх хүмүүс билэгшээх. Лебираль хууль хэмээн онцлох болсон шалтгаан нь 1997 оны хуулийн мөн чанар юм. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарынхан болон хөрөнгө оруулагчдад тэгш боломж, нээлттэй бодлого барьсан нь түүний ач гавьяа гэж хэлж болно. 1997 оны Ашигт малтмалын тухай хуульд “...хуулиар тавигдах шаардлагыг хангасан өргөдөл гаргаж эхний ээлжинд бүртгүүлсэн этгээдэд хайгуулын лиценз олгоно”. “...Хайгуулын лиценз хүчин төгөлдөр байгаа талбайд зөвхөн уг лицензийг эзэмшигч ашигт малтмал ашиглах лиценз авахаар өргөдөл гаргаж болох ба үүнээс бусад тохиолдолд энэ хуулиар тавигдах шаардлагыг хангасан өргөдөл гаргаж, эхний ээлжинд бүртгүүлсэн этгээдэд ашигт малтмал ашиглах лиценз олгоно” гэсэн зүйл заалт дурайж байна.

Тэгвэл 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг дээрх хоёр хуулийн нэгдэл гэж уул уурхайн салбарынхан тайлбарлав. Гэхдээ тус хуульд түрүүчийн хуулиудаас ялгаатай зарим нэг зүйл заалт багтсан ч нэмэлт өөрчлөлт нэрийн дор хуулийн засвар өрнөсөн гэх аж. Тухайлбал, ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий, түгээмэл тархацтай, энгийн гэсэн ангилалтай болгож стратегийн ач холбогдол бүхий ордыг ашиглахад хайгуулыг хэний хөрөнгөөр хийж, нөөцийг нь тогтоосноос хамаарч, төрийн оролцооны хувь хэмжээг тогтоохоор хуульчилжээ.

Мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг нэмэгдүүлсэн, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, хайгуулын зардлын доод хэмжээг тогтоож өгсөн. Орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэгт илүү анхаарчээ. Гэхдээ энэхүү хууль нь 1994 оны уугуул хууль, 1997 оны эцэг хууль, 2006 оны суугуул хэв шинжийг багтаасан хэмээн мэргэжилтнүүд тэмдэглэсэн юм.

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчид, тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийнхэн сайн хууль, тогтвортой эрх зүйн орчинг л хүлээдэг. Геологи хайгуулаас олборлолт хүртэлх бүхий л үе шат, түүний дараах үйл ажиллагааны жанжин шугам нь 1997 оны Ашигт малтмалын тухай хууль. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сөргөлдөөний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Хорин жилийн хугацаанд дөрвөн удаа төрөл арилжсан ч 1997 оны Ашигт малтмалын тухай эцэг хууль үүргээ хангалттай биелүүлжээ. Уул уурхайн салбарын өсөлт хөгжил, өнөөгийн эдийн засгийн амжилтын тохироо нь 1997 оны дээрх хуулиас эхтэй болохыг эцэг хуулийн оргил цаг батална. ■

## Ашигт малтмалын тухай хуулийн түүхэн хөгжлийн үе шат

**1913** онд Богд хааны зарлигаар тогтоосон “Монгол Улсын хязгаарын дотор алт, мөнгөний зэрэг олон зүйлийн уурхай нээн шийтгэх дүрэм”

**1923** “Ардын засагт Монгол Улсын уурхай дүрэм”

**1988** Газрын хэвлийн тухай хууль

**1994** Ашигт малтмалын тухай анхны хууль

**1997** Ашигт малтмалын тухай хоёр дахь шинэ хууль

**2006** Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга

Эх сурвалж: МУУУА

## ЗАНАРЫН ЭРИН ЭХЭЛЧИХЭЖ

1980-аад оны дундуур Монгол Улс 20 тэрбум тонн шатдаг занарын нөөцтэй гэсэн тойм судалгааг геологчид хийжээ.

### Б.ЭНХ-АМГАЛАН

Дэлхийн нүүрсний холбооноос гаргасан судалгаагаар хүн төрөлхтөнд 118 жил хэрэглэх нүүрс байгаа бол газрын тосны 49, байгалийн хийн 59 жилийн нөөц үлдээд байгаа юм байна. Голлох ашигт малтмалын бүтээгдэхүүнүүдийн ашиглалтын хугацааг нийт улс орнуудын одоогийн хэрэглээгээр тооцож гаргасан байна. Гэвч дэлхийн улс орнуудын үйлдвэржилт жил ирэх тусам өргөжин тэлснээс үүдэн эрдэс баялгийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байгааг дэлхийн хэвлэл мэдээллийн байгууллагууд онцолсоор. Ингэхээр дээрх жилээр тооцсон нөөцийн үзүүлэлт өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагатай зэрэгцэн буурна гэсэн үг.

Тэгвэл шавхагдаж эхэлсэн нүүрс, газрын тос, байгалийн хийг бид юугаар орлуулж болох вэ? Энэ асуултад ганцхан үгээр хариулахад хангалттай аж. Занар. Магадгүй сэргээгдэх эрчим хүчний нөөц нар, салхийг орхигдуулж байна гэж үзэж болох юм. Гэвч нар, салхины нөөц хэдий шавхагдашгүй ч дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээг нэг дор хангах боломжгүй ажээ.

Их Британийн газрын тос, хийн үндэстэн дамнасан корпорацийн захирал асан Лорд Брауни “Занарын тос болон хий нь онцгой бүтээгдэхүүн юм. Учир нь бид эрчим хүчний үндсэн эх үүсвэрүүдийн хамгийн сүүлийнх рүү гар дүрэх гэж байна” хэмээн хэлжээ. Ингэхээр дэлхийн эрчим хүчний ирээдүйд занар ямар том байр суурь эзлэх нь тодорхой болж байна.

Одоогоос 40 гаруй жилийн өмнө буюу 1970-аад оны эхээр нефтийн үнэ өсөж эхэлснээс занарыг олборлож, үйлдвэрлэх нь эдийн засгийн хувьд ашигтай болж хувирчээ. Гэвч 1980-аад оны эхээр Ойрхи Дорнодод газрын тосны олборлолт огцом нэмэгдэхэд нефтийн зах зээлийн үнэ навс унаснаар (15 доллар хүртэл), шатамхай занарын олборлолт, ашиглалт эдийн засгийн хувьд ашиггүй болж, энэ салбар хумигдсан байдаг. Харин сүүлийн жилүүдэд хүн төрөлхтөний хөгжлийн явц хурдсан аж үйлдвэржилт тэлж, хүн ам хурдацтай өсөх болсноор газрын тосны хэрэгцээ өсч, үнэ нь ч тэнгэрт хадсан билээ (100 ам.доллар). Дээрээс нь газрын тосны нөөц шавхагдаж эхэлсэн нь занарын зах зээлийг хөдөлгөх гол хүч болоод байна. ▶



► Дэлхий нийтээр шатдаг занарыг сонирхож эхэлснийг сүүлийн үеийн үйл явдлаас тод харж болох юм. Өнөөдөр Австрали, Бразил, Аргентин Хятад, Эстони, Израйль, Иордан, АНУ тэргүүтэй улс оронд занарын том ордууд бий гэдэг. Харин занарын нөөцөөрөө дэлхийд эхний 20-т ордог Их Британи Улс саяхан задгай тэнгист санаанд оромгүй их хэмжээтэй буюу 28 их наяд тонн занар байж болох нөөцийг олж илрүүлсэн талаар дэлхийн хэвлэлүүд шуугиж байна. Энэ нь тус улсын эх газрын нөөцөөс тав дахин их гэсэн үг юм.

Одоогийн байдлаар Эстони, Бразиль, АНУ, Хятад зэрэг улс шатдаг занарыг олборлож, цахилгаан станцын түлш, шатахуун гаргаж авах хэлбэрээр ашиглаж байна. Харин Балтийн тэнгисийн эргээр нутагтай Эстони улс газрын хөрсөндөө шатдаг занараас өөр баялаггүй учир станцуудаа шатдаг занараар л галладаг аж. Тиймээс Йордан Эстони "Eesti Energia AS" компанитай хамтран 2016 онд 700 мегаваттын цахилгаан станц барихаар хэлэлцэж байна. Занарын тосны дөрөв дэх том нөөцтэй Иордан улсын тус станц занарын тосыг шатааж эрчим хүч гаргаж авах аж.

Гоулдман Сакс компанийн мэдэгдсэнээр АНУ 2017 он гэхэд Саудын Арабыг гүйцэж, өдөрт 10.9 сая баррель нефть үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа аж. Эрчим хүчний импортдоо жилд 300 орчим тэрбум доллар зарцуулдаг АНУ шатдаг занараас нефть гаргах үйлдвэрлэлээ хөгжүүлснээр 2030 он гэхэд Ойрхи Дорнодын газрын тосны ноёрхлоос бүрэн чөлөөлөгдөнө гэж тус улсын эрх баригчид үзэж байгаагаар олонд ил болгожээ. Гэвч саяхан газрын тосны ханган нийлүүлэгч "Baker Hughes Inc" компаниас газрын тосны үнэ энэ чигээрээ унасаар 80 ам.доллараас доош орвол АНУ-ын Хойд Дакота болон Өмнөд Техасын нутагт ажилллаж буй занарын тосны өрөмдлөг зогсоход хүрнэ гэдгийг анхааруулаад байгаа юм.

Дэлхийд одоогоор занарын 600 орчим ордыг илрүүлээд байна. ОХУ-ын академич Э.Волков "Судалгаануудын үр дүнд дэлхийн занарын нөөц 550-630 тэрбум тонн занарын давирхай буюу синтетик газрын тосыг агуулж байгааг тогтоосон. Энэ нь эдүгээ дэлхийд илрүүлээд буй түүхий газрын тосноос даруй дөрөв дахин их гэсэн үг юм" хэмээн тодорхойлжээ.

Хар, хүрэн, шаравтар саарал өнгөтэй шатдаг занар нь 10-50 хувь, заримдаа 60 хүртэлх хувийн кероген хэмээх органик бодис агуулсан шаварлаг тунамал чулуулаг аж. Занарын органик хэсэгт агуулагдах устөрөгчийн хэмжээ нь ямар ч нүүрснийхээс их бөгөөд давирхай нь бүтэц найрлагын хувьд түүхий газрын тостой төстэй тул түүнээс газрын тосны төрлийн бүтээгдэхүүн гаргаж авах боломжтой гэнэ. Шатдаг занар бага температурт (450-5500С) өндөр даралт

шаардахгүйгээр шууд задардаг тул технологийн боловсруулалт хийхэд хялбар. Занарын энэхүү шинж чанарыг түшиглэн шингэн түлш гаргаж авахад тохиромжтой гэж үздэг ажээ.

Тэгвэл занарыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж манайд байна уу. Нефтийн хувьд гадаадаас 100 хувь хараат манай оронд шатдаг занарын 60 шахам орд, илэрц байдаг бөгөөд Хөгшин Орхон, Дундговийн Баянжаргалан сум, гол хэсэг нөөц нь Дундговь, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий, Төв, Өвөрхангай Баянхонгор зэрэг аймагт байдаг юм байна.

Геологчид 1980-аад оны дундуур манай улс 20 тэрбум тонн шатдаг занарын нөөцтэй гэсэн тойм судалгаа хийжээ. Шатдаг занарын геологийн хайгуулын судалгаа одоогоор манайд түүхий гэж хэлж болно. Үүнийг нарийвчлан судалж, улмаар эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой эсэхийг нарийн тогтоох хэрэгтэй гэдгийг мэргэжлийн хүмүүс ярьдаг. Харин зарим хувийн компани занарыг сонирхож, гадаадын компаниудтай хамтран судалгаа шинжилгээ хийгээд эхэлсэн мэдээ бий.

Монгол Улсад занарын талаарх төрийн нэгдсэн бодлого, төлөвлөлт одоохондоо алга. Гэхдээ энэ талаар Эрдэс баялаг Эрчим хүчний яам, агентлагийн түвшинд ярьж буй асуудал байгаа гэнэ. УИХ-ын гишүүн Г.Баярсайхан "Шатдаг занарыг эдийн засгийн ач холбогдолтой түүхий эдэд оруулах шаардлагатай. Дотооддоо нефтийн бүтээгдэхүүн боловсруулан гаргах улмаар гадаадаас авдаг нефтийг орлож чадах ямар ч боломж, бололцоог дэмжих хэрэгтэй" гэв.

Занарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаараа цахилгаан дулааны станцуудын нүүрсний хэрэглээг багасгах талтай аж. Энэ нь нэг талаар утаа багасгах боломж гэсэн үг. Бидэнд хамгийн их хэрэгтэй нь дотоодын нефтийн хэрэгцээгээ бүрэн биш юм аа гэхэд тал хагасыг нь ч болтугай занарын тусламжтайгаар хангах.

Гэвч занарын олборлолт, боловсруулалт нь дэлхийн цаг агаарын дулааралд нэрмээс болж, хөрсний эвдрэл, агаар мандлын бохирдол гэх зэрэг байгаль орчны олон төрлийн сөрөг нөлөө дагуулах магадлал ихтэй гэж зарим эрдэмтэн үздэг байна. Учир нь шатдаг занарыг боловсруулахад ус, эрчим хүч асар ихээр шаардагддаг ажээ.

Орчин үеийн техник, технологи 1970-аад онтой харьцуулшгүйгээр хөгжсөн ч энэ нь нэг талаас занарыг олборлох технологи төгс болсон гэж үзэж болохгүйг харуулна. Харин технологи, олборлолтын хувьд өртөг өндөртэй энэ бизнес олон улсын анхааралд орж, хөгжлийн эрчим нь түргэсэж эхэлсэн нь технологийн шинэ шинэ боломжууд, үнэ өртгийн хувьд ч сонголт бий болох дохио биз ээ. ■

## ӨСӨЛТӨӨС ХӨГЖИЛД

МУИС-ийн Эдийн засгийн сургууль, Австралийн хэрэглээний эдийн засгийн зөвлөх компани БиЭйЭкономиксийн хамтарсан эдийн засгийн нарийвчилсан судалгаанд “Оюутолгой төслийн нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг 2020 он гэхэд одоо байгаагаасаа 35 хувиар өснө” гэсэн таамгийг эдийн засагчид дэвшүүлжээ.

### Б.АЛТАЙ

Ажилтай, орлоготой тун сайхан амьдрах боломж, бололцоо Монголд бий. Үүнийг олж харсан хөрөнгө оруулагчид, дэлхийн томоохон компани, аж ахуйн нэгж өөрийн салбар болоод төлөөлөгчийн газраа Улаанбаатарт байгуулах нь эрс олширлоо. Тэдний амьдрах сонирхол, ашигтай ажиллах баталгаа нь манай орны газрын хэвлийд буй алт, зэс, нүүрс, жонш, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн ашигт малтмалын ирээдүйн дүр зураг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, уул уурхайн баялгийн үр шимээр

монголчууд хөгжих, ашигтай ажиллах суурь нөхцөл нь бүрдэсний тэмдэг. Ердөө л нэг жилийн хугацаанд Монголын эдийн засгийн тоон үзүүлэлт нүд баясаж, сэтгэл татам ид шидийг үзүүлсэн нь дэлхий нийтийн анхаарлыг татлаа. Монголын эдийн засаг өнгөрсөн онд 17.5 хувиар өсөж, зэрэг зиндаа ойрхон орнуудын шарыг гозойлгож, “Их долоо”-г бараг л ичээв. Хятадын эдийн засгийн өсөлт манайхтай тун ойртсон боловч өсөн хувийн өсөлттэй тээр хойно, тоосонд дарууллаа. Монгол Улс эдийн засгийн ▶

ФОТОГ Б.Бямба-Очир



▶ эрчимтэй өсөлтөөрөө дэлхийд гайхуулж, ДНБ-ий хэтийн тэсрэлт нь айсуу хөгжлийн задаргааг улам ч бодитой болгосон нь энэ.

Эдийн засаг нь хамгийн хурдан хөгжиж буй орнуудыг Монгол тэргүүлж, үндэстэн дамнасан дэлхийн компаниуд Улаанбаатарт олон жилээр саатаж, хамтран ажиллахаар орон байрны эрэлд гарах нь ердийн үзэгдэл болчихож. Товчхондоо хуучин хүү шинэ хүү болов. Уул уурхайн салбар тодруулбал, дэлхийн хамгийн том алт, зэсийн нөөцтэй Оюутолгойн орд нь Монголыг дэлхийн төвд аваачлаа. Хамгийн багадаа л Өмнийн говьд 50 жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах Оюутолгой төсөл бүтээн байгуулалтын шатандаа Монголын эдийн засгийн дүр төрхийг өөрчилж, шинэ стандарт тогтоов.

Азийн цээжний гүнд, далай тэнгисээс алс хязгаар, эх газрын зүрхэн тушаа орших Монгол Улсын нийслэл Улаанбаатарт хөгжлийн салхи сэвэлзэх болсныг дэлхий нийт онцлох болсон. Улсынхаа нийслэлээс өмнө зүгт буй Оюутолгой ордыг тойрсон орон нутгийн дэвшил, тэнд буцалж буй хөгжил, бүтээн байгуулалт монголчуудыг Солонгос бус Өмнийн говь руу уруу татаж, тэнд амьдралаа төвхнүүлж эхэллээ. Уул уурхайн өгөөж, түүний үр шимийг монголчууд мэдэрч, улсаараа уурхайчин болохоор хошуурах нь энүүхэнд хэрэг. Учир нь Оюутолгой төсөл нь монголчуудыг ажлын байраар хангах томоохон эх үүсвэр болж байна. Өнөөдрийн байдлаар “Оюутолгой” компани үндэсний томоохон ажил олгогч, шилдэг татвар төлөгч, нийгмийн хариуцлагатай компани гээд бүхий л сайн нэрийг хүртсэн нь тэдний амжилт. Харин эдийн засагт үлдэж буй үр шимийг нь бид өсөлтөөс хөгжилд хөтлөх л хэрэгтэй бус уу. Түүнчлэн манай улсын гадаадын хөрөнгө оруулалтын түүхэнд хамгийн томд багтах зургаан тэрбум ам.доллар эдийн засагт түлхэц болж, өсөлтийг тулах багана гэвэл хол дэгсдэхгүй л болов уу.

МУИС-ийн Эдийн засгийн сургууль, Австралийн хэрэглээний эдийн засгийн зөвлөх компани БиЭйЭкономиксийн хамтарсан эдийн засгийн нарийвчилсан судалгаанд “Оюутолгой төслийн нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг 2020 он гэхэд одоо байгаагаасаа 35 хувиар өснө” гэсэн таамгийг эдийн засагчид дэвшүүлжээ. Мөн Засгийн газрын орлогын 30 хувийг Оюутолгой төсөл бүрдүүлж, төслийн хугацаанд дээрх орлого нь оргил үедээ жилд 1.3 их наяд төгрөг / нэг тэрбум ам.доллар/, жилд дунджаар 800 тэрбум төгрөг /620 сая ам.доллар/ байна гэжээ. Хэрэв “Оюутолгой” төсөл хэрэгжээгүй бол манай улсын эдийн засаг 2013-2020 онд долоон хувийн өсөлт л үзүүлэх байж. Харин төсөл хэрэгжсэнээр дунджаар 12.7 хувийн тогтмол өсөлтөөр эдийн засаг тэлэх тооцоо ч мөн гарчээ. Монголын эдийн засагт гарч буй “гаж” гэмээр гэнэтийн энэхүү өсөлтийн нууц нь 2001 онд Канадын Айвенхоу Майнз компанийн нээн илрүүлсэн Оюутолгой орд.

Зургаан жил шахам хэлэлцсэн Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээг “зуудаг нохой” мэт Монголын төр гацааж байсан. Гэлээ ч төрд хэрэгтэй, улс орны хөгжилд тус нэмэртэй орд газраа эдийн засгийн эргэлтэд оруулж, өсөлт хөгжлийн үүд хаалгыг нээсэн нь түүх болон үлдсэн. Хамтарсан Засгийн газрын хамтын бүтээл болох

Оюутолгой төсөл хамгийн сайн нь гэсэн үнэлэлт дүгнэлтийг ч улстөрчид өөрсдөө хөзрөө нээх мэт дэлгэн тавих болов. Эдийн засгийн өсөлт ч үүнийг нь нотолж харууллаа.

Өнөөдрийн байдлаар уурхайн үйлдвэрлэл эхлэхээс өмнө 7.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт Монгол Улсын эдийн засагт цутгаж, Засгийн газарт 300 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг “Оюутолгой” компани төлөөд байна. Мөн үйлдвэрлэл эхлэх ирэх 2013 оноос өмнө 900 орчим тэрбум төгрөгийн татвар, хураамж, төлбөрийг шилжүүлэхээр болжээ. Өнөөдөр уул уурхайн аварга том төсөлд өсөн мянга гаруй монгол гар бие оролцож, улсынхаа хөгжлийг сэтгэл зүтгэл, хөлс, хүчээрээ сүндэрлүүлж байгаа нь сэтгэл бахдам.

“Оюутолгой” компани уурхайн бүтээн байгуулалтаа 90 хувь давуулахын зэрэгцээ манай 1000 гаруй үндэсний аж ахуйн нэгжээс 1.7 их наяд төгрөгийн худалдан авалт хийсэн дүн бий. Уул уурхайн компани гээд урлаг соёл, спорт, боловсролоос хол хөндий байсангүй. Тэд боловсролын салбарт хамгийн том хөрөнгө оруулалт болох 110 тэрбум төгрөгийг бодитой, үлдэцтэй, үр дүнтэй оюун санааны дээрх мөнгөөр үл хэмжигдэх ирээдүйн ажиллах хүчинг бэлтгээд эхэллээ. Монгол Улс өсөлтөөс хөгжилд. ■

## Оюутолгойн тоон үзүүлэлт:

- 7.8 их наяд гаруй төгрөг (6 тэрбум ам.доллар)-2013 онд Оюутолгой уурхай ашиглалтад орохоос өмнө хийх хөрөнгө оруулалт
- 4.5 их наяд төгрөг (3.5 тэрбум ам.доллар)-2011 оны эцэс гэхэд Оюутолгой төсөлд хийсэн хөрөнгө оруулалт
- 320 тэрбум төгрөг (250 сая ам.доллар) -Оюутолгойн хөрөнгө оруулагчдаас Монгол Улсын Засгийн газарт одоогийн байдлаар төлөөд буй ашгийн татварын хэмжээ.
- 900 тэрбум төгрөг (700 сая ам.доллар) -Оюутолгойн хөрөнгө оруулагчдаас уурхай ашиглагдахаас өмнө Монгол Улсын Засгийн газарт төлөх татвар
- 10.4 тэрбум төгрөг (найман сая ам.доллар) -Оюутолгой компанийн хувь эзэмшигчдээс Оюутолгой төсөлд өдөр бүр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад зарцуулж байгаа мөнгөн дүн
- 30 хувь -Оюутолгой төслийн хугацаанд оргил үедээ жилд дунджаар 800 тэрбум төгрөгийн (626 сая ам.доллар) орлогыг Монгол Улсын Засгийн газар авна
- 35 хувь -Оюутолгой уурхай бүрэн хүчин чадлаараа ашиглалтад орох үед Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь хэмжээ.
- 9.621 Оюутолгой төсөл дээр ажиллаж буй монгол ажилчид

е е е е

## УСГҮЙ ХУУЛЬ УЛСЫН ИРЭЭДҮЙ

Боловсруулах үйлдвэр ашиглалтад орвол уул уурхайн баялгаас дутахааргүй хөгжил дэвшил ирж, олон зуун хүн ажлын байртай болж, гаднынхны хорхойг хөдөлгөж, чамгүй хөрөнгө оруулалт татах учиртай.

Х.АНАНД

Монголын хөгжил дэвшлийн тодорхой хэсгийг нуруундаа үүрч яваа газрын тосны салбарт хууль эрх зүйн таатай орчноос эхлээд олон шинэчлэл үгүйлэгдэж байна. Манай улс өнгөрсөн онд импортлосон нефтийнхээ 94.3 хувь буюу 990 мянган тонныг ОХУ, 2.3 хувийг БНХАУ, 1.5 хувийг Беларус, 0.8 хувийг БНСУ, мөн хэмжээний хувийг Литви улсаас авчээ.

Товчхондоо бол зам бүрт түгжрэл үүсгэж, нефтийн бүтээгдэхүүнээр ажиллаж буй бүхний түлшийг бид зуун хувь гаднаас авдаг. Энэ тухай олон жил ярьсны эцэст Дорнод, Дархан-Уул, Говьсүмбэр зэрэг таван газарт жилд дөрөв орчим сая тонн газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар болсон. Боловсруулах үйлдвэр ашиглалтад орвол уул уурхайн баялгаас дутахааргүй хөгжил дэвшил ирж, олон зуун хүн ажлын байртай болж, гаднынхны хорхойг хөдөлгөж, чамгүй хөрөнгө оруулалт татах учиртай.

Дэлхий дээрх нийт газрын тосны нөөц 2030-2040 он хүртэл л хүн төрөлхтөний хэрэгцээг хангах олон улсын шинжээчдийн дүгнэлт гараад байгаа ч бидэнд боломж бий. Урсдаг алтныхаа ашиг шимийг хүртэх хамгийн чухал зүйл бол боловсруулах үйлдвэрүүдийг нэн даруй ашиглалтад оруулах. Үүнд багаар бодоход дөрвөн жилийн хугацаа шаардлагатайг албаны хүмүүс хэлдэг. Газрын тос

боловсруулах үйлдвэрээ ашиглалтад ороход хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлсэн байж чадвал 1.6 сая тонн нөөцтэйгөөрөө 33 дугаарт эрэмбэлэгддэг Монгол Улс энэ салбартаа дэлхийд од болох сайхан ирээдүй бий.

Хууль зүйн орчныг таатай болгоно гэхээр гаднынханд ээлтэй, дотоодынхондоо халтай хууль санд мэнд баталчих гээгүй юм шүү. Эсвэл гаднын хөрөнгө оруулагчдыг боомилсон, үргээсэн зүйл заалт нэм ч гэсэнгүй. Ашиг л олж байвал бусад нь хамаагүй гээд гаднынханд үүд хаалгаа нээхдээ бус, тэднээс хамгаалж, харамлаж байна гээд хүчин чадалгүй техник технологитой, мэдлэг, туршлагагүй дотоодын зарим компанид эрх мэдэл өг гэж байгаа ч юм биш. Хамгийн гол нь энэ салбарт хөрөнгө оруулалт, цаг хугацаа, дадлага, туршлагатай зөв удирдлага хэрэгтэй байгааг мартаж учиргүй. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг байгуулагдсан. Тэдний найруулсан хуулийн төслийг шинэ Засгийн газар хэлэлцэж, батлах учиртай. Тиймээс эрхэм гишүүд тус хуулийн үг, үсэг бүрийг гярхай хянаж, өөрт ашигтай, өрөөлд хохиролгүй юм хийх шаардлагатай байна. Үгүй бол өөртөө юмгүй, үр хойчдоо өртэй үлдэх хэцүүхэн, хариуцлагатай цаг үе ирээд байна.

Нэг жишээ дурдъя. БНХАУ-ын хоёрхон компани 2010 онд Тамсаг болон Дорноговийн нутгаас нийтдээ 2.181.4 мянган баррель буюу 296.8 мянган тонн түүхий газрын тос олборлосон байдаг. Гэтэл Бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцлөөр дээрх хэмжээний газрын тосны дөрөвний нэг буюу ердөө 75 мянга орчим тонн нь л манайд үлдсэн байгаа юм. Энэ ч бас бага тоо. 1998 оноос хойш манайх нийтдээ есөн сая орчим баррель түүхий тос олборлож, бараг бүгдийг нь Хятад руу экспортолжээ. Түүнчлэн дотоодын жижиг компаниуд чадал муутай техник, төхөөрөмжөөр өч төчнөөн тэрбум төгрөг үрэн байж олсон жаахан тосныхоо ихэнхийг Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчмаар Засгийн газарт тушаадаг тухай гомдол тасардаггүй.

Энэ мэт гажуудал газрын тос боловсруулах үйлдвэр баригдаж дуусахад арилсан байх ёстой. Үгүй бол боловсруулах үйлдвэр дагаж орж ирсэн гаднын хөрөнгө оруулагчдын савыг нутгийн минь хэвлий дэх газрын тос дүүргээд, боловсруулах түүхий эдгүй үйлдвэрийн хэдэн төмөр арзайгаад үлдэх вий.

Өөр нэг жишээ байна. Газрын тосны хайгуул, олборлолт хийхэд гаднын компанитай хамтран ажиллах тохиолдолд гэрээнд заасан үүрэг, хариуцлагын бусад асуудлыг ▶



► нууцлах эрхийг хуулиараа олгосон байдаг аж. Энэ нь ямар нэг эрсдэл, хохирол амссан ч хуулийн дагуу бус хамтрагчдын гэрээнд заасан үүргээр зохицуулагдана гэсэн үг юм. Энгийнээр тайлбарлавал Ли хамт зүтгэж олсон газрын тосныхоо ашгийг аваад зугтчихлаа гэхэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага тооцох аргагүй болж байгаа юм. Учир нь бид хуулийн дагуу бус гэрээгээр хамтарч ажилласан гэдэг аж. Уг гэрээнд ямар ч “но” байхыг үгүйсгэх аргагүй. Бид шинэчлэн найруулж, баталж буй хууль бүрийнхээ үг, үсэг, цэг, таслал бүрт гярхай, хашир хандах хэрэгтэй. Мөн олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, усыг нь сайтар шавхаж, усгүй, хийгүй хууль батлах нь юу юунаас чухал. Засгийн газраас өнгөрсөн оны сүүлчээр “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого батлах тухай” төсөл баталсан. Гэхдээ энэ бол хууль биш хэрэгжүүлэх ёстой ажил юм. Тиймээс шинэ Засгийн газар ирэх дөрвөн жилд ямар шинэчлэл, бодлого явуулбал газрын тосны салбарт хөгжил авчирч, хурд нэмж болох тухай мэргэжилтнүүдийн санааг онцолъё.

### А.Эрдэнэпүрэв /Эрдэс, баялаг, эрчим хүчний яамны Түлшний бодлогын газрын дарга/:

-Засгийн газар, УИХ төвхнөөгүй ийм үед энэ талаар ярих нь нэг талаар эрт байна. Нөгөөтэйгүүр Монгол Улсын Засгийн газраас Газрын тосны салбарт 2017 оныг хүртэл баримтлах бодлого баталсан. Энэ бодлогод ирэх жилүүдэд хийж, хэрэгжүүлэх бүх чиглэл, ажлыг заасан байгаа. Үүнээс гадна Газрын тосны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг удахгүй хийнэ. Ингэхдээ одоо яригдаад байгаа Бүтээгдэхүүн хуваах гэрээний маргаан зэрэг элдэв асуудлыг цэгцэлнэ. Сайн хуультай болоод авбал Засгийн газраас баталсан баримтлах бодлогын дагуу ажил жигд явах учиртай.

Газрын тосыг зөвхөн шатахуун, нефтиэр төсөөлж, энэ хүрээнд авч хэлэлцэх нь өрөөсгөл. Газрын тос бол эрчим хүчний гол эх үүсвэр. Дэлхийн хамгийн үнэтэй, чухал зүйл газрын тос байгааг манайхан мэдэрч, ойлгож эхэлсэн. Газрын тос боловсруулах

үйлдвэр, түүхий эдийн хангамж, хөрөнгө оруулалт гээд Засгийн газрын хүрээнд ярилцаж, шийдвэрлэх ёстой чухал асуудал олон байна.

### Г.Баярсайхан /УИХ-ын гишүүн/:

-Газрын тосны салбар төрөөс хараат бус хөгжих ёстой. Нэг талаар төрийн оролцоотой учраас жигд, сайн хөгжихгүй байсан байх магадлалтай. Тиймээс энэ салбарт хүчээ үзэж буй хувийн хэвшлийнхэн төрийн оролцоог харж, хүлээх хэрэггүй юм. Газрын тос боловсруулах үйлдвэр удахгүй ашиглалтад орох ёстой. Тэр үед төрөөс хараат байх нэрээр ажлаа цалгардуулж болохгүй. Харин ч нээлттэй байх ёстой. Гадна, дотнын бүх хөрөнгө оруулагч, хамтран ажиллахыг хүсэгчдэд тендерийг нээлттэй зарлах нь өрсөлдөөнийг бий болгоно.

Удахгүй хэлэлцэх хуулиар өрсөлдөөнийг хэрхэн цэвэр байх ёстойг тодорхой гаргаад өгөх хэрэгтэй. Өрсөлдөөн бий болж, төрийн оролцоо тодорхой хэмжээгээр хумигдсан тохиолдолд энэ салбарт


хөгжил, цэцэглэлт ирнэ. Мөн хүрэн нүүрс, занараас шингэн түлш гаргах ажлыг яаралтай жигдрүүлэх хэрэгтэй. Хүрэн нүүрс, занар, газрын тос гурвыг хөтөлгөө морь шиг хамтад нь хөгжүүлбэл нефть, эрчим хүчний салбарт толгой өвдөх юмгүй болно. ►►

Монгол Улсын Засгийн газраас “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ 2011 оны арванхоёрдугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Үүнд:

1. Газрын тосны салбарын эрх зүйн орчныг сайжруулах;
2. Газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгож, газрын тосны салбарыг хөгжүүлэх;
3. Газрын тосны хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх;
4. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих;
5. Газрын тосны бүтээгдэхүүнээр тогтвортой хангах;
6. Газрын тосны салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх;
7. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, бүс нутгийг хөгжүүлэх зэрэг болно.

Засгийн газрын бодлогын хүрээнд дээрх долоон чиглэлээр 2017 он хүртэл бодит арга хэмжээ авахаа өнгөрсөн хавар амласан. Одоо бидэнд энэ салбарт шинэ ангийнхан юу хийхийг харах л үлдлээ. Бас их итгэл хүлээлгэж байгааг дамжуулах нь зүй биз ээ.



е е

## ДАРХЛАА БА УУРХАЙН ХААЛТ

Үүрийн гэгээ татаж, өтгөн манан газраас хагацаж ядан салах Монголын тэгш талд аль эрт чийг унажээ. Талын салхи зөөлөн үлээж, таанын үнэр хамар цоргих нь хэний ч сэтгэлийг сэргээж, мартагдсан гэгээн дурсамжийг сэдрээх хүчтэй ажгуу. Ай даа, Монголын тал нутаг минь диваажин гэлтэй. Нүдээ аниад, гараа алдлаад эх нутгийнхаа зөөлөн сэвшээг мэдрэх юутай аз жаргал. Гэтэл...

### Э.ЗОРИГТ

#### Гашуун түүх

Өнөөдөр бид уурхай гэх “мангас”-ын гарт онгон дагшин байгалийнхаа гоо үзэсгэлэнг хулгайлуулж, там мэт ухсан гүн нүх, тартагтаа тулсан байгалиа хараад шүүрс алдаж байгаа нь нууц бишээ. Ерөө, Хараа, Бороо, Баруун ба Баруун хойт Хэнтийн бүс нутгуудад XIX зууны эхээр уул уурхайн үйлдвэрлэл явуулж байсан болон түүнээс өмнөх үеийн гар аргаар олборлолт явуулж байсан талаар баримт мэдээ олон байдаг.

Гэхдээ 1922 онд Налайхын нүүрсний уурхайг улсын мэдэлд авснаар Монголын уул уурхайн салбарын шинэ үеийн түүх эхэлсэн гэдэг. Тухайн үед томоохон хэмжээний уул уурхай ашиглах туршлага манай улсад байгаагүй учраас уурхай гэх үг бидний дунд “хар толбо” үлдээсэн. Тухайлбал, Налайхын уурхайд 1989 онд шатамхай хийн тэсрэлт болж, олон хүний амь эрсдэн, уурхайн малталт эвдрэлд орсны улмаас тус уурхай хаагдсан. Харин өнөөдөр Налайхад ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн хүндрэлтэй асуудал ихээр хуримтлагдсан нь “уурхайн хаалт”-ыг төлөвлөөгүй, энэ талаар ямар ч төсөөлөлгүйгээр үйлдвэрлэл явуулж ирсэнтэй шууд холбоотой аж.

Тус уурхай гэнэт хаагдсанаас болж ажилгүйдлийн тоо ихээр нэмэгдсэн байна. Үүний улмаас ажилгүй иргэд

амиа тэжээхийн тулд гар аргаар нүүрс олборлож, амь насаа алдах эрсдэлд орж, энэ нь одоо ч үргэлжилсээр байгаа юм. Түүнчлэн өнөөдөр Төв аймгийн Заамар, Өвөрхангай аймгийн Уянга сум зэрэг газрууд уул уурхайн саварт уул нь тал, тал нь там болтлоо зэрэмдэглүүлээд байна. Тиймээс энэ тал дээр төр, засгаас дорвитой анхаарал хандуулах бодитой бодлого хэрэгжүүлэх цаг болжээ.

Бусад орны туршлагаар бол “Уурхайн хаалт” гээч зүйлийг маш нарийн авч үздэг ажээ. Тэгвэл “Уурхайн хаалт” гэж юувэ. ШУТИС-ийн Уул уурхайн инженерийн сургуулийн багш М.Дагва “Уурхайн хаалт бол маш өргөн цогц ойлголт. Ерөнхийд нь багцлаад хэлбэл уурхай хаагдах үед тухайн байгаль орчин, нийгэмд учирч буй сөрөг үр дагаврыг арилгах,

гэтлэн давахад чиглэсэн цогц үйл ажиллагаа” гэв. Олон улсын жишгээр уурхайн хаалтаар дараах хэд хэдэн асуудлыг шийдэх ёстой ажээ.

#### Нэг: Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх

Манай уул уурхайн компаниудын толгойны өвчин бол яах аргагүй нөхөн сэргээлтийн асуудал. Гэтэл нөхөн сэргээлт нь “Уурхайн хаалт”-ын ердөө л нэг хэсэг нь гэнэ. Өнөөдөр манай уул уурхайн үйл ажиллагаа явуулсан ихэнх талбайд мал хатгах өвсгүй нүцгэн тал, ширгэсэн голийн сайр л үлдэж, хүн амьтан амьдрах ч боломжгүй болгосон байдаг нь туйлын харамсалтай. Хамгийн сүүлийн мэдээгээр Ашигт малтмалын газраас хийсэн уул уурхайн үйлдвэрлэлийн ▶



► улмаас эвдэрсэн газрын тооллогод 15 аймгийн 56 сумын нутгийн 500 гаруй нэгж талбайг хамруулжээ. Уг тооллогын дүнгээр Монголын нутаг дэвсгэрийн 3984.46 га талбай эвдрэлд орсныг тогтоосон байна. Чухам энэ их талбайг хэн сүйтгэсэн нь тодорхой бус байгаа гэнэ. Уул уурхайн салбар дахь байгаль орчин хамгаалал төслийн үндэсний зохицуулагч С.Энхболд “Өнөөдөр манайд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компани, тухайн компанийн захирлаас аваад цэрэгт нь хүртэл уул уурхайн ашиглалт явуулсан л бол нөхөн сэргээлт зайлшгүй хийх учиртай гэдэг оюуны үрийг тархинд нь суулгаж өгөх хэрэгтэй. Тархинд нь энэ төрлийн үр суугаагүй тохиолдолд хичнээн үр тариад ургахгүй шүү дээ” гэсэн юм. Энэ нь хууль эрх зүйн орчин Монгол Улсад ямар байгааг харуулахаас гадна гарсан ганц нэг журмыг биелүүлдэг нь цөөн гэдгийн тод илрэл юм.

Ийм асуудлыг шийдэхийн тулд гаднын зарим оронд тухайн компаниас нөхөн сэргээлтийн урьдчилсан барьцаа хөрөнгө авахаар журамласан байдаг аж. Тухайлбал, Германд нийт нөхөн сэргээлтийн зардлын 50-иас доошгүй хувийг уул уурхайн компаниудаас урьдчилан авдаг байна. Мөн газар нутгийг урьдын байсан хэвэнд оруулах, тэр ч бүү хэл амралт соёлын газар байгуулах зэрэг үүргийг гэрээндээ давхар тусгаж өгдөг аж. Хэрвээ шаардлагыг биелүүлэхгүй бол барьцаа хөрөнгийг нь буцаан өгөхгүй гэсэн үг. Уг нь манайд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө гаргуулах талаар хуулийн заалт байдаг ч төгс бус, дээрээс нь дагаж мөрддөггүй.

Гэхдээ бас сайн мэдээ байна аа. Сүүлийн жилүүдэд манай уул уурхайн салбарт гаднын томоохон тоглогчид орж ирсэнтэй холбоотой уул уурхайг дагадаг бараан нэрийг засаж залруулах зарим нэг үйл ажиллагааг явуулж эхлээд буй. Тухайлбал, “Пибоди Винсвей ресорсез” ХХК-ийн Эрээний нүүрсний уурхайн нөхөн сэргээлтийг

энд дурдаж болно. Хэдийгээр тус компанийн нөхөн сэргээсэн талбай том биш ч нөхөн сэргээлтийг ном журмынх нь дагуу хийж, талбайдаа урт хугацааны мониторинг, хяналт тавьж байгаа аж. Нөхөн сэргээлт нь өнөөдөр хэдэн ургамал тарьчихаад мартахыг хэлэхгүй. Харин урт хугацааны хяналт шалгалт хэрэгтэйг мэргэжилтнүүд нь онцолсон.

Нөхөн сэргээлт нь тухайн орны байгаль, цаг уурт тохирсон өвс, ургамал тарих цаашлаад тухайн орчинд ан амьтад нутагшуулах, ажлын биелэлтэд урт хугацааны судалгаа хийх цогц үйл ажиллагаа ажээ. “Пибоди Винсвей ресорсез” ХХК-ийн хувьд урт хугацааны хяналт тавих тал дээр ихээхэн анхаарч байгаагаараа бусдад үлгэр дуурайлал болж байна.

Харин сүүлийн үед “Бороо гоулд” компанийн нөхөн сэргээлтийн туршлагаас уул уурхайн бусад компани нэвтрүүлж эхлээд байгаа аж. Тус компаниас нөхөн сэргээлтийн талаар туршлага солилцох, энэ талын дэмжлэг авах зэрэг асуудлаар ханддаг болсон байна. Компанийн Байгаль орчны мэргэжилтэн Г.Мөнхжин “Манай компани 2003 оноос хойш нөхөн сэргээлт хийж байна. Үүндээ орон нутгийн иргэдийг түлхүү оролцуулдаг. “Бороо гоулд” компанийн хувьд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, нутгийн хөгжилд аль болох түлхүү анхаарч ирсэн. Манай хэлтэс жил бүр 50-60 хүнийг түр ажлын байраар хангадаг” гэв.

Тус компани 2011 оны байдлаар 320 орчим га газрыг нөхөн сэргээж, холбогдох газарт чанар, стандартын дагуу хүлээлгэн өгчээ. Ийм хэмжээний газарт биологийн нөхөн сэргээлтийг амжилттай гүйцэтгэсэн уул уурхайн компани Монголд ганцхан бий. Тэр нь “Бороо гоулд” гэнэ.

Монгол Улсын хэмжээнд уул уурхайн компанийн нөхөн сэргээлт хийсэн талбай 2004 онд 134 га байсан бол 2009 онд 8023 га болж 60 хувьд хүрсэн байна. Биологийн нөхөн сэргээлт 2006 онд 690 га байсан бол 2009 онд 3593 га

болж 23 хувиар өсчээ. Өнгөрсөн хугацаанд нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ энэ мэт бага багаар нэмэгдсэн боловч чанарын хувьд хангалттай хэмжээнд хүрч чадаагүйг мэргэжилтнүүд ярьсан.

Монгол Улсын өнөөдрийн хөгжлийн жор нь уул уурхай гэх ганц эх үүсвэрээс хамааралтай болоод байгаа. Харин тус жорын гол амин дэм нь Оюутолгой, Тавантолгой зэрэг дэлхийн түвшний томоохон төслүүд бөгөөд түүнтэй зэрэгцэн өөр бусад нүүрсний уурхай олноор нээгдэж эхэллээ. “Эдгээр төсөл алтны шороон ордуудаас ялгаатай нь тухайн уурхай илүү олон жил ашиглагдах бөгөөд газрын гүнд 200–600 метр магадгүй түүнээс ч илүү гүн ухаж, газрын хэвлийг эргүүлнэ. Үүнийг дагаад бүс нутгийн болон улсын хэмжээнд эерэг болон сөрөг үр дагавар мэдрэгдэх болно. Тиймээс хууль эрх зүйн орчинг зайлшгүй шинэчлэх шаардлагатай” хэмээн мэргэжилтнүүд ярьдаг. Эдгээр томоохон уурхай нь ►





“Бороо Гоулд”: Орон нутгийн иргэд нөхөн сэргээлтэд оролцож байгаа нь

► өнөө жил ухсан нүхээ дараа жил дахин гүнзгийрүүлээд явах тул жил бүр уурхайд нөхөн сэргээлт хийхийг шаарддаг манай хуулийн зохицуулалт хэрэгжих боломжгүй болох юм байна.

### **Хоёр: Уурхай хааснаас хойшх нийгмийн болон дэд бүтцийн асуудлыг цогцоор нь шийдэх**

Энэ бол бидний ярих ёстой хамгийн чухал асуудал. Уг нь бид өнөөдрийн өөхнөөс маргаашийн булчирхай дээр гэх ухагдахуунтай ард түмэн. Гэтэл энэ ухаанаа уул уурхайд төдийлэн гаргахгүй байх шиг. Хэдийгээр Оюутолгой, Тавантолгой тийш төмөр зам тавих, тэнд хот байгуулах нь зайлшгүй хэрэгтэй ч ордуудын ашиглах хугацаа дуусахаар яах вэ. Хэнд ч хэрэггүй “төмрийн хог” болж үлдэх үү. Энэ талаар эртнээс бодолцох шаардлагатай байна. УИХ-ын гишүүн асан Д.Энхбат “Ирээдүйд манай уул уурхайг тойрсон олон хот, бүтээн байгуулалт бий болно. Харин тэр үед тогтвортой, системтэй хөгжлийг бий болгож чадаагүй бол миний тооцоолсноор 50 гаруй жилийн дараа Монгол Улс 200 орчим Налайх шиг хоттой болно” гэсэн байна.

Өнөөдөр ярьж буй томоохон уурхайнуудыг хаах тэр үед тухайн орны хөгжил цэцэглэлтээс аваад нийгмийн асуудалтай холбоотой олон асуудал хөндөгдөх нь дамжиггүй. Тэдгээр асуудлын ихэнх нь томоохон хэмжээний эрсдэл дагуулдаг байна. Тухайлбал, уурхай гэнэт хаагдахад орон нутгаас авч ажиллуулж байсан олон мянган хүнийг яах вэ гэсэн асуулт гарч ирнэ. Тухайлбал, Оюутолгойд ажиллаж буй 10 мянга гаруй ажилчин мөн үйлдвэрлэл эхлээд ажилд орох 3000 мянга орчим хүн уурхай хаагдахад хаана юу хийх билээ гэдгийг л урьдчилан тооцоолох тухай асуудал юм. Уурхайн хаалтын хамгийн том асуудал бол энэ.

“Ядуурал байгаа цагт байгаль дэлхий сүйддэг гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрсөн. Тиймээс уурхай хаахтай холбоотойгоор иргэд ажилгүй болбол яах вэ, тэд байгаль дэлхийг сүйдэлж эхэлнэ. Энэ алдааг уул уурхайн компаниуд аль болох гаргахгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй байна. Манай улс байгалийн баялаг ихтэй учраас өнөөдөр ажиллаж байсан жижиг уурхайнууд маргааш хаагдлаа гэхэд нөгөөдөр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хаа нэгтээ шинэ уурхай нээгээд тэндээ ажилчдаа ажиллуулж байгаа. Харин

Оюутолгой, Тавантолгой гэсэн том уурхайнууд хаагдахад юу болох вэ гэдгийг л бодох нь чухал” хэмээн С.Энхболд ярьсан.

Мөн орон нутагт тухайн уурхайгаас татвар, хураамж хэлбэрээр орж байсан орлого зогсохоор тус орон нутгийн амьдрал яах вэ гэх мэт олон асуудал хөндөгдөнө. Тиймээс уул уурхайн зөв менежмент явуулдаг орны Засгийн газар уул уурхайн компаниудтай анх гэрээ хийхдээ л холбогдох шаардлагуудыг тавьж, төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих байдлаар хариуцлагатай ажилладаг байна.

Уул уурхайн хөгжлөөрөө тэргүүлэгч Австралид уурхайг хаах хоёр үндсэн үйл явц байдаг аж. Нэгдүгээрт, уурхайн үйл ажиллагаа эхлэхтэй хамт хаалттай холбоотой төлөвлөгөөг тухайн компани зайлшгүй боловсруулах ёстой. Талууд хоорондоо зөвшилцөж, тухайн сум орон нутгийн иргэдтэй нээлттэй хэлэлцүүлэг явуулж, санал бодлыг нь сонсдог аж. Ингэснээр орон нутагт нийгэм, эдийн засгийн суурийг бий болгох тал дээр уул уурхайн олборлолт явуулж буй компаниуд зайлшгүй ►►



Нөхөн сэргээлт хийсний дараа

анхаарах шаардлагатай болдог нь урт хугацааны төлөвлөлт юм. Хоёрдугаарт, уурхайг хаах үетэй холбоотой богино болон дунд хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг компаниас заавал шаарддаг. Тухайлбал, уурхайг хаахтай холбоотой орон нутагт гарах нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулах зорилгоор сургууль, эмнэлэг, үйлдвэр үйлчилгээний газар байгуулах, уурхайн ажилчдыг хэрхэн бусад салбарт шилжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэдэг аж.

Энэ мэт цөөн хэдэн жишээнээс үзэхэд уурхайн хаалт нь эрх зүйн нарийн зохицуулалт, төслийг хэрэгжүүлэгч, хянагч болон бусад бүх оролцогч талаас ихээхэн хүчин чармайлт шаардсан, анхнаас нь төлөвлөж, төсөвлөж явах асуудал гэдэг нь тодорхой харагдаж байна. Харин өнөөдөр манайд энэ талын журам, заалт дутуу дулимаг байгааг М.Дагва багш хэлсэн юм.

### **Гурав: Уурхай ашиглаж байгаад хаагдсан газарт аюулгүй орчин бүрдүүлсэн байх**

Манайхан энэ тал дээр ам ангайдаггүй гэхэд болно. Аюулгүй

орчин бүрдүүлэхийг олон улсад ерөнхийд нь “Ажиллаж, амьдрах явцад тухайн хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эрсдлээс хамгаалах үйл ажиллагаа” гэж үздэг байна.

Тэгвэл уг дүгнэлтээр манайд тийм аюулгүй орчин бүрдсэн уул уурхай байхгүй гэдгийг нотлох жишээ олон шүү дээ. Тухайлбал, Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын малчин Ц.Баасан “Алтны уурхайн буруутай үйл ажиллагаанаас болоод иргэд ундны усны дутагдалд орж байна. Хавар, зуны цагт ширгэсэн голын сайраас ус гаргаж уудаг. Гэхдээ энэ нь чанарын шаардлага хангадаггүй. Чанаргүй уснаас үүдэлтэй өвчлөл манайд газар аваад байгаа. Уул уурхайн олборлолт явуулж ухсан нүхэнд мал амьтан тэр ч бүү хэл хүн хүртэл унаж бэртсэн удаатай” гэсэн юм.

Уг нь дээрх олон улсын шаардлагад нийцдэг энэ мэт ажлуудыг л амьдралд хэрэгжүүлж чадвал уул уурхай гэдэг хүмүүсийн сэтгэлд айдас хургуулсан “хар

шид”-ийн хүч мэтээр ойлгогдохгүй. Харин ч эсэргээрээ хөгжлийг тэтгэгч, эрдэнэсийн эх уурхай гэх ухагдахууныг иргэдийн сэтгэхүйд суулгаж болно гэх. Уул уурхайн хөгжлийн ачаар Монгол Улс мөнгөтэй болж, хөгжлийн талаар ярьж байна. Гэхдээ уурхайнуудыг хаасны дараа тулгарах асуудлыг одооноос анхаарахгүй бол бид ирээдүйд сэглэгдсэн байгаль, улс орныг хойч үедээ хүлээлгэн өгч болзошгүй юм. Үүнийг л олон улсад “Баялгийн хараал”, “Голланд өвчин” гэж нэрлэдэг. Харин “Баялгийн хараал”-ын хариулга, “Голланд өвчин”-ий эсрэг тэмцэх хүчтэй дархлаа нь зөв зохистой “Уурхайн хаалт” юм.

Төрөөс энэ асуудалд төмөрнүүрээ гаргаж, уул уурхайн компаниудад зөв шаардлага тавьж, хариуцлага тооцохын зэрэгцээ хамтран ажиллах хэрэгтэй байна. Зөвхөн нөхөн сэргээлт гэх ганцхан зүйлийг бус зөв зохистой уурхайн хаалтын талаарх ойлголт, мэдлэг мэдээлэл өгч, сургалт семинар явуулж ажиллах ёстой. Ингэж ажиллаж чадвал уул уурхайн салбарт байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах эхлэлийг зөв зохистой тавьж улмаар хэрэгжүүлж, хөгжүүлж болох ажээ. ■

## ГЕРМАНЫ КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ТАНИЛЦЛАА



ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн КНХ-ын мэргэжилтэн О.Батболд Германы бизнес эрхлэгчдэд Монголын уул уурхайн салбарын тухай илтгэж байна

Петер Кустерер “Компанийн нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд байгууллагынхаа стратеги, үнэт чанарыг ойлгосон байх нь маш чухал. Бид нийгэмд технологи, ноу-хау, шинэчлэлээр дамжуулан хувь нэмэр оруулахыг зорьдог” гэв.


Түүрүүч нь №13 (023) дугаарт

### Х.ХУЛАН

ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрөөс зохион байгуулсан Германы шилдэг компаниудын нийгмийн хариуцлагын туршлага судлах аяллаар уул уурхай, хүнд аж үйлдвэр төдийгүй бусад чиглэлийн компаниуд нийгмийн хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлдэгтэй танилцсан билээ. Явуулж байгаа үйл ажиллагаанаас хамаараад компаниудын нийгмийн хариуцлага өөр хоорондоо ялгаатай ч бүр онцлогтоо үндэслэн КНХ-ын стратегиа боловсруулсан Германы компаниудын зорилго нэгдмэл юм.

### Бод!

Мэдээллийн технологийн компанид ус, агаар мэт чухал зүйл юу байдаг бол? Энэ асуултад хариулахын өмнө дараах түүхийг сонирхуулъя. Одоогоос зуугаад жилийн өмнө өвлийн жихүүн нэгэн өдөр Америкийн томоохон компаниудын бизнес эрхлэгчид уулзжээ. Тэд өглөө бүр найман цагт цугларч, шинэ санаа хөгжлийн тухай яриа өрнүүлдэг уламжлалтай байж. Гэтэл нэгэн өдрийн уулзалтаар ярих сэдэв олдсонгүй. Тэгтэл тухайн үед “Нэшнл кэш рэжистер” ▶



“АйБиЭм” компанийн бүтээгдэхүүний танилцуулга. Баруун гар талаас: Компанийн иргэншлийн асуудал хариуцсан дарга П.Кустерер

▶ (“National Cash Register”) корпорацид маркетингийн албаны даргаар ажиллаж байсан Томас Ж. Уотсон индэр дээр гарч “Бид сайтар бодож чадахгүй байгаа нь бэрхшээл учруулж байна. Тиймээс сайн бод” гэж хэлжээ. Тэрбээр БОД! хэмээх энгийн мөртөө гүн утгатай уриагаа “АйБиЭм” (IBM) компанийн захирлын албан тушаалд дэвшихээсээ өмнө ийнхүү хэлсэн ажээ. Бод!

Өнөөдөр дэлхий дахинаа 400 мянгаад шинийг санаачлагч “АйБиЭм”-чүүд (IBMers) үйл ажиллагаа явуулдаг. Тэд бүтээлчээр бодож, сэтгэдэг учраас олон улсын тавцанд мэдээлэл технологийн “хаан” компани болжээ. Энинген хотод байрлах “АйБиЭм” (IBM- International Business Machines гэсэн үгийн товчлол) компанид очиход хамгийн түрүүнд бүтээгдэхүүн, эрүүл мэндийн салбар дахь судалгааны ажлаа танилцуулсан юм. Эрдэм шинжилгээний ажилд жилдээ зургаан тэрбум ам. доллар зарцуулдаг тус компани эрүүл мэндийн салбарын судалгаанд ихээхэн ач холбогдол өгдөг. Нанотехнологи, ховор өвчний оношлогоо, суперкомпьютинг, силикончипын технологи гэхчлэн хүн төрөлхтөний сайн сайхан амьдралд чиглүүлсэн судалгааг тасралтгүй явуулдаг аж. Мөн “клауд компьютеринг”-ийн (Cloud Computing) технологийг анх удаа амжилттай нэвтрүүлсэн тэргүүн туршлагатай.

Мэдээлэл технологийн компани ч гэсэн “ногоон” байж болох бөгөөд үүний тод жишээ бол “АйБиЭм” юм. Ажилчид заавал оффисын байранд бус, гэртээ ажиллахыг албан ёсоор зөвшөөрдөг онцлогтой аж. Өөрөөр хэлбэл, ажилчид нь байгууллагын дотоод сүлжээгээ ашиглан дэлхийн хаанаас ч ажиллах боломж нээлттэй байдаг байна. Тус компанийн ажилчдын гуравны хоёр нь “мобайл” арга барилыг сонгожээ. Компанийн иргэншлийн (Corporate citizenship) асуудал хариуцсан дарга Петер Кустерер жишээ нь даваа гаригийн өглөө ажилдаа аажуу ирдэг. Тэрбээр гэртээ цахим шуудангаа шалгачихаад замын түгжрэл арилсан үед ажил руугаа гардаг байна. Мөн стратегийн бодлого боловсруулах, илтгэл бэлдэх ажлаа ч гэртээ хийдэг хэмээн ярьсан юм.

#### Компанийн иргэншил

Томоохон компаниуд хандив, тусламж хүссэн захидал байнга авч байдаг нь энэ нийгмийн нэгэн онцлог юм.

Дэлхийн бүх оронд нийтлэг байдаг зүйл. Харин “АйБиЭм” энэ тал дээр өөрийн гэсэн хил хязгаарын заагийг тогтоосон байна. Жишээ нь, спортын арга хэмжээг дэмжихгүй гэжээ. Спортыг чухал бус гэж үздэгтээ биш харин ч хангалттай их тусалцаа авдаг салбар тул спортоос өөр чиглэлийг дэмжихээр тогтсон байна. Петер Кустерер “Компанийн нийгмийн хариуцлагын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд байгууллагынхаа стратеги, үнэт чанарыг ойлгосон байх нь маш чухал. Бид нийгэмд технологи, ноу-хау, шинэчлэлээр дамжуулан хувь нэмэр оруулахыг зорьдог. Иймд биднээс бэлэн мөнгөний тусламж гуйсны хэрэггүй” хэмээн хэлдэг тухайгаа сонирхуулсан.

#### Дэлхийн иргэн

Тус компани мэдээллийн технологийн бүтээгдэхүүн боловсруулахаас гадна нийгмийн сайн сайханд зориулсан олон үйл ажиллагаа явуулдаг. Тэд “Дэлхийн иргэн” хөтөлбөрийг санаачлан, цэнхэр гаригаа тогтвортой хөгжилд чиглүүлэн ажиллаж байна. Энэ нь ажилчид зөвхөн компанийн ажилчны үүргээ бус, хувь хүн талаасаа нийгэмдээ ихэвчлэн сайн дураараа хувь нэмрээ оруулахыг хэлж байгаа юм.

#### “Компанийн үйлчилгээний корпус” (Corporate Service Corps) хөтөлбөр

Тус хөтөлбөрт хамрагдсан “АйБиЭм”-чүүд хөгжиж буй орнуудад очиж, мэдлэг чадвараа дайчлан сайн дурын үндсэн дээр ажилладаг. Өнөөгийн байдлаар 1400 сайн дурын оролцогч дэлхийн 20-иод оронд очиж, орон нутгийн засаг захиргаатай нь хамтарчээ. Жишээ нь, тэд Вьетнамын Хо Чи Минх хотод хүнсний аюулгүй байдал, усны менежмент, тээвэр, экологийн тогтолцоо хөгжүүлэх гэсэн дөрвөн чиглэлээр ажиллажээ.

#### Тусч хамт олон

Нэгэн хотод 0-3 настай хүүхдэд зориулсан өдөр өнжүүлэх нээх гэтэл санхүүжилт олдоогүй байна. АйБиЭм-ийн софтвер харууцсан ажилтан бусадтайгаа ярилцаад энэхүү арга хэмжээг хариуцахаар шийджээ. Тэрбээр санхүүгийн ажилтны бодож өгсөн тооцоог оруулан “янзтай сайн” илтгэл бэлдсэн байна. Түүнийгээ хотын бүх жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үзүүлж дэмжлэг тусалцаа хүссэнээр үйл ажиллагаа явуулах хэмжээний хандив цуглуулж чаджээ. Энэ нь мэргэжлийн ур чадвараа ашиглан бусдад хэрхэн тусалж болохыг харуулж байна.

#### Боловсрол

“АйБиЭм” цэцэрлэг, сургуулиудад зориулж тусгай программ суулгасан компьютер хандивладаг байна. Хүүхдүүд өнгө, дүрс, тоо, үсэг заахаас гадна англи хэлний дуудлагыг нь хүртэл засаж өгдөг шидтэй компьютер аж. (“KidSmart Young Explorer”, “Reading Companion” программ, “Forbidden city” тоглоом)

#### Нийгмийн бэрхшээлд шийдэл

“Дэлхий нийтийн сүлжээ” (World community grid) хөтөлбөрийн хардвэйр, софтвер болон бусад бүх ▶

► техникийн үйлчилгээг “АйБиЭм” зохиосон байна. Энэхүү төсөл нь технологи ашиглан асаастай компьютер, ноутбукийн эрчим хүчийг эрдэмтдийн судалгааны ажилд зарцуулдаг байна. Үүний тулд Та компьютер дээрээ тусгай программ суулгахад л хангалттай.

“АйБиЭм” өөрийн “Бизнесийн үйл ажиллагааг нийгэмд эерэг нөлөөлөл бий болгоход чиглүүлнэ” гэдэг хариуцлагын зарчмаа технологи, ноу-хау, шинэчлэл ашиглан биелүүлдэг ажээ.


## Нийгэмд хөрөнгө оруулагч: Дойче банк

КНХ-ын аяллын тав дахь өдөр уул уурхайн компанийн төлөөлөгчид технологийн бүс нутаг Карлсруэ хотод хүрэлцэн очсон юм. Алдартай Бенц маркийн машиныг зохион бүтээгч Карл Фридрих Бенц 1844 онд тус хотод төрсөн билээ.

Бид Карлсруэ хотын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаатай танилцсаны дараа “Дойче банк”-ны нийгмийн хариуцлагын туршлагаас хуваалцсан.

Германы “Дойче банкны” байрны давхар бүрийн ханыг жаазтай зураг чимсэн байлаа. Өнгө өнгийн цэцэгстэй зураг, орчин үеийн урлагийн бүтээлүүд олны харааг булаах аж. Хоёр жил тутамд зургуудыг сольдог гэж тус банкны Олон улсын арилжаа хариуцсан захирал Михаель Шпек хуучлав. “Дойче банк” нь урлагийн бүтээл, сонгодог хөгжмийг дэмжихийг КНХ-ын бодлогоо гэж үздэг юм байна.

Компанийн нийгмийн хариуцлагыг өнөөгийн нийгэм болон түүний ирээдүйд оруулах хөрөнгө оруулалт гэж тодорхойлсон тус банк нийгмийн эд баялгийг бүтээхийг гол зорилго болгожээ. Өнгөрсөн онд компанийн нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд 83 сая евро зарцуулсан гэнэ. КНХ-ын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг салбараар нь авч үзвэл:



Дэлхийн 72 оронд 100 мянган ажилчинтай “Дойче банк” боловсролын салбарыг онцлон авч үздэг. Нийгмийн гарлаасаа шалтгаалан боловсрол эзэмших боломжгүй авьяастай хүүхэд, залуучуудыг түлхүү дэмждэг ажээ. Жишээ нь 19 настай Нигери гаралтай Вивин Окоқд банкны Англи дахь салбарын ажилтан Мэри-Луиз Грэй тусалж зөвлөгөө өгч, хамтарч ажилласны үр дүнд Вивиан нийгмийн ухааны чиглэлээр тэтгэлэгтэй суралцагч оюутан болсон байна. Вивиан өнөөдөр их сургуулиа төгсөх гэж буй аж. Германы “Дойче банк” ажилгүйдэл, ядуурлыг



Карлсруэ дахь “Дойче Банкны” салбар дээр

бууруулж дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн Microfinance Invest, Consortium, FINCA, Alfred Herrhausen Fund of Deutsche Bank Foundation, Street Smart, Cool Roofs зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

### Ногоон хөгжлийг дэмжигч

“Дойче банкны” Нью-Йорк дахь төв салбарын байрны дээвэр дээр 122 кВ нарны фотоволтаик системийг суурилуулжээ. 244 метрийн өндөрт байрлах энэхүү технологи нь банкны оффисын эрчим хүчний хэрэглээг бууруулж, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг жилд 100 метрийн тонноор багасгадаг ажээ. Мөн тус банк Итали, Испанид ч гэсэн нарны эрчим хүчний хоёр паркийг барьсан байна. “Дойче банк” Европын шилдэг сэргээгдэх эрчим хүч хэрэглэгч санхүүгийн байгууллагаар хоёр жил дараалан шалгарчээ.

### “Нийгэмд хөрөнгө оруулах нь мөнгөнөөс илүү”

Дэлхийн хэмжээнд 19 мянган “Дойче банк”-ны ажилчид сайн дураараа гурван мянга гаруй ашгийн бус хамтрагч байгууллагыг дэмжин ажиллаж байна. Тэд ашгийн бус байгууллагуудад санхүү, чанарын менежмент, төслийн удирдлага, маркетинг, мэдлэгээ хуваалцаж, гар бие оролцдог аж. Банкны удирдлагын зүгээс ажилчдынхаа идэвх, зүтгэлийг үнэлэн “Дойче банкны сайн дурын ажилтны шагнал”-ыг хүртэл бий болгосон байна. Ийм сайн дурын төсөл дээр ажиллаж буй ажилтан жилд нэг удаа бүтэн өдрийн чөлөөгөөр шагнуулдаг аж. Жишээ нь, Сингапур дахь тус банкны ажилтан Онна Лю хөгшчүүлийг асардаг “Concern and Care” нийгэмлэгтэй хамтарч ажилладаг. Асрамжийн ахмадууд, өвчтэй хүмүүстэй тулж ажиллах мэдээж бэрх. Хөгшчүүлийг асрах нь их хайр халамж, сэтгэлийн тэнхээ шаардсан ажил ч Оннаны хувьд тэднийг инээмсэглүүлэх нь юутай ч зүйрлэшгүй баяр. Гурван хүүхдийн ээж тэрбээр ажил, хувийн амьдралаа зохицуулахад цагаа зөв хуваарилах нь хамгийн чухал гэж үздэг.

Өөр нэг жишээ дурдахад, “Дойче банк”-ны хоёр мянган ажилтан байгаль орчны нийгэмлэгтэй хамтарч, 33 мянган мод суулгасан зэрэг олон сайн дурын ажлыг дурдаж болно. Компаниуд бол нийгмийн салшгүй нэгээхэн хэсэг ►►

- ▶ нь юм. Тийм ч учраас тус банк “Нийгэмд хөрөнгө оруулах нь мөнгөнөөс илүү” уриатай ажилладаг.

## Технологи- Сийменс

КНХ-ын аяллын эцсийн зогсоол нь Баварийн нийслэл Мюнхен хот дахь “Сийменс”-ийн төв оффис. Дэлхийн 190 оронд үйл ажиллагаа явуулдаг тус компани нь 405 мянган ажилтантай. Анх 1847 онд Вернер фон Сийменс, Йохан Георг Хальске нарын үүсгэн байгуулсан телеграфын компани эдүгээ үндэстэн дамнасан өндөр-технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болжээ.

Дэлхийн аль ч оронд хотжилт, уур амьсгалын өөрчлөлт, хүн амын насжилт, даяаршил нь хамаатай. НҮБ-ын тооцолсноор ирэх 2050 онд нийт хүн амын бараг 70 хувь хот суурин газар амьдрах ажээ. Энэ нь ихэнх хүн дотоод дэд бүтцийн хүртээмж хүрэлцэхгүй болсон том хотуудад суурьшихыг өгүүлж байна. Тухайлбал, манай урд хөршид гэхэд 2025 онд 200 хот нь нэг сая хүн амтай болох төлөвтэй. Ийм үед байгаль орчинд ээлтэй, дулаан, цахилгааны хангамж, эрүүл мэндийн үйлчилгээ улам их ач холбогдолтой болно. Нийгэмд тулгарах эдгээр асуудлыг технологи, ноу-хау ашиглан шийдэхээр ажиллаж байгаа олон байгууллагын нэг нь “Сийменс” компани.

### Компанийн хариуцлага:

“Сийменс” компани шинэчлэлт технологи, шийдэл ашиглан 160 жилийн турш тогтвортой байдлын зарчмыг өнөөг хүртэл баримталсаар иржээ. Компанийн хариуцлагын гол зорилт нь хүн, эх дэлхий, ашиг гурвыг тэнцвэржүүлэх. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ дамжуулан хүн амын насжилт, хотжилт, уур амьсгалын өөрчлөлт, даяаршил гэхчилэн нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулж байгаа тус компанийн нийгмийн хариуцлагын бодлого байгаль хамгаалал, боловсрол шинжлэх ухаан, соёл урлаг, хүмүүнлэгийн тусламжийн чиглэлүүд дээр төвлөрдөг. Өнгөрсөн онд тус компанийн бүтээгдэхүүнийг хэрэглэснээр үйлчлүүлэгчид 317 сая тонн хүчилтөрөгчийн давхар исэл ялгаруулалтыг хэмнэсэн байна. Энэ нь эрчим хүчнээс үүдэн гарах дэлхийн нийт хүчилтөрөгчийн ялгарлын нэг хувьтай тэнцэх үзүүлэлт аж. Тус компанийн нийгмийн хариуцлагын олон төрлийн үйл ажиллагааных нь зарим сонирхолтой хөтөлбөрөөс дурдъя.

### Сургуульд зориулсан ногоон мэдээ

“Siemens I—Green Education” хөтөлбөрөөр Хятадын найман хотын 10 сургуулийн цагаач ажилчдын хүүхдүүдэд байгаль орчны хамгааллын мэдлэг олгодог байна. Компанийн ажилчид гурван долоо хоног тутам сайн дураараа чөлөөт цагаараа хүүхдүүдэд хичээл заадаг. Эдгээр сургуульд эрчим хүч хэмнэдэг гэрэл чийдэн, бусад тоног төхөөрөмжийг ч мөн өгчээ. Сүүлийн 2.5 жилийн турш уг хөтөлбөр маш амжилттай хэрэгжсэн учир компанийн ажилчид бусад байгууллагыг ч ийм байдлаар ажиллахыг уриалсан байна.

### Гаднаас автобус, дотроо эмнэлэг

Ядуу болон орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн

үзлэгт хамрагдах хүндрэлтэй байдаг. Тэгвэл Энэтхэгийн хойд болон зүүн бүсийн иргэдэд зориулж “Сийменс” компани нийгмийн хариуцлагын стратегийн хүрээндээ эмнэлгийн үйлчилгээг өвөрмөц хэлбэрээр хүргэдэг ажээ. Гаднаас нь харахад автобус, дотроо харин рентген, ЭХО, зүрхний бичлэгийн болон оношлогооны бусад тоног төхөөрөмж агуулсан иж бүрэн эмнэлгийг ажиллуулдаг ажээ. Энэтхэгийн хойд хэсэгт байрлах зөөврийн эмнэлэг нь “Medanta” эмнэлэгтэй, зүүн хэсгийнх нь “Smile” нийгэмлэгтэй хамтарч ажилладаг. Автобусны хойд хэсэгт дүрс оношилгооны зургийг угаах харанхуй өрөөтэйгээс гадна зөөврийн эмнэлэг эрчим хүчээ өөрөө гаргаж авдаг генератортай гэнэ.

### Техникийн гайхамшиг

“Сийменс”-ийн КНХ-ын мэргэжилтэн Маркус Штрангмюллер “Тогтвортой байдлын сэдэв хэзээ ч зогсохгүй” гэсэн юм.

Тухайлбал, тус компани “Siemens Water Technologies” ашигласан усыг нам даралтаар ундны ус болгодог “СкайХидрант” шүүгч машиныг зохиожээ. Хэт-нарийн шүүлтүүрийн хүчээр хэрэглэсэн усны бохирдлыг нарийвчлан шүүдэг байна. “СкайХидрант” өдөрт 10 мянган литр ус цэвэршүүлдэг бөгөөд ердөө 1.5 метр урт, 12 кг жинтэй эд. Химийн бодис ордоггүй, эрчим хүч бага хэрэглэдэг энэхүү машиныг угсарч ажиллуулахад маш хялбар. Өнөөдөр дэлхийн 42 оронд 900-гаад ийм машин ундны ус гаргаж байна. Бангладеш, Хаити, Энэтхэг, Камбожийн ядуусын дунд ихээхэн эрэлт хэрэгцээтэй эд гэнэ. “Сийменс” энэхүү машинаа улам боловсронгуй болгож “АкуаВендор” нэртэй загварыг бүтээжээ. Өмнөх машинтай ижил үүрэгтэй шинэ загварын машины бүх үйлдэл нь автомат. Хяналтын систем шүүж цэвэршүүлэх, удирдах бүх үүргийг гүйцэтгэж өдөрт 25 мянган литр ус гаргаж авах хүчин чадалтай гэнэ.

Германы компаниуд ийнхүү өргөн цар хүрээтэй хариуцлагын үйл ажиллагаа явуулж байна. Хамгийн сонирхолтой нь ажилчид сайн дураараа нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулж байгаа нь сайшаалтай санагдсан. Гэхдээ зөвхөн компаниуд бус иргэд бид өөрсдөө байгаль орчиндоо ээлтэй амьдарч, нийгэмд сайн үйлс дэлгэрүүлэхэд сайн дураараа оролцох боломжтой билээ. Дэлхийн иргэний үүргээ ухамсарлаж ажиллацгаая. ■



Ундны ус гаргагч “СкайХидрант” машин

Үргэлжлэл бий



## НОМИНГИЙН ТӨРСӨН ӨДӨРТ ЗОЧИЛСОН НЬ

“Номин Холдинг-20” өнгө өнгийн лаа бүхий төрсөн өдрийн амтат бялуу, тэнгэрт цацрах салют энэ бүхэн есөн эрдэнийн нэгээр овоглодог энэ өнөр айлын өнгөрсөн түүхийг илтгэж, ирэх 20 жилийн ирээдүйг тодорхойлох ажгуу.

### Б.МЭРГЭН

Наран наадаж, хур ивээсэн Монгол нутгийн зуны өглөө тив дамнан аялах тэнгэрийн хөлгийг алсаас харуулдан зогсоно. Гадаад, дотоодын айлчин, гийчин олноороо холхих зуны саруудад “Чингис хаан” нисэх онгоцны буудал тун ч завгүй байх ажээ. Бидний хүлээсэн онгоц газарджээ. Зургаан тивийн долоон тэрбум иргэнийг эгнээндээ элсүүлсэн дэлхийд алдартай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 11 орны 60 гаруй төлөөлөгч хүрэлцэн ирлээ. Ази, Европ, Америкийн 400 гаруй компанитай түншилж, дэлхийн брэндүүдийг нэг дор цуглуулж чадсан Монголын ууган компаниудын нэг “Номин Холдинг” Монголын зах зээлд мэндлээд даруй 20 жилийг ардаа үджээ. Номинчууд өнөөдөр алд цэнхэр хадаг, мөнгөн аягатай сүү өргөн барих монгол уламжлалаар ахан дүүсийн барилдлагатай “гэр бүл”-ийн гишүүдээ ийн угтан золгов.

“Номин Холдинг” энэ онд 20 жилийн ойн баяраа тохиолдуулан хамтран ажиллагсад, ажилчид болон дотоод, гадаадын түншүүдээ хамруулан бүтэн жилийн арга хэмжээ зохион байгуулжээ. Оны эхэнд хэрэглэгчдэдээ зориулж нийт 8438 хүн азтан болох хоёр тэрбум төгрөгийн шагналын сантай сугалаат худалдааг зарласан бол энэ удаад хамтран ажилладаг гадаадын түншүүдээ Монголд урьж, төрсөн

өдрийн лаагаа хамтдаа үлээхээр шийджээ. Номингийнхон Монгол түмний зочломтгой зангаар холын зочдоо хүндлэн угтаж, газар орноо гайхуулан таниулахаар дөрвөн өдрийн хөтөлбөр бэлтгэсэн байлаа. Уг хөтөлбөрөөр зочид Үндэсний баяр наадам, компанийн тусгайлан зохион байгуулах аялалд оролцохоос гадна Чингисийн морьт хөшөө, XIII зуун цогцолбор газарт зочлох ажээ.

### 10 жилд ганц тохиох цугларалт

Улаанбаатар хотын төв цэг Сүх жанжны талбайд номинчууд, итгэлт түншүүдтэйгээ гэр бүлийн зураг татуулахаар иржээ. Технологийн гайхамшгийг мэдрүүлэгч Sony, Sharp, Hitachi, гоо сайхны охин тэнгэр L’Oreal, хурд хүчний эзэн Chevrolet, идээ ундааны тансаг Любимый Сад, Маккофе тэргүүтэй дэлхийд нэр сүрээ цайз мэт өндөрт бэхжүүлж чадсан брэндүүд тэр дундаа, тэднийг амжилтад хөтөлсөн менежер, захирлууд нь нэг дор цуглажээ.

“Номин Холдинг”-той гар барилцан түншлээд жил гаруй хугацаа болж байгаа гэр ахуйн хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ алдартай “ОКТ” компанийн худалдааны ▶

► менежер Винченцо Маре “Номин хэмээх брэнд нэрэндээ бус энэ компанийн төлөө ажиллаж байгаа хүмүүсийн чин хүсэл, сэтгэл надад биширмээр санагддаг. Сайн багийн ажиллагаа тэдний онцлог гэж би боддог” хэмээн сэтгэгдлээсээ хуваалцсан юм.

“Инээгээрэй авлаа шүү” гэх зурагчны тушаалаар Чингис хааны сүрлэг хөшөөний өмнө зогсоо хүн бүрийн нүүрэнд инээмсэглэл тодорно.

## “Хөх тэнгэр”-ийн номин цэнхэр үдэш

“Тавтай морил зочид оо”. Энэ үдэш “Хөх тэнгэр” цамхагийн хүлээн авалтын танхим танан цагаан, номин цэнхэр өнгөөр гоёжээ. “Номин Холдинг” үүсгэн байгуулагч Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан А.Шагдарсүрэн ойн хүндэтгэлийн арга хэмжээг нээж “1992 оны долоодугаар сарын 11-нд буюу 20 жилийн өмнөх энэ өдөр бид “НОМИН-5” ХЭАА нэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлж билээ. Харин өдгөө манай компани худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, барилга, санхүү, даатгалын гэх мэт бизнесийн төрлүүдээр 4000 гаруй ажилтантай, зах зээлд тэргүүлэгч 23 салбар нэгжтэй бол эргөжсөн байна” хэмээн компанийнхаа үүх түүх, ололт амжилтыг үргэлжлүүлэн ярьж, нийт хамт олондоо 20 жилийн ойн баярын мэнд дэвшүүлсэн.

Монголд ардчилсан нийгэм байгуулагдах, чөлөөт эдийн засагт шилжих тэрхүү түүхэн үеэс бизнесийн гараагаа эхлүүлж, өдгөө 20 насны баяраа ийн өргөн хүрээнд тэмдэглэж байгаа номинчуудыг хараад өнөөдрийн түвшинд хүрэхэд ямар их хөдөлмөр, сэтгэлийн хүч зарцуулсан бол хэмээн бодож суулаа. Энэхэн агшинд номинчуудын сүлд “Номин эрдэнийн орон” дууг Ардын жүжигчин А.Долгор, Гавьяат жүжигчин Б.Дашдондог нар дуулж байх зуур газар газраас ирсэн зочид, төлөөлөгчид бие биетэйгээ танилцаж, хол ойрын сонин сайхнаа хуваалцаж яриа өрнүүлсэн юм. Лореал /L'OREAL/ брэндийг өнөөдөр мэдэхгүй хүн тэр дундаа эмэгтэй хүн ховор биз ээ. Тэгвэл “Номин Холдинг”-той хоёр жил гаруй хугацаанд хамтран ажиллаж буй тус компанийн Казахстан дахь салбарын экспорт хариуцсан менежер Бенжамин Рачов хэлэхдээ,

“Лореал үргэлж мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг, зах зээлээ мэдэрч чадах чадвартай, шилдэг хамтрагч сонгодог. Тиймдээ ч Номинг сонгосон” гэв.

“Номин Холдинг”-ийн төрсөн өдөр Улсын баяр наадамтай давхцсан болохоор илүү сүрлэг, зочдын хувьд үзэж харах, сонирхох их юмтай байлаа. Тэдний хувьд өмнө нь ажил төрлөөр Улаанбаатар хотноо ирээд л явдаг байсан бол өнөөдөр дэлхийд ганцхан Монголын эрийн гурван наадмыг тухлан үзсэн. Өөрөөр хэлбэл, дэлхийд алдартай брэндүүдийн мэргэжилтнүүдийн сэтгэлд Монгол наадам хэмээх брэнд хоногшин үлдэж чадсан гэж би баттай хэлнэ. Бөхийн барилдаан, сур харваа, хурдан морины уралдаан гайхалтай биш гэж үү. Дээр нь монголчуудын үндэсний хувцас тэднийг гайхшруулж байсан юм. Соёолонгийн тоосонд хийморио сэргээсэн зочдын сэтгэл ихэд хөдөлж, тэргүүний морь барианд орох тэрхэн торгон агшинд заримынх нь нүдэнд нулимс цийлэгнэх нь эгээ л монгол хүмүүс гэлтэй.

## Төрсөн өдрийн мэнд хүргэе!

Номинчууд 20 насны босгон дээрээ ямархуу өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага болсноо зочдод бодит байдлаар танилцуулж байсан юм. Тухайлбал, “Номин Холдинг”, General Motors компанийн түншлэлийн үр дүн болсон хурд хүчний гайхамшиг Chevrolet тэргүүтэй төмөр хүлгүүдээр зочдодоо үйлчилсэн нь аргагүй л сүр хүчийг үзүүлэх шиг.

Тус компанийн ойн баярын хүлээн авалт Нүхт дэх “Номин Тэнгэр” цогцолборт болсон. Энэхүү арга хэмжээнд гадаадын зочдоос гадна хамтран ажилладаг бүхий л байгууллагын төлөөлөгчид оролцож, “Номин Холдинг”-ийн баяраас хуваалцсан юм. Компанийн ерөнхий захирал Ш.Баярсайхан “20 жил гэдэг нийгмийн хөгжлийн хувьд ахархан хугацаа ч номинчууд бидний төдийгүй Монгол Улсын хувьд их үйл явдал, хөгжил дэвшлийн он жилүүд байлаа. Өнгөрсөн хугацаанд хийж бүтээсэн, бизнесийн зарчмууд болон ирээдүйн хүсэл тэмүүллээ нэгтгээд харахад харилцагч, хэрэглэгч бүхэн маань ямагт компанийн маань төв нь байсаар иржээ” хэмээсэн юм.

Монгол Улсын бизнесийн нүүр царай болдог үндэсний олон компани бий, манайд. Тэдний нэг тус компанийн бүтээгдэхүүнүүдийг бид өдөр тутам хэрэглэж, амьдралын амтыг мэдэрсээр хамтдаа 20 жилийг үджээ.

“Sony Electronics” компанийн ерөнхий захирал Тайсүкэ Наканаши “Монгол түншдээ ойн баярын мэнд хүргэж ирэх 30, 50 жилдээ улам их амжилт бүтээл гаргаарай” хэмээн хүслээ.

“Номин Холдинг-20” өнгө өнгийн лаа бүхий төрсөн өдрийн амтат бялуу, тэнгэрт цацрах өнгө өнгийн салют энэ бүхэн есөн эрдэнийн нэгээр овоглодог энэ том айлын өнгөрсөн түүхийг илтгэж, ирэх 20 жилийн ирээдүйг тодорхойлох ажгуу.

## Таны төлөө 20 жил

Давхардсан тоогоор сардаа сая гаруй худалдан авагч бараа, бүтээгдэхүүнээ хүргэдэг “Номин Холдинг” компанийн салбарууд өдөр ирэх тусам өнгө нэмж, өргөжин тэлж байна. Зочид Номин Логистик, Номин Моторсын үзэсгэлэнгийн танхим, Өнөр Хайпермаркет, Улсын Их Дэлгүүр, Хан-Уул дүүрэгт байрлах Номин агуулах худалдаатай танилцсан юм. Энэ үеэр компанийн удирдлагууд Номин агуулах худалдааны газраа дүүргийн хэрэглэгчдийн цаг мөнгийг хэмнэсэн нэг цэгийн үйлчилгээ бүхий газар болгох чиглэлд нэлээд их ажил хийжээ. Саруул танхим, хөгжим, хямд үнэ, дэлхийн брэндүүд цөм бүрдсэн энэ төв өнгөрсөн оны долоодугаар сард үүд хаалгаа нээсэн аж. Хөтчийн хэлснээр энэ дэлгүүрт 10000 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн байгаа гэнэ. Гаднаа автомашины том зогсоолтой. Тус дэлгүүрээр үйлчлүүлэгчид олон үндэстний зоог барьж, автомашинаа оношлуулах зэрэг бусад төрлийн үйлчилгээ ч авах боломжийг бүрдүүлж хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхлыг нэг дор цогцлоон бүтээхийг эрмэлзсэн нь илт. Номингийн төрсөн өдөрт ирсэн гаднын зочид олон зуун жилийн түүхтэй, дэлхийд үлгэр жишээ компани, пүүсийн ►

► төлөөлөл ч 20 жилийн туршлагатай түншээсээ сурах зүйл олон байна хэмээн ярилцаж явсан юм.

## Миний эх орон Номин эрдэнэ билээ

Номингийн гадаад зочдын эцсийн зогсоол Чингисийн морьт хөшөө буюу XIII зууны үеийн Монголын эзэнт гүрний төрхийг харуулсан байгууламж болой. Дэлхийд нэр цугаа түгээсэн Чингис хааны отгоор зочлох, танилцах, бодитоор харах боломж тохиосонд зочид гийчид их л баяртай байв. Тэд зураг авахуулж, бичлэг хийж, хөгжилдөнө. Эх нутагтаа очоод ярих, сонирхуулах олон дурсамжтай болсон биз ээ.

“Номин Холдинг”-той 1998 оноос хойш хамтран ажиллаж байгаа гэр ахуйн электрон барааны “Sharp Roxy Sales” компанийн ерөнхий захирал Хидэки Тай Монголд өвөл анх ирж байсан гэнэ. Тэрбээр “Би байгальд их хайртай хүн. Тиймдээ ч Монголд ирэх дуртай. Монгол бусад орноос нэг л өөр” хэмээн XIII зуун цогцолборын Малчны отогт зочлох үедээ ярьсан бол “Номин Фейшн”-ийн хувцас загвар хариуцсан зөвлөх Ролф Штульман “Өнгөрсөн өдрүүдэд үзэж харсан бүхэнд сэтгэл их хөдөллөө. Номингийн хамт

олонд ойн баярын мэнд хүргэхийн ялдамд талархаж байгаагаа илэрхийлье” гэв. Харин өнөөдөр 100 жилийн ойтойгоо золгож буй “Sharp” компанийн төлөөлөгч “Номин электрон бараа, бүтээгдэхүүний зах зээлд багагүй туршлага хуримтлуулсан сайн хамтрагч. Тиймээс ч бид цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэн хамтдаа олон жилийн ойн баярыг хамтдаа тэмдэглэх болно” гэсэн билээ.

Бизнесийн гол зарчмуудын нэг нь түншээ дээдлэн хамтын ажиллагаандаа үнэнч байх гэдэг. “Номин Холдинг” энэ л зармын хүрээнд ойн баяраараа гадаадын түншүүддээ хүндлэл үзүүлж, хамтын ажиллагаагаа улам батжуулахыг ийн зорьсон юм. Үнэхээрийн гадаад сайн хамтын ажиллагааны үр дүнд номинчууд дэлхийн брэнд болсон электрон бараа, машин, хувцас, болон хүнсний зүйлсийг хэрэглэгч бидэнд хүргэдэг ажээ.

Дэлхийн брэндүүдийг Монголын номин хөх тэнгэр дор нэгтгэж чадсан энэ их айлын ирээдүй дэх хамтын ажиллагаа өргөжиж, Монгол Улсын хөгжил дэвшилд оруулах хувь нэмэр тэр хэмжээнд өсөн нэмэгдэх өлзийтэй ерөөлөөр “Номин Холдинг”-ийн төрсөн өдөрт зочилсон тэмдэглэлээ өндөрлөе. ■

**KHATAN TUUL**  
*Pure Water*

Packaging quantity of Pure water:  
0.35 L /bottled/  
0.6 L /bottled/  
1 L /bottled/  
19 L /ballon/

**Маркетинг: 99071655**  
**Захиалга авах утас: 70173386**  
**Факс: 976-11-70174494**

Produced and bottled by "Welmon Trade" Co., Ltd of Mongolia

## УУРХАЙЧДЫН УУШГИЙГ ХЭН АВРАХ ВЭ

Уурхайд ажиллагсдын орчин, хамгаалах хувцас, эрүүл мэндэд онцгойлон анхаарахгүй бол таван жилийн дараа гэхэд одоо ажиллаж байгаа 30-35 насны залуучууд ямар нэг өвчтэй болж, асаргаанд орох, амь насаа алдах аюулд ороод буйг хэлэх нь зүйтэй.

Х.БӨРТЭ

Манай улсад жилд дунджаар 4500 орчим хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгддэг. Жилд 3000 гаруй хүн хорт хавдрын улмаас амиа алдаж байгаа харамсалтай тоо баримт байна. Өөрөөр хэлбэл, Монголд өдөрт найман хүн хорт хавдрын улмаас хорвоог орхиж байна гэсэн үг юм. Хүн амын дундах нас баралтын шалтгааны хоёрдугаарт мөн л хорт хавдар орж байна. Хавдрын улмаас жилд амиа алдаж буй 3000 гаруй иргэний 40 орчим хувь нь уул уурхайд ажиллагсад байдаг аж. Уул уурхай Монголчуудыг тэжээж буй гол салбар ч уурхайчид хамгийн хорттой нөхцөлд ажилладаг гэдэгтэй эмч нар санал нэг байна.

Энэ талаар Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын үндэсний төвийн дарга Д.Атараатай ярилцлаа.

### Уурхайчдын ажлын нөлөөллийн судалгааг хийдэг болох хэрэгтэй

-Хортой, хоргүй хавдар дэлхий дээрх аюултай өвчлөлийн хоёрдугаарт бичигдэж байна. Харин манайд энэ өвчнөөр өвчилж, амиа алдагсдын нэгдүгээрт уул уурхайд ажиллагсад орж байгаа гэх. Манайд хавдартай эсэхийг оношлох, эмчлэх байдал ямар хэмжээнд байдаг юм бол?

-ДОХ, Сүрьеэ зэрэг өвчин амь насанд хамгийн аюултай өвчлөлүүд



байсан бол сүүлийн арван жилд хавдар голлох боллоо. Жилд зөвхөн хавдар өвчний улмаас манай улсад 3000, дэлхийд 10 сая хүн амиа алддаг харамсалтай тоо байна. Үнэхээр уул уурхай, химийн хорттой нөхцөлд ажиллаж байгаа олон зуун хүн хавдар өвчний улмаас амиа алдаж байна.

Хамгийн чухал нь эрт оношлуулах, эмчилгээ хийх юм шүү дээ. Гэтэл хүмүүс хавдраа III, IV шатанд орсон хойно нь эмчид хандаж, баахан эм тариа гэнэт хийгээд эхэлдэг. Гэвч оройтсон байх нь олон. Оношлогооны хувьд маш сайжирсан. Хамгийн гол нь иргэд өөрийнхөө төлөө эмнэлэгт үзүүлж, оношлогоонд орох цаг зав гаргадаг байх хэрэгтэй.

**-Сүүлийн жилүүдэд мэргэжлээс**

**шалтгаалах өвчлөл нэмэгдэж байгаа гэсэн дүн байна. Ямар өвчлөл зонхилж байна вэ?**

-Мэргэжлээс шалтгаалсан өвчин нь хөдөлмөрийн орчны сөрөг нөлөөллөөс үүсч байгаа юм. Монгол Улсад 40 жилийн өмнөөс энэ төрлийн өвчнийг тогтоож эхэлсэн. Нийт 8877 хүн мэргэжлээс шалтгаалсан өвчин туссан гэж бүртгэгдсэн. Нийт тохиолдлын 60 гаруй хувийг уул уурхайн салбарт ажиллагсад эзэлж байна. Тэр дундаа Өнгөтийн уурхайн алт, жоншоос үүдэлтэй өвчин өндөр тохиолдож байгаа юм. Дараа нь барилга, зам тээвэр, эрчим хүчний салбарт ажиллагсад мэргэжлээс шалтгаалах өвчнөөр түлхүү өвчилж байна. Илэрсэн өвчлөлүүдээс тоос-»

ны шалтгаант амьсгалын замын өвчин, мэдрэл, гэмтэл, хордлогоос шалтгаалсан өвчлөл, харшил эхний байруудыг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд химийн бодисын хэрэглээ өссөнтэй холбоотой өвчнүүд ихэсч байна.

**-Уул уурхайд ажиллагсад хавдраас гадна ямар өвчнөөр өвчилдөг вэ. Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?**

-Уурхайд ажиллагсдын 70-95 хувьд нь уушги тоосжих, хараа муудах, уушигны хавдар, уушигны сүрьеэ зэрэг өвчлөл илэрдэг. Нүүрс олборлох явцад тоос тоосонцор агаарт хамгийн удаан хугацаанд хөвдөг ба энэхүү тоосонцроор уурхайчид байнга амьсгалж байдаг. Ийнхүү жижиг ширхэглэлтэй тоос тоосонцор уушигны нарийн гуурс болон цөвдөлд хуримтлагдан, цаашид уушигны эд эстэй биологи, өвчлөлийн хувиралд орж, уушигны тодорхой хэсгийг чулуужуулдаг. Ийнхүү чулуужих процесс өргөжин тодорхой түвшинд хүрээд амьсгалын замын бэрхшээлтэй болдог бөгөөд үүнийг анагаах ухаанд уурхайчдын тоосны өвчин гэдэг.

Уурхайд ажиллагсдын орчин, хамгаалах хувцас, эрүүл мэндэд онцгойлон анхаарахгүй бол таван жилийн дараа гэхэд одоо ажиллаж байгаа 30-35 насны залуучууд ямар нэг өвчтэй болж, асаргаанд орох, амь насаа алдах аюулд ороод буйг хэлэх нь зүйтэй. Бидэнд ийм нэг судалгаа байна. Уурхайд ажиллагсдын өвчлөлийн хувийг өнгөрсөн оны байдлаар гаргасан байна. (Графикаас харна уу)

|                                 |       |
|---------------------------------|-------|
| Уушигны гадны шалтгаант өвчин   | 61,6, |
| Мэдрэлийн өвчин                 | 15,7, |
| Төрөл бүрийн бодисын хордлого   | 8,0,  |
| Яс булчингийн тогтолцооны өвчин | 5,8,  |
| Цусны эргэлтийн системийн өвчин | 4,0,  |

-Бусад өвчин 4.9 хувийг тус тус эзэлсэн байх юм. Энэ бол уул уурхайн салбарын ажилчдын эрүүл мэндэд

анхаарах цаг болсны гэрч. Уурхайд ажиллагсдын хувьд хамгийн чухал хамгаалалт бол амны хаалт.

**-Ер нь хавдрын өвчлөлийн шалтгаан, нөлөөлөл нь юу байна вэ?**

-Хавдрын өвчний шалтгааныг дэлхийн аль ч улс оронд тогтоож чадаагүй. Хэрэв тогтоосон бол дэлхий даяараа хэдэн мянгаар нас барж байгаа тоог багасгаж чадах байсан биз. Гэхдээ нөлөөлж буй хүчин зүйлд агаарын бохирдол, хэрэглэж буй хүнсний бүтээгдэхүүн, химийн хорт бодис гээд нөлөөлөх хүчин зүйл олон. Хамгийн наад зах нь хөгцөрсөн, мөөгөнцөртэй бүтээгдэхүүнийг иргэд хэрэглэдэг. Хавдар юунаас болж үүсдгийг дэлхийн олон орны эрдэмтэд судалсаар л байна.

**-Өнөөдрийн байдлаар манай улсад яг хэчнээн хүн уурхайд ажиллаж байгаад ийм төрлийн өвчинтэй болж, хавдрын улмаас нас бараад байна вэ?**

-2011 оны байдлаар 5000 гаруй хүн уурхайн гаралтай уушигны хавдартай гэж оношлогдоод байна. Гэхдээ үүний цаана эмнэлэгт үзүүлээгүй хэчнээн хүн байгааг бид хэлж мэдэхгүй. Нас баралт манайд бүртгэгддэггүй учраас хэлж мэдэхгүй байна. Налайх, Шивээ хүрэн гээд нүүрсний уурхайгаас гадна жонш, цементэн дээр ажилладаг хүмүүс ч уушигны хорт хавдар, тоосжилтын өвчин тусна шүү дээ.

**-Манай эмч, мэргэжилтнүүдийн илрүүлж чадаагүй ямар өвчин байна вэ. Сүүлийн жилүүдэд шинээр илэрч байгаа өвчин бий юу?**

-Мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг оношлоход манай улсын эмч нар өнгөрсөн хугацаанд ямар ч гарын авлага, чиглэл болсон шийдвэргүйгээр өнөөдрийг хүрсэн. Харин энэ сард “Зонхилон тохиолдох мэргэжлээс шалтгаалах өвчин, эмгэгүүдийн оношлогоо, эмчилгээний удирдамж”-ийг баталлаа. Энэ удирдамж батлагдсанаар эмч мэргэжилтнийн мэдлэг дээшлэх, олон улсын түвшинд оношлогоог нийцүүлэх зэрэг ач холбогдолтой юм. Манай улсад нэг ч бүртгэгдээгүй

өвчин бол асбест. Энэ нь шөрмөсөн чулуу буюу асбестын бодисын хэрэглээтэй холбоотой. Уг бодисыг манай барилгын компаниуд хэрэглэдэг. Бид ДЭМБ, ЭМЯ, ЭМШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн тэнхимийн эрхлэгч доктор н.Оюунтогостой хамтарч асбест суурь судалгааг хийж байна.

Шөрмөсөн чулуу буюу асбест нь барилгын салбарт хэрэглэдэг гипсэн хавтан ашиглах, барилгыг нураах, дулааны цахилгаан станц, дулааны шугам сүлжээг шавж хэрэглэдэг бүтээгдэхүүнээс ялгардаг тоосонцор юм.

**-Уурхайд ажиллагсдын эрүүл мэндэд гаднын орнууд хэрхэн анхаарал хандуулдаг юм бол?**

-Уул уурхайн гэрээ хэлэлцээрийг бүх байгууллагаас төлөөлөл оролцуулж хийх ёстой. Гэтэл манайд Эрүүл мэндийн яамны мэргэжилтнүүдийг энэхүү гэрээ, хэлэлцээрт оролцуулдаггүй. Сангийн яам, БОАЖЯ, ЭБЭХЯ-ны төлөөлөл гарын үсэг зураад л ажлыг эхлүүлсэн байдаг. Гаднын орнууд маш өндөр түвшинд анхаарал хандуулдаг. Ялангуяа уул уурхай хөгжсөн орнуудад ажилчдынхаа эрүүл мэндийн нөлөөллийн байдлын судалгааг хийж үнэлж, түүнийхээ дагуу эмчилж, эрүүл мэндэд нь ихэд анхаардаг.

**-Уул уурхайн эрүүл мэндэд нөлөөлөх байдлын судалгааны үнэлгээ манай улсад бий юу?**

-Өнгөрсөн жил анх удаа “Оюутолгой” компани эрүүл мэндийн нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн. Энэ нь манайд жишиг болж буй сайн хэрэг. Бусад уул уурхайн компани энэ үнэлгээг зайлшгүй хийдэг болох ёстой. Энэ нь уурхайчдын эрүүл мэндийг хамгаалах хамгийн чухал арга хэмжээ юм.

**-Хөдөлмөрийн нөхцөл, Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын төвд жилд хэдэн хүн үйлчлүүлдэг вэ?**

-2009 онд 30 орчим мянган хүн байсан бол одоо жилд 110 гаруй мянган хүнд үйлчилгээ үзүүлж байна. ■

# ЧУУЛГАН, ҮЗЭСГЭЛЭН

## Герман – Монголын бизнесийн өдрүүд 2012 харилцаа тогтооё, харилцан суралцъя, хамтдаа хөгжъе!

**Нэг дэх өдөр: Технологийн шинэчлэл**  
Үйлдвэрлэлийг дэвшилтэт аргаар шинэчлэх нь.  
(хүнс, сүү боловсруулах, нэхмэл даавуун эдлэл болон эрчим хүчний үйлдвэрлэл)

**Хоёр дахь өдөр: Нийлүүлэлтийн сүлжээний менежмент**  
Өсөж буй зах зээлийн эрэлт хэрэгцээг оновчтой нийлүүлэх нь.  
(худалдан авалт, агуулах ба нөөцийн менежмент, нийлүүлэлт)

**Гурав дахь өдөр: Бизнесийн менежмент**  
Өөрчлөгдөн хөгжиж буй Монгол Улсын хөрсөн дээр  
буулгасан менежмент.  
(чанарын удирдлага, хүний нөөц, нийгмийн хариуцлага)

## Blue Sky Зочид буудал & Цамхаг, Улаанбаатар, Монгол улс 2012 оны 10 сарын 22-24

Энэхүү арга хэмжээнд оролцсоноор Таньд бизнесийн шинэ түнштэй болох, мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэх, өөрийн бизнесийн ирээдүйг баталгаажуулах боломж нээгдэнэ.

**Зохион байгуулагч:** Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн “Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага” Хөтөлбөр

**giz** Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH



**Мэдээллийн  
ИВЭЭН ТЭТГЭГЧ:**



**Холбоо барих:**

Утас +976 7011 7704  
Емайл imri@giz.de  
Вэб www.giz.de  
www.imri-mn.com

---

## Үндэсний Компанийн Нийгмийн Хариуцлагын форум 2012 оны 10 дугаар сарын 24, Blue Sky Зочид буудал & Цамхаг,

Холбоо барих: ГОУХАН-ийн  
ЭТИС Хөтөлбөр  
Утас +976 7011 7704  
Емайл imri@giz.de  
Вэб www.giz.de  
www.imri-mn.com

